



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО



МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН

САЛБАР АЛМАНАХ 2017



МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАР

АЛМАНАХ 2017



DCAF
a centre for security,
development and
the rule of law

АНУРУГ
Publishing



DCAF

a centre for security,
development and
the rule of law

Энэхүү номыг хэвлэн гаргахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төвийн удирдлага, хамт олонд гүн талархал илэрхийлье.

МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАР

АЛМАНАХ 2017

Улаанбаатар хот
2017 он

ДАА - 80

ННА - 93

Б - 331

МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАР
АЛМАНАХ 2017

Зохиогчдын баг: Ш.Хишигсүрэн
Б.Мэргэн
Т.Наранхүү
Ж.Баярцэцэг
Б.Алтанхүү
Ж.Мөнхболд
Б.Пүрэв
П.Цэцгээ
П.Оюунчимэг
Б.Индра

Эрхлэн гаргагч: “Ауруг Паблишинг” ХХК

Редактор: М.Батчимэг

Хэвлэлийн хуудас: 14.5 х.х

© Энэхүү номын зохиогчийн эрх Улаанбаатар Бодлогын Судалгааны
Төвд хамаарна. Бүх эрх хамгаалагдсан.



Олимпийн гудамж 9/7
Улаанбаатар, Монгол Улс
Утас: 976-77040262
И-мэйл: info@aurug.mn
Цахим хаяг: www.aurug.mn

ISBN: 978-99978-806-0-4

ӨМНӨХ ҮГ



Эрхэм хүндэт уншигчид аа,

Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, “Улаанбаатар бодлогын судалгааны төв” төрийн бус судалгааны байгууллагатай хамтран “Монгол Улсын Аюулгүй байдлын салбар - Алманах 2017” нэр бүхий эрдэм шинжилгээний, өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэлийг бэлтгэн гаргаж байна.

“Монгол Улсын Үндсэн хууль”-ийн Арван нэгдүгээр зүйлд Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг болохыг заасан бөгөөд Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн энэхүү үзэл санааг хэрэгжүүлэх үүднээс цөөнгүй тооны хууль тогтоомжийг батлан гаргасан билээ.

Үүний зэрэгцээ, Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль батлагдан гарсанаас хойших 26 жилийн хугацаанд бидний туулж ирсэн амаргүй замдаа хуримтлуулсан туршлага, өнөөдөр олон улсад болон дотоодод үүсээд байгаа зарим талаасаа мухардмал гэж хэлж болохоор шинэ нөхцөл байдал нь эдгээр хууль, тогтоомжийг эргэн харах, цаашид боловсронгуй болгохыг зүй ёсоор шаардах боллоо.

Ийм нөхцөлд үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогынхоо залгамж чанарыг хадгалан, цаг ямагт төгөлдөршүүлэх, түүнд нөлөөлж буй олон талт хүчин зүйлсийг тогтмол тандан судалж, дүн шинжилгээ хийх, энэ үндсэн дээр болзошгүй эрсдэл, сорилт, аюул, заналыг урьдчилан харж, тэдгээрийг даван туулах зорилго бүхий судалгаа, шинжилгээний ажлыг байнга явуулж байх нь ихээхэн чухал асуудал юм. Үүнд манай орны эрдэмтэн судлаачид, мэргэжлийн хүмүүсийн санаа бодол, үнэлэлт, дүгнэлт ихээхэн ач холбогдолтой байх нь хэн бүхэнд ойлгомжтой зүйл юм.

Энэ үүднээс нь авч үзвэл энэхүү эмхэтгэлийг гаргаж буй нь цаг үеэ олсон, чухал үйл явдал болж байна.

“Монгол Улсын Аюулгүй байдлын салбар - Алманах 2017” эмхэтгэлд Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл, Засгийн газар болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын өмнө тавигдаж буй тулгамдсан зарим асуудлыг нээн илрүүлсэн, түүний дотор эдгээр байгууллага дахь хүний эрх, хэвлэл мэдээллийн асуудлыг судлан дүгнэсэн, шүүн хэлэлцсэн материалууд орсон нь ихээхэн сайшаалтай хэрэг юм.

Миний бие УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргын хувьд үндэсний аюулгүй байдлыг хангахад туслалцаа үзүүлэх, өөрийн гэсэн хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж буй эрдэм шинжилгээний, түүний дотор төрийн бус судалгааны байгууллагуудын үйл ажиллагаа, санал, санаачлагыг цаашид ч байнга дэмжин ажиллах болно.

Энэхүү Алманахыг жил бүр тодорхой хугацаанд тогтмол гаргаж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, энэ салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгоход зохих хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Эрхэм судлаачдын эрдэм номын мөр өөдрөг байх болтугай.

Ж.ЭНХБАЯР

Монгол Улсын Их Хурлын гишүүн,
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга

ӨМНӨХ ҮГ



Аливаа шинэ залуу ардчилсан орны хувьд үндсэний аюулгүй байдлыг хангах, үндсэн хуульт байгууллыг хамгаалах, нийгмийн дэг журмыг сахиулах, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй аюулгүй байдлын салбарын шинэчлэл нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөөс дутахгүй ач холбогдолтой юм. Аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд үйл ажиллагаандаа хүний эрхийг хангаж, хууль дээдлэх нь ардчиллын зарчим. Харин тэдгээр байгууллагуудыг ардчиллын зарчим, үнэт зүйлст нийцүүлэн үндсэн үүргээ мэргэжлийн төвшинд, харилцан уялдаатайгаар гүйцэтгэх боломжоор хангах нь шинэчлэлийн гол зорилго байдаг.

Цэрэг, батлан хамгаалах болон хууль сахиулах салбарыг шинэчлэх чиглэлээр 1990-ээд оноос хойш дорвитой алхмууд хийгдэж, бодит ахиц дэвшил гарсан хэдий ч энэхүү ажиллагаанд дүн шинжилгээ хийж, мэргэжлийн үнэлэлт дүгнэлт өгөх ажил өнөөг хүртэл хангалтгүй явж иржээ. Шинэчлэлийн зорилго, үйл явцын талаар иргэд олон нийтийн ойлголт дутмаг төдийгүй шийдвэр гаргагчид, салбарын төвшинд ч шинэчлэлийн үр дүн, сургамж, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар бодитой, цогц мэдээлэл нэн чамлалттай байна.

Улаанбаатар бодлогын судалгааны төв, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос хамтран Монгол Улсын аюулгүй байдлын салбарын засаглал, шинэчлэлийн асуудлаарх анхны дорвитой цогц бүтээл болох “Монгол Улсын Аюулгүй байдлын салбар - Алманах 2017” номыг эмхэтгэн боловсруулж, Таны гар дээр хүргэж байна. Номын бүлэг бүр үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий зэвсэгт хүчин, цагдаа, хил хамгаалах алба зэрэг байгууллагуудын үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, түүхэн хөгжил, цаашдын чиг хандлагын талаар судалгаа, тоо баримтад тулгуурласан мэдээлэл өгөхийг зорьсон. Түүнчлэн аюулгүй

байдлын салбарын засаглал, хяналтад өвөрмөц тодорхой хувь нэмэр оруулдаг парламент, хүний эрхийн комисс, хувийн хамгаалалтын албад, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг оролцогчдын талаар ч мөн багтаасан нь бодлого боловсруулагчид төдийгүй салбарын мэргэжлийн хүмүүс, энэ асуудлыг сонирхон судалдаг хэнд ч болов ач тусаа өгнө гэдэгт итгэлтэй байна.

“Монгол Улсын Аюулгүй байдлын салбар – Алманах 2017” нь Монгол Улсын аюулгүй байдлын салбарын өнгөрсөн, одоо, ирээдүйг цогцоор харах анхны оролдлого. Үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй оролцдог онцгой байдлын болон тагнуулын байгууллагын талаар энэ удаад оруулж завдаагүй хэдий ч дараа дараагийн дугаарт бие даасан бүлэг болгон оруулахаар төлөвлөж байна.

Эцэст нь, энэ бүтээлийг боловсруулж, эмхэтгэн хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны удирдлага, хамт олон болон зохиогчиддоо гүн талархал илэрхийлье.

Мигэддоржийн БАТЧИМЭГ

Улаанбаатар бодлогын судалгааны төвийн Гүйцэтгэх захирал

АГУУЛГА

Хууль тогтоох байгууллага ба аюулгүй байдлын салбарын хөгжил, шинэчлэл Монгол Улсын Их Хурал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөх Ш. Хишигсүрэн	9
Аюулгүй байдлын салбарын хөгжил, шинэчлэл: Ерөнхийлөгч ба Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Судлаач Б. Мэргэн	36
Монгол Улсын Батлан хамгаалах, зэвсэгт хүчний байгуулалтын хөгжил, шинэчлэл Судлаач Т.Наранхүү	46
Аюулгүй байдлын салбарын хөгжил, шинэчлэл: Хууль сахиулах байгууллагууд Веритас Консалтанси ХХК-ийн захирал Ж.Баярцэцэг	71
Монгол Улсын Хил хамгаалах салбарын хөгжил, шинэчлэл Хил хамгаалах ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын захирал, Хурандаа Б.Алтанхүү	89
Монгол Улсын Цагдаагийн байгууллагын хөгжил, шинэчлэл Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академийн захирал Ж.Мөнхболд	104
Монгол Улсын хувийн хамгаалалтын байгууллагын хөгжил Хууль зүйн ухааны доктор, Хошууч генерал Б.Пүрэв	126
Монгол Улсын Цэргийн шүүхийн хөгжил, шинэчлэл Хуульч эмэгтэйчүүдийн холбооны Гүйцэтгэх захирал П.Цэцэгээ	134
Аюулгүй байдлын салбар дахь хүний эрхийн асуудал Хүний Эрхийн Үндэсний Комиссийн гишүүн П.Оюунчимэг	148
Аюулгүй байдлын салбар ба хэвлэл мэдээлэл Доктор, Монгол Улсын Их сургуулийн Олон улсын харилцааны сургуулийн Бодлогын судалгааны төвийн судлаач Б.Индра	166

Ш. Хишигсүрэн

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА БА АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАРЫН ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛ

Түүхэн товчоо

Монгол газар нутагт оршиж байсан эртний овгууд “хуралдай” хийж асуудлуудаа шийдвэрлэж байсан тухай түүхэнд дурдагдсан байдаг¹. Хуралд овгийн гишүүд нийтээрээ оролцож бүх зүйлийг хэлэлцэн шийдэж, овгийн ахлагчийг сонгох, огцруулах хүртэл өргөн эрх мэдэлтэй байсан бол түүхэн хөгжлийн явцад хурал олонхын хурлаас цөөнхийн хурлын шинжийг агуулах болсон байна. Ийнхүү хурлын шинж алгуур өөрчлөгдөхийн хэрээр түүний асуудлыг хэлэлцэн шийдэх үүрэг багасч зөвлөх байгууллагын шинжийг агуулах болсон гэж үздэг.

1206 онд Их Монгол Улс байгуулагдахад олон жижиг, аймаг, улс бүрд байсан ноёд, язгууртны хурлуудыг “Их Хуралдай” (Yeke Quraldai) гэдэг нэртэй нэгдсэн том хурал бий болж төрийн нэгэн бүтэц болон төлөвшин тогтжээ². Их Монгол Улсын үед Их хааныг сонгох, аян дайнд мордох зэрэг хамгийн чухал асуудлуудыг **Их Хуралдайгаар** шийддэг байсан гэж үздэг. Их Хуралдайд алтан ургийнхан, цэргийн жанжид, төрийн сайдууд зэрэг хамгийн нөлөө бүхий хүмүүс оролцож хамтаар улсын чухал асуудлуудыг нийтээр хүлээн зөвшөөрөх байдлыг хангахад голлох үүрэг гүйцэтгэж байсан байна.

1911 он хүртэл Монголын хурал нь Их Хуралдай, Монголын бага хаадын улсуудын үед чуулган, аймаг, хошуудын чуулган гэсэн нэршлээр өөр өөрийн онцлогтойгоор түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

1911 онд Үндэсний эрх чөлөөний хувьсгал, тусгаар тогтнолоо тунхаглан зарласантай зэрэгцэн Монгол даяар улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт өрнөж, олон улсын жишиг, чиг хандлагыг судлан дэлгэрүүлэх зарим нэг бодит ажлууд хийгдсэн байдаг. Эдгээр ажлын нэгэн тод жишээ бол олон орны Үндсэн хуулийг судлан улмаар улс төрийн амьдралд шинэ зүйл бий болгосон нь “Улсын хурал” хэмээх газрыг дээд, доод танхимтай байгуулсан явдал юм.

¹ Ж.Гэрэлбадрах “МОНГОЛ УЛСЫН ДЭЭД, ДООД ХУРАЛ Монголын анхны парламент (1914-1919 он)” УБ, 2011, х, 6.

² Ж.Гэрэлбадрах, ндб, х.8.

1914 онд Богд Хааны зөвшөөрснөөр Улсын Хурлын газрыг байгуулж, дүрэмд нь Дээд, доод хурлын хэлэлцэх асуудлыг тогтоожээ. Хурлын дүрмийн 2 дугаар зүйлд Дээд хурал нь улс төрийн чухал хэрэгт бодлого гарган зөвлөн хэлэлцэх, таслан шийтгэхийг нь таслан шийтгэх, Доод хурал нь улс төрд тустай болох хэрэгт санаа гаргаж зөвлөн хэлэлцээд Дээд хуралд өргөн тогтоох зэрэг үндсэн чиг үүрэгтэй байсан байна.

Улсын хурлын Дээд, Доод хоёр танхимаар 1914-1915 онд үргэлжилсэн Хиагтын гурван улсын гэрээ ба 1919 онд Монголын тусгаар тогтнолыг устгах Хятадын түрэмгий бодлого, төлөвлөгөөг хүлээн авах, эсэхийг хэлэлцэж байжээ. Богд Хаан Улсын хурлын гаргасан шийдвэрийг ямар нэгэн хэмжээгээр харгалзан үзэж байсан зэргээс үзэхэд Улсын хурал нь яам, хаанд зөвлөх эрхтэй төдийгүй зарим асуудлыг таслан шийдвэрлэх эрхтэй байгууллага байжээ³.

Улсын хурлын газрын дүрэм ёсоор долоо хоног бүр хуралдах Дээд, Доод хурал нэлээд олон асуудлыг хэлэлцэж байжээ. Дээд, Доод хурал улсын аюулгүй байдал, гадаад бодлого, цэргийн асуудлаархи хэлэлцсэн асуудлаас жишээ татвал:

- Нэр нь үл мэдэгдэх хүнээс буу, сум хийх багаж хэрэглэл нууцаар худалдан авч өөрсдөө зэр зэвсгээ хийж тусгаар тогтнолоо хамгаалах талаарх санал, Гадаад яамны түшмэл Минбуугийн мөнгө, төмөр, гууль, тугалга зэрэг байгалийн баялаг хайж ашиглан цэргийн зэвсгээ сайжруулах тухай 4 зүйл санал бүхий өргөх бичиг;
- Цахарын цэргийн дарга Донров, Баянцагаан нараас Өвөр чуулган, хошуудыг Хятадад нэгтгэх болсон тул цаашид хэрхэхийг заасан хааны зарлигийг гуйж өргөсөн бичиг;
- Зүүн өмнөд хязгаарын сайд, баатар гүн Бавуужавын харьяа цэргийн нэр бүхий 12 дарга нараас Хятадтай байлдахад бэлэн байгаа болон зах хязгаар нутгийг тогтоож, олныг амаржуулахыг гуйж өргөсөн бичиг;
- Хиагтын гурван улсын хэлэлцээрийн явцыг эсэргүүцсэн бичиг;
- 1919 оны 10 дугаар сард Доод хурал Монголын өөртөө засах эрхийг устгах бичгийг хэлэлцээд эс зөвшөөрч байсныг онцолсон байна⁴.

1914-1919 онд үйл ажиллагаагаа явуулж байсан Улсын Дээд, Доод хурал нь Монголын анхны парламент ёсыг бий болгох алхмыг тавьж,

³ Ж.Гэрэлбадрах, ндб, х.27.

⁴ Ж.Гэрэлбадрах, ндб, х.117.

улсын аюулгүй байдал, гадаад бодлого, цэргийн асуудлаар Засгийн газар, Богд Хаанд зөвлөх, зарим асуудлаар таслан шийдвэрлэх эрхтэй байгууллага байсан. Түүнчлэн Улсын хурлын газраас тэр үеийн суурь хууль гэж үзэх “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийг батлан гаргасан юм.

1912 онд Цэргийн яамнаас улсын цэргийн анхны анги, хороодыг бий болгож, 1913.02.03-нд байгуулсан Монгол цэргийг бэлтгэн сургах тухай Монгол, Оросын хэлэлцээр, 1914.05.29-нд байгуулсан Орос улсаас цэргийн дарга, түшмэлүүдийг урин авчирч Монгол цэрэг цэргийн эрдэм заалган боловсруулах тухай Монгол, Оросын гэрээгээр манай улс нь оросоос мэргэжилтэн авч цэрэг бэлтгэж эхэлсэн байна. Түүнчлэн 1912 оны сүүлээр нийслэл хүрээний ойролцоо Хужирбуланд цэргийн сургууль байгуулж, 1913 онд монгол цэргийн дагаж мөрдөх 23 зүйл бүхий дүрэм гаргаж байжээ.

1921 оны Ардын хувьсгал ялж, 1924 онд Бүгд Найрамдах Монгол Улсын анхны Үндсэн хууль баталсан бөгөөд уг хуулийн Дөрөвдүгээр зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн хурлын чөлөөт цагт Улсын Бага Хуралд хадгалуулах ба мөн хурлын чөлөөт цагт Бага Хурлын тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино.” гэж заасан байна. 1924 оны Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гадаадтай харилцахад тус улсыг төлөөлөх ба мөн харилцах явдлыг эрхлэх”, 2 дахь хэсэгт “Тус улсын хил хязгаарыг өөрчлөх, байлдах, найрамдах явдлыг эрхлэх, мөн гадаадтай тогтоосон гэрээ бичгийг батлах”, 7 дахь хэсэгт “Улсын цэргийн хүчнийг байгуулах удирдах”-ыг Улсын дээд эрх хадгалах газруудын эрхлэх асуудалд хамааруулсан байдаг. Үүнээс үзэхэд 1924 оны Үндсэн хуульд тусгайлан аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар заагаагүй боловч уг асуудлуудын хүрээнд хил хязгаарыг өөрчлөх, байлдах, найрамдах, цэргийн хүчин байгуулах гэсэн нэр томъёо хэрэглэж байжээ.

1921 онд Ардын хувьсгал дараагаар байгуулагдсан Засгийн газар нь 1922.07.03-нд Бүх цэргийн зөвлөлийн газраас Дотоодыг хамгаалах тусгай газрыг байгуулж байсан нь улсын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий тагнуулын байгууллагын суурийг тавьж байжээ. Түүнчлэн 1923.11.30-нд Засгийн газраас “Монгол Улсын Бүх цэргийн зөвлөлийн дүрэм”, “Монгол Улсын Бүх зэвсэгт цэргийн жанжны дүрэм”, “Монгол Ардын Бүх цэргийн штабын дарга бөгөөд цэргийн яамны эрхэлсэн түшмэлийн дүрэм” зэргийг батлан хэрэгжүүлж байсан байна⁵.

⁵ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл Хоёрдугаар боть, УБ, 2010, х, 470-472.

Монгол Улсын 1924 оны Анхны Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн дагуу Улсын Бага Хурал нь хууль, дүрэм, тогтоол, тушаал гаргах бүрэн эрхтэй байсан бөгөөд улсын аюулгүй байдлаар зарим шийдвэрийг Сайд нарын Зөвлөл шийдвэрлэж байсан байна. Тухайлбал, Ардын сайд нарын зөвлөлийн 1934 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор Улсын аюулаас хамгаалах газрын дүрмийг баталж гаргасан бөгөөд улсын нутаг дэвсгэр дээр гүйцэтгэх төрөл бүрийн аюулаас хамгаалах ажлыг тус улсын аюулаас хамгаалах газарт даалгахаар дүрэмд нь заажээ. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид болон Сайд нарын Зөвлөлийн 1936 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 15 дугаар тогтоолоор дотоодыг хамгаалах газрыг дотоод яам болгон өргөтгөсөн байна. Үүнээс үзэхэд улсын аюулгүй байдлыг хангах асуудлаар Улсын Бага Хурал, түүний Тэргүүлэгчид болон Сайд нарын Зөвлөл шийдвэр гаргах эрхтэй байжээ.

1940 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын өмнөөс засгийн дээд эрх барих ба улсын захиргааны дээд газруудын эрхлэх хэрэгт БНМАУ-ын батлан хамгаалах явдлыг байгуулж, зэвсэгт хүчнийг удирдах хийгээд тусгаар тогтнолыг хангахад; Улсыг аюулгүй байлгах явдал ба ард иргэний эрх, ёс журмыг хамгаалах зэрэг асуудлыг хамааруулж, анх удаагаа Үндсэн хуульд улсын аюулгүй байдал болон батлан хамгаалах асуудлыг тусгайлан тусгасан байдаг. Тус Үндсэн хуулийн Арван гуравдугаар болон Арван долдугаар зүйлд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын өмнөөс засгийн дээд эрх барих газар нь Улсын Их Хурал түүний чөлөөт завсар засгийн дээд эрхийг Улсын Бага Хурал барихаар, Улсын Бага Хурлын чөлөөт цагт улсын засгийн дээд байгууллага нь Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид байхаар тус тус заасан.

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид 1944 оны 72 дугаар тогтоолоороо БНМАУ-ын Ард нийтээс цэргийн алба хаах үүргийн тухай хуулийг батлан дагаж мөрдөж байжээ.

Агаарын зайн тухай хуулийг Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1958 оны 172 дугаар зарлигаар баталсан байна.

1921 онд Монгол Улсын Засгийн газрын баталсан Цэргийн зөвлөлийн дүрмээс эхлэн 1960 он хүртэл цэрэг, батлан хамгаалахтай холбоотой 50 гаруй хууль, дүрэм баталсан байдаг бөгөөд эдгээр эрх зүйн баримт бичиг нь Засгийн газар, Улсын Бага Хурал, түүний Тэргүүлэгчид, Цэргийн зөвлөл, Цэргийн явдлын яамны шийдвэр, тогтоолоор баталгаажсан байдаг байна.

1960 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улс нь 3 дахь Үндсэн хуулиа баталсан бөгөөд тус хуулийн Арван наймдугаар зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал мөн” гэсэн бөгөөд мөн Хорьдугаар зүйлд Ардын Их Хурлын бүрэн эрхийг тухайлан заахдаа хууль гаргах, дотоод, гадаадын улс төрийн бодлогын үндсэн зарчим арга явуулгыг тогтоохыг тусгасан байна. Ардын Их Хурлын Тэргүүлэгчид нь олон улсын гэрээгээр авсан үүргээ биелүүлэх хэрэгцээ тохиолдвол Ардын Их Хурлын чуулганы чөлөөт цагт дайны байдал зарлах, нийтийн буюу хэсгээр цэрэг дайчилгаа зарлах, 1960 оны Үндсэн хуулийн Гучин долдугаар зүйлд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл нь төрийн гүйцэтгэн захирах дээд байгууллага болохыг тогтоогоод Дөчин нэгдүгээр зүйлд Сайд нарын Зөвлөл нь улс орныг батлан хамгаалах, зэвсэгт хүчин байгуулах, ажлыг ерөнхийд нь удирдаж, цэргийн жинхэнэ албанд татах иргэдийн тоог тогтоох асуудлыг шийдвэрлэх эрхтэйгээр тусгасан.

1960 оны Үндсэн хуулиар хууль тогтоох эрх нь Ардын Их Хуралд олгогдсон боловч түүний Тэргүүлэгчид нь зарлигаараа хууль батлан хэрэгжүүлдэг байсан байна. Тухайлбал, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1981 оны 417 дугаар зарлигаар БНМАУ-ын Бүх нийтийн цэргийн үүргийн тухай хуулийг баталсан байна.

1960-аад оноос 1990 оноос хойш Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнээр элссэнтэй холбоотойгоор гадаад харилцаа өргөжиж, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох зэрэг асуудлыг Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар шийдвэрлэж иржээ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах салбар дахь парламентын үүрэг, хэрэгжилт

Ардчилсан Үндсэн хууль түүний дагуу гарсан хууль тогтоомж

Монгол Улс 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хууль⁶ баталсан бөгөөд Монгол Улс нийгмийн шинэ тогтолцоонд шилжихтэй холбогдуулан юуны өмнө эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Ийнхүү аюулгүй байдал болон батлан хамгаалах салбарын сэтгэлгээнд норматив хандлага давамгайлах болж шинэ Үндсэн хуулийн дагуу богино хугацаанд аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын эрх зүйн шинэтгэлийг хийх шаардлага гарч ирсэн.

⁶ Монгол Улсын Үндсэн хууль 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаар батлагдсан. 2000 онд УИХ Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.

1992 оны Үндсэн хуулиар батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг мөн болохыг хуульчилж өгсөн нь төрийн байгууллага бүр улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй гэсэн агуулгыг илтгэх бөгөөд уг хуулийн Хорьдугаар зүйлд “Төрийн эрх барих дээд байгууллага нь Улсын Их Хурал” байхаар зааж, хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалагдахаар зохицуулсан билээ.

Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурал нь хууль тогтоох, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Үндсэн хуулийг хэдийгээр 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн боловч Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулах хүртэлх зурвас үед Улсын Бага Хурал үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлээр дараах агуулга, зохицуулалт бүхий хуулиудыг батлан гаргасан байдаг. Үүнд:

Хуулийн нэр	Баталсан огноо	Хуулийн зорилт, гол зохицуулалт
<p>Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль</p>	<p>1992.05.04</p>	<p>Монгол Улсын иргэн Үндсэн хуульд заасан үүргийнхээ дагуу эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмших, цэргийн алба хаахтай холбогдсон харилцаа, түүнчлэн цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тогтоож зохицуулах зорилттой бөгөөд цэргийн жинхэнэ алба хаах, цэрэг татлаг, цэргийн үүрэгтэн, цэргийн цол, цэргийн эрх зүйн байдлыг голлон зохицуулсан байна.</p>
<p>Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хууль</p>	<p>1992.05.13</p> <p>Уг хуулийг 2001.12.27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон</p>	<p>Уг хуулиар улсын аюулгүй байдлыг “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал хэвийн байх, Үндсэн хуулиар бататгасан төр, нийгмийн байгууллын аюулгүй оршин тогтнох нөхцөл” гэж, мөн “Улсын аюулгүй байдлыг хангах” гэж улсын аюулгүй байдлын асуудлаар төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн эрх бүхий байгууллага болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэний эрх, үүрэг, хармуцлагын нэгдмэл үйл ажиллагааг ойлгохоор тусгайлан тодорхойлсон.</p>
<p>Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль</p>	<p>1992.05.29</p>	<p>Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зорилго, үйл ажиллагааны үндсэн зарчим, чиг үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоон түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилттой бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн байхаар хуульчилсан. Түүнчлэн зөвлөлийн бүрэн эрх, зохион байгуулалтын бүтэц, шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг хуульд тусгасан.</p>

Өнөөгийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг Улсын Бага Хурлаас тогтоосон цагаас хойш аливаа өөрчлөлт гараагүй байгаагаас үзэхэд шинээр Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан УИХ Үндсэн хуульд заасан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох онцгой бүрэн эрхээ өнөө болтол хэрэгжүүлээгүй явж ирсэн гэж дүгнэж болно. 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд уг хуулийн төслийг Улсын Их Хурлын 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасан шийдвэр гаргасан байдаг.

Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” хэмээн заасан.

Улсын Их Хурал Үндсэн хуулийн дээрх заалтыг 2002 оын 5 дугаар сарын 6-ны өдөр Зэвсэгт хүчний тухай хуулийг батлан гаргаж хэрэгжүүлсэн бөгөөд уг хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар шинэчлэн найруулсан.

Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын хилийг хуулиар бататгана.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно.”

Улсын Их Хурал Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 1993 оны 10 дугаар сарын 21-ны өдөр батлагдсан Монгол Улсын хилийн тухай хуулиар, мөн зүйлийн 3 дахь хэсгийг 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуулиар тус тус хэрэгжүүлсэн байна.

Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд дараах бодлогын баримт бичгүүдийг тогтоолоороо баталсан байна. Үүнд:

Бодлогын баримт бичгийн нэр/УИХ-ын тогтоолын дугаар/	Баталсан огноо, УИХ-ын тогтоолын дугаар	Үндсэн агуулга	Тайлбар
Цэргийн номлол	1993		
"Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал" болон "Монгол Улсын цэргийн номлол"	1994 56 дугаар тогтоол	Уг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд анх удаагаа үндэсний аюулгүй байдлыг Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал; нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал; иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал; эдийн засгийн аюулгүй байдал; шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал; мэдээллийн аюулгүй байдал; монгол соёл иргэншлийн аюулгүй байдал; хүн ам, удмын сангийн аюулгүй байдал; экологийн аюулгүй байдал гэсэн үндсэн 9 хэсгээс бүрдэхээр ⁷ , мөн үндэсний аюулгүй байдлыг нийгэм, улс төр, зохион байгуулалт, эдийн засаг, дипломат, цэрэг, тагнуул, хууль зүйн аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангахыг тусгасан. Харин Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд гадаад улс төрийн бодлогыг улсын аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх нэг гол хэрэглүүр гэж үзсэн ⁸ .	Эдгээр баримт бичиг нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалах асуудлаарх төрийн бодлогыг нэгтгэн гаргасан баримт бичиг мөн
			Харин 1994 оны Монгол Улсын цэргийн номлолд батлан хамгаалах бодлогын хүрээнд дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, улс орноо түрэмгийлэллээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах, зэвсэгт хүчнийг байгуулах, зэвсэгт тэмцэл явуулах талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон.

⁷ 1994 оны Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 9 дугаарт нийтлэгдсэн. Тус үзэл баримтлалын 5 дахь хэсэг.

⁸ 1994 оны Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 9 дугаарт нийтлэгдсэн. Тус үзэл баримтлалын 7 дахь хэсэг.

Төрийн цэргийн бодлогын үндэс	1998.05.15 УИХ-ын 56 дугаар тогтоол	Тус цэргийн бодлогын үндэс нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох батлан хамгаалах бодлогыг тодорхойлсон тулгуур баримт бичиг мөн болохыг тогтоосон. Түүнчлэн тус баримт бичгээр Монгол Улсын цэргийн байгуулалтын улс төрийн үндэс нь зөвсэгт хүчинд тавих иргэний хяналт мөнийг тодорхойлсон байдаг.
Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	2010.07.15 УИХ-ын 48 дугаар тогтоол	2010 оны Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улсын "оршин тогтнохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал", "дотоод аюулгүй байдал", "хүний аюулгүй байдал", "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал", "мэдээллийн аюулгүй байдал" гэсэн зургаан аюулгүй байдлын салбар харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна гэж тогтоосон ⁹ . Түүнчлэн Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа байхыг тусгасан.
Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал	2011.02.10 УИХ-ын 10 дугаар тогтоол	Уг үзэл баримтлалд Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт болохыг тодорхойлж, хоёр хөрштэйгээ найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх, улмаар өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэн энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулахаа илэрхийлсэн.

⁹ 2010 оны Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 36 дугаарт нийтлэгдсэн. Тус үзэл баримтлалын 1.2.3 дахь заалт.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс	2015.10.08 УИХ-ын 85 дугаар тогтоол	Энэхүү бодлогын баримт бичиг нь 1988 оны төрийн цэргийн бодлогын үндсийн агуулгыг өргөжүүлж, улсын батлан хамгаалах тогтолцоог тодорхойлж, түүнийг чиглэлийг заасан, төрийн цэргийн байгуулагыг нэг мөр болгож, зэвсэгт хүчний хөгжлийг улам түргэтгэх онцлогийг шингээсэн төрийн баримт бичиг мөн бөгөөд уг баримт бичгийн хүрээнд батлан хамгаалах салбарын эрх зүйн орчин боловсронгуй болж улмаар зэвсэгт хүчний монгол цэргийн өв Уламжлалд тулгуурлан шинжлэх ухаан болон дэвшилтэд технологийтой зэрэгцэн хөгжих чиг хандлагыг тогтоосон.	Энэхүү үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал шинэчлэгдсэнтэй холбогдуулан аюулгүй байдал болон батлан хамгаалах салбарын хүрээнд 1998 оны Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндсийг шинэчлэх ажил эрчимтэй эхэлсэн бөгөөд уг ажил 2015 онд дуусаж Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэсний шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурал 2015 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр өргөн мөдүүлсэн билээ. Уг шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдээс санал гарч дэмжигдсэн төслийг Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс гэж өөрчлөн, холбогдох өөрчлөлтийг оруулж Улсын Их Хурал 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 85 дугаар тогтоолоороо Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг ¹⁰ баталсан.
--	---	--	--

¹⁰ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 41 дугаарт нийтлэгдсэн.

Улсын Их Хурал үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг шинээр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах үүргээ тухай бүрт нь гүйцэтгэж ирсэн ч сар, жилээр бус өдөр, хоногоор огцом өөрчлөгдөж байгаа олон улсын нөхцөл, байдлыг харгалзан үзвэл цаашид улам эрчимтэй ажиллах шаардлага тулгамдаж байна.

Улсын Их Хурал аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаарх хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэн гаргаж ирсэн. Улсын Их Хурал 2015 оны 10 дугаар сард Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг баталсантай холбогдуулан уг баримт бичигт заасан батлан хамгаалах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох ажлыг нэн даруй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага гарсан. Уг асуудлыг нэг мөр болгох үүднээс 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Үндсэн хуульд заасан тодорхой бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай, Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг, Цэргийн албаны тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай, Мэдээллийн аюулгүй байдлын тухай болон Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслүүдийг өргөн мэдүүлсэн.

Эдгээр хуулийн төслүүдээс Улсын Их Хурал 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг, Цэргийн албаны тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан бөгөөд хуулиудын гол шинэлэг зохицуулалтыг дурдвал:

1/ Батлан хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга нь шаардлагатай нэр томъёог жигдлэн тодорхойлж, батлан хамгаалах тогтолцоог зөвхөн цэргийн арга хэмжээгээр хязгаарласан ойлголтоос өргөн хүрээгээр тодотгон, батлан хамгаалах тогтолцооны үндсийг орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа гэсэн өөр хоорондоо нягт уялдаа холбоотой гурван тулгууртай байхаар анх удаа хуульчилсан. Түүнчлэн цэргийн, цэрэгжсэн байгууллага зэрэг салаа утга бүхий ойлголтыг нэг мөр болгон Монгол Улсын төрийн цэргийн байгууллыг тодорхойлж, цэргийн байгууллын тогтолцоог тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байгууллагаас бүрдэхээр тогтоосон. Эдгээр байгууллагууд нь цэргийн эрх зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрэм, цэргийн цол, цэргийн албан хаагчийн бие бялдарын стандарт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох байдлаараа нэгдмэл байх эрх зүйн үндсийг бий болгосон.

2/ Батлан хамгаалах хуульд төрийн цэргийн байгууллыг төр, нийгмийн байгуулал, иргэний эрхийн эсрэг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглосон.

3/ Батлан хамгаалах удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн цэргийн байгууллын улс төрийн удирдлага, төрийн захиргааны удирдлага, цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг хэрэгжүүлэх субъектүүдийг хуульчлан, бүрэн эрхийг зааглан тусгасан. Батлан хамгаалах талаарх төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын үүргийг тодорхой тусгасны зэрэгцээ аж ахуйн нэгж, байгууллагуудын хүлээх үүргийг нарийвчилсан. Аж ахуйн нэгж, байгууллагууд нь ажилтныхаа иргэний цэргийн алба хаах үүргийг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, цэргийн үүрэгтний дайчилгааны сургууль, цугларалтад оролцуулах үүрэг хүлээнэ. Ингэснээр аж ахуйн нэгж, байгууллага ажилтнаа дайчилгааны сургуульд явахад нь түүний ажлын байрыг нь хадгалан, ажилтнаа оролцуулах боломжийг нь хангана.

4/ Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зэвсэгт хүчин нь хуурай замын болон агаарын цэргээс бүрдэхээр зохицуулж, үг хэллэгийг нь олон улсад хэрэглэгддэг цэргийн нэр томъёотой нийцүүлэн тусгасан. Тус хуулиар зэвсэгт хүчний үндсэн чиг үүргийг тодорхойлж, зэвсэгт хүчний удирдлагын тогтолцоог, тэдгээрийн бүрэн эрхийг хуульчилсан. Өөрөөр хэлбэл, Зэвсэгт хүчний улс төрийн дээд удирдлагыг Улсын Их Хурал, төрийн захиргааны удирдлагыг Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штаб, цэргийн захиргааны удирдлагыг төрийн цэргийн командлагч, нэгтгэл, анги, салбарын захирагч, цэргийн мэргэжлийн удирдлагыг төрөл, мэргэжлийн цэргийн дарга нар тус тус Үндсэн хууль, болон бусад хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд эдгээр удирдлагын бүрэн эрхийн өөр хоорондын уялдаа холбоог хуулиар нарийвчлан зааглаж, давхардал, хийдлийг нь засаж залруулсан.

5/ Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулж байсан асуудлыг Цэргийн албаны тухай хууль болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар тус тус зохицуулахаар хуульчилсан. Цэргийн албаны тухай хуулиар цэргийн алба нь цэргийн жинхэнэ алба, цэргийн бэлтгэл албанаас бүрдэхээр тогтоож, цэргийн жинхэнэ алба хаагч нь хугацаат болон гэрээт алба, дүйцүүлэх, ахлагчийн болон офицерийн

алба гэсэн бүтэцтэй байхаар хуульд тусгасан. Цэргийн сургуульд суралцсан хугацааг хуулиар иргэний ажилласан хугацаанд тооцох, оюутан-цэрэг зэрэг асуудлыг шинээр хуульчилсан. Хугацаат цэргийн алба хаах хугацаанд ямар нэг өөрчлөлт оруулаагүй болно. Цэргийн алба хаах насны дээд хязгаарыг ахлагчийн албыг 47 нас хүртэл, офицерын албыг дунд офицер 47, ахлах офицер 52 нас хүртэл, дээд офицер 57 нас хүртэл, эмэгтэйчүүд офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаахаар шинэчилсэн. Энэ нь өмнөх хуулиас ер нь алба хаах насыг 2 насаар нэмэгдүүлсэн болно.

6/Цэргийн албаны тухай хуулиар цэргийн цол олгох журмыг тодорхой болгон цол олгох эрх бүхий албан тушаалтныг тодотгон, түүний эрх, цэргийн цолыг олгох, хэрэглэх, цол бууруулах, хураан авах, сэргээх журмыг нарийвчлан тогтоож, цэргийн цолыг цэргийн байгууллагаас бусад төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан хэрэглэхийг хориглосон эрх зүйн зохицуулалтыг бий болгосон. Ингэснээр цэргийн цол шат дараатай олгож, цэргийн цол олгох асуудлыг цэгцэлсэн гэж үзэж байна.

7/Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар цэргийн алба хаагч нь захирах, захирагдах, улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх зарчмыг баримтлахыг хуульчилж, цэргийн алба хаагч гадаад улсад энхийг дэмжих ажиллагаанд оролцох, дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцах, ангийн байрлалаас гадна бүтээн байгуулалтын үйл хэрэгт оролцох болон хуульд заасан бусад үүрэг гүйцэтгэх тохиолдол бүрийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн цэргийн алба хаагчийн давуу эрхэд офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн жил бүр биеэр эдлэх ажлын 15 өдрийн амралтыг 18 өдөр болгосон, офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид цэргийн жинхэнэ алба хаасан таван жил тутамд олгох ажлын хоёр өдрийн нэмэгдэл амралтыг гурван өдрийн нэмэгдэл амралт болгон өөрчилсөн өөрчлөлтийг хуульчилсан. Мөн цэргийн алба хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс гэр бүлийн гишүүн нь цэргийн эмнэлэгээр үйлчилүүлэх, офицер, ахлагч нь шилжин томилогдох, цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халагдах үед түүний гэр бүлийн гишүүд, ачаа тээшний хамт оршин суух газарт нь хүргэх тээврийн зардлыг тооцон олгох, офицер, ахлагч нь өөр анги, байгууллагад шилжин алба хаах болсонтой холбогдуулан эхнэр / нөхөр/ нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрсэн бол тэдэнд нэг сараас доошгүй хугацааны дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгох зэрэг нэлээд олон шинэлэг асуудлыг хуульд тусгасан.

Харин үүнтэй зэрэгцүүлэн Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэст заасан орон нутгийн хамгаалалтын болон дайчилгааны

бэлтгэлийг хангах харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Монгол Улсын хувьд иргэний болон цэргийн удирдлагын харилцааг улс төрийн тогтолцооны ардчилсан удирдлагын хүрээнд шинээр зохицуулах шаардлагатай нэгэн чухал асуудал юм. Учир нь Монгол Улс 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш цэрэг болон батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг сайжруулсан боловч ардчилсан нийгмийн хөгжилд нийцсэн иргэн-цэргийн харилцааг хангалтай судлан хууль тогтоомжийг шинэчлэх ажил шаардлагын хэмжээнд хэрэгжиж чадаагүй, иргэний хувьд аюулгүй байдал, батлан хамгаалах асуудал нь төдийлөн нээлттэй бус явж ирсэн уламжлал өнөө хүртэл оршоор байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийг Улсын Их Хурал 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэн баталсан.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын асуудал

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бүрэн эрхийг нээж улмаар түүний онцгой бүрэн эрхэд хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийг хамааруулсан. Хууль батлах, түүний биелэлтийг хянан шалгах хоёрын нийлбэрийг хууль тогтоох үйл ажиллагаа гэж үздэг¹¹. Хууль тогтоох үйл ажиллагаа нь парламентын үндсэн үйл ажиллагаа билээ.

Улсын Их Хурал нь Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль¹² болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд¹³ заасны дагуу парламентын хяналт шалгалтыг дараах арга хэлбэрээр хэрэгжүүлж байна:

1/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга,

¹¹ Б.Чимид."Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх зарим асуудал", Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын төлөвшил, хөгжил /Онол, практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл/, УБ хот, 2010, х 63.

¹² Монгол Улсын Их Хурлын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 8 дугаарт нийтлэгдсэн. Уг хуулийн 7 дугаар болон 19 дүгээр зүйлд парламентын хяналт шалгалтын асуудлыг тусгасан.

¹³ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2007 оны 39 дугаарт нийтлэгдсэн. Тус хуулийн 48 дугаар зүйлд Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, 49 дүгээр зүйлд гишүүний асуулгын хариуг хэлэлцэх, 50 дугаар зүйлд гишүүний асуултын хариуг хэлэлцэх, 51 дүгээр зүйлд Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газрын гишүүдийн тайланг сонсох журмыг тус тус зохицуулсан.

- асуулт тавьж хариуг нь хуульд заасан хугацаанд авах;
- 2/ Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаатай танилцах;
 - 3/ Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл шаардаж авах;
 - 4/ Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллага, тэдгээрийн удирдлагын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх;
 - 5/ Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, санал, дүгнэлт зэрэг баримт материалыг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох;
 - 6/ Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор дагнасан болон холимог бүрэлдэхүүнтэй шалгалтын ажлын хэсэг байгуулж ажиллуулах;
 - 7/ Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын гаргасан эрх зүйн актыг хянаж, хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авах.

Парламентын хяналт шалгалтыг гүйцэтгэж байгаа субъектээр нь парламент бүхэлдээ буюу түүний бүтцийн нэгж /Байнгын, түр болон дэд хороо/-ээр хэрэгжүүлэх хяналт шалгалт, парламентын гишүүний хэрэгжүүлэх хяналт шалгалт, парламентын бүтцэд ордоггүй хараат бус байгууллага /Төрийн аудит, Хүний эрхийн үндэсний комисс, Санхүүгийн зохицуулах хороо, Төв банк гэх мэт/-аар дамжуулан гүйцэтгүүлэх хяналт шалгалт гэж ангилан үздэг¹⁴ бөгөөд энд Улсын Их Хурал түүний гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын төсвөөс бусад асуудлаарх өнөөг хүртэлх хийсэн хяналт шалгалтын асуудлыг товчоолон харуулахыг эрмэлзэв.

Судалгааны хүрээнд 1992 оноос өнөөг хүртэл аюулгүй байдал, батлан хамгаалахтай холбогдуулан гаргасан хяналт шалгалтын ажлын хэсгийн үйл ажиллагааг авч үзлээ. Энд Улсын Их Хурлын болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/-ны тогтоолоор байгуулсан парламентын хяналт шалгалтын ажлын хэсгийг авч үзсэн болно:

¹⁴ Б.Чимид, “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх зарим асуудал”, Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын төлөвшил, хөгжил /Онол, практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл/, УБ хот, 2010, х 67.

Д/д	Ажлын хэсэг байгуулсан шийдвэр	Ажлын хэсгийн үндсэн чиглэл	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	УИХ-ын 1993 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 98 дугаар тогтоол	Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газар, бусад тусгай албадаас Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийн заалтыг хэрхэн биелүүлж байгаагай болон нууц баримт материалын бүрэн бүтэн байдлын хадгалалт, хамгаалалттай холбоотой асуудлыг хянан шалгах Улсын Их Хурлын Ажлын хэсэг	Уг хяналт шалгалтын дагуу Улсын Их Хурал 1994 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 19 дүгээр тогтоол гаргаж Засгийн газарт Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт хийсэн шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар шаардлагатай арга хэмжээ авч дүнг Улсын Их Хурлын 1994 оны хаврын чуулганд танилцуулахыг даалгаж байжээ.
2	Байнгын хорооны 1999 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 4 дугаар тогтоол	Хилийн цэргийн удирдах ерөнхий газар, Хилийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих Ажлын хэсэг	Тус шалгалтын дүнг Байнгын хорооны хуралдаанаар танилцуулж, Байнгын хорооноос шалгалтын мөрөөр арга хэмжээ авах албан бичгийг Засгийн газарт өгч байсан байна. Уг албан бичигт Засгийн газар харуу өгсөн байдаг.
3	Байнгын хорооны 1999 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 13 дугаар тогтоол	Батлан хамгаалах яамны 1999 оны төсвийн гүйцэтгэлийг шалгах танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг	Уг шалгалтын явц, үр дүн болон бусад мэдээлэл тодорхойгүй.
4	Байнгын хорооны 2011 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 04/02 дугаар тогтоол	Завхан, Увс аймаг дахь хилийн цэргийн анги салбаруудын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай танилцах үүрэг бүхий Ажлын хэсэг	Уг шалгалтын явц, үр дүн болон бусад мэдээлэл тодорхойгүй.

<p>5 Улсын Их Хурлын даргын 2012 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 157 дугаар захирамж</p>	<p>Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтийг хангах, аюулгүй байдал, хууль зүйн салбарын шинэчлэлийн бодлогыг уялдуулах, аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналтыг боловсронгуй болгох бодлого боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг</p>	<p>Уг шалгалтын явц, үр дүн болон бусад мэдээлэл тодорхойгүй.</p>
<p>6 Байнгын хорооны 2013 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 06 дугаар тогтоол</p>	<p>Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний жанжин штабт зэвсэг техникийн өнөөгийн байдал, хадгалалт, хамгаалалтын байдалтай танилцаж, санал дүгнэлт гаргах Ажлын хэсэг</p>	
<p>7 Байнгын хорооны 2014 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаар тогтоол</p>	<p>Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн үнэлж, санал дүгнэлт гарган Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг</p>	<p>Байнгын хорооны 2015 оны 1 дүгээр сарын хуралдаанд танилцуулан Засгийн газарт гадаад бодлогын хэрэгжилттэй холбогдох зарим чиглэл өгсөн Байнгын хорооны тогтоол гаргаж ажилласан байдаг.</p>
<p>8 Байнгын хорооны 2015 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 03 дугаар тогтоол</p>	<p>Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс болон “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, цэргийн зэвсэглэл, техникийн хадгалалт, хамгаалалтын байдалд шалгалт хийж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг</p>	<p>Тус Ажлын хэсэг нэлээд олон цэргийн анги, салбарт хүрч тухайн анги, салбар дахь зэвсэглэл, техникийн хадгалалт, хамгаалалтын байдалд шалгалт хийн ажиллаж, уг асуудлаар 2015 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Засгийн газарт шаардлагатай чиглэлийг өгөн түүний хэрэгжилтийг хангуулж, санал, дүгнэлтээ гарган ажилласан байна¹⁵.</p>

¹⁵ Тус Ажлын хэсгийн хэсгийн санал болон Батлан хамгаалах сайдын мэдээллийн дагуу чиглэл өгөх тухай Байнгын хорооны 2015 оны 08 дугаар тогтоолыг гаргасан бөгөөд уг тогтоолоор зарим анги, салбар дахь зэвсэглэл, техникийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдаг.

2000-2009 оны хооронд аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулсан тухай ямар нэг өгөгдөл олдоогүй болно. Энд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох эмийн, хүнсний болон экологийн аюулгүй байдал зэрэг асуудлаар санал дүгнэлт гаргах үүрэг Байнгын хороодын хамтарсан ажлын хэсгийг авч үзээгүй болно. Учир нь эдгээр ажлын хэсэг нь батлан хамгаалахаас бусад салбарын асуудлыг илүүтэй хамаарч байгаа тул бидний ажлын сэдэвт хамааруулаагүй болно.

2012-2016 оны хооронд Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулга, асуултыг судлан үзэхэд аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлээр Батлан хамгаалахын сайд болон бусад холбогдох албан тушаалтанд асуулга болон асуулт тавьж байсан талаарх өгөгдөл байхгүй байна.

Улсын Их Хурлын 2008-2012 оны бүрэн эрхийн хугацаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих болон олон улсад ажиллагаанд Монгол Улсаас цэргийн баг оролцуулж байгаа үйл ажиллагааны хүрээнд хийж байгаа ажил, цаашид авах арга хэмжээний талаар Ерөнхий сайд мэдээлэл хийж байсан бол 2011 онд Тагнуулын ерөнхий газар Байнгын хорооны хуралдаанд хаалттайгаар 2 удаа, 2012 онд Хил хамгаалах ерөнхий газар 1 удаа тус тус мэдээлэл хийж байжээ¹⁶.

Батлан хамгаалах сайд 2015 онд нэг удаа Байнгын хорооны хуралдаанд мэдээлэл хийсэн байна.

Асуулга, асуулт, тайлан, мэдээлэл сонсох мэтийн парламентын хяналт шалгалтын гол хэлбэрүүдийг мэдээлэл авах төдийгээр ашиглах бус, харин хууль яаж “ажиллаж” ямар үр дүнд хүрч байгаа, Засгийн газар түүний гишүүний үйл ажиллагаанд илэрч байгаа зөрчил, улс төрийн бодлого, практик хоёрын зөрөөний шалтгаан, гэм буруу, түүнийг арилгах арга замыг олж тогтоон зохих шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай¹⁷.

Дээрх мэдээллээс аюулгүй байдал, батлан хамгаалах салбар дахь парламентын хяналт хангалттай хэмжээнд төлөвшиж, тогтворжоогүй байгаа нь харагдаж байна. 2015 онд байгуулагдсан УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Зэвсэгт хүчний жанжин штабт зэвсэг техникийн өнөөгийн байдал, хадгалалт, хамгаалалтын байдалтай танилцаж, санал дүгнэлт гаргах Ажлын хэсэг цэргийн анги,

¹⁶ Монгол Улсын Их Хурлын түүхэн товчоон 2008-2012 он, УБ хот, 2012, х.208, 213, 214.

¹⁷ Б.Чимид. “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх зарим асуудал”, Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын төлөвшил, хөгжил /Онол, практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл/, УБ хот, 2010, х 74

нэгтгэлээр нэлээд явж бодит нөхцөл байдлын судлан шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, санал дүгнэлт гаргаж, зохих журмын дагуу Засгийн газар болон холбогдох байгууллагуудад нь хүргүүлсэн нь нэлээд үр дүнтэй ажил болсон байна.

Улсын Их Хурал ба Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалахын төсөв

Улсын Их Хурал Үндсэн хууль болон Төсвийн тухай хууль тогтоомжийн дагуу жил бүрийн улсын төсвийг хуульд заасан хугацаанд нь баталж ирсэн бөгөөд батлан хамгаалах салбарын буюу батлан хамгаалахын сайдын жилийн төсвийн багцыг улсын нэгдсэн төсөвт тусган бусад сайдын төсвийн багцтай хамт Засгийн газраас жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг¹⁸.

Улсын Их Хурал улсын төсвийг тухайн оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлах хуулийн хугацаатай бөгөөд улсын төсвийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд заасан журмын дагуу 4 үе шаттайгаар хийдэг¹⁹.

Төсвийн хэлэлцүүлгийн үе шат:

- Нэг дэх хэлэлцүүлэг - Ерөнхий сайд төсвийн төслийн талаар нэгдсэн хуралдаанд илтгэл тавих;
- Хоёр дахь хэлэлцүүлэг - Бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төсвийн төслийг эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж гарсан санал, дүгнэлтийг томьёолон Төсвийн байнгын хороонд хүргүүлэх ба саналыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах;
- Гурав дахь хэлэлцүүлэг - Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулах;
- Дөрөв дэх хэлэлцүүлэг - Нэгдсэн хуралдаан даргалагч Монгол Улсын төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж сонсож тус бүрээр нь санал хураалт явуулж батлах.

¹⁸ Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн. Тус хуулиар улсын төсөв өргөн мэдүүлэх, батлах зэрэг цагалбарын хугацааг нарийвчлан тогтоосон.

¹⁹ Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйл. Мөн хуулийн 26 дугаар зүйлд төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайланг хэлэлцэх журмыг зохицуулсан.

Батлан хамгаалахын төсвийг батлах тусгайлсан горим байдаггүй бөгөөд бусад салбарын төсөв батлах процедуртай нэгэн адил зохицуулалтыг дагаж мөрддөг.

Батлан хамгаалахын төсвийг батлахад гардаг хүндрэл

Батлан хамгаалах салбарын төсвийг улсын төсөвт тусган Засгийн газраас жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг. Улсын жил бүрийн төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө Сангийн яам төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарт багтаан төсөвлөдөг.

Ийнхүү улсын төсөвт багцлагдан өргөн мэдүүлсэн батлан хамгаалах салбарын төсвийн анхны хэлэлцүүлгийг Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд илтгэснээр эхэлдэг.

Батлан хамгаалах салбарын төсвийг эрхлэх асуудлынхаа хүрээнд холбогдох Байнгын хороо буюу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн гарсан санал, дүгнэлтээ томъёолон Төсвийн байнгын хороонд хүргүүлдэг.

Батлан хамгаалах салбарын төсвийг Байнгын хороо нь хэлэлцэх явцад дутуу болон шаардлагатай хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг нэмэх, эсхүл тэдгээртэй холбогдох санал гарган Байнгын хорооны гишүүд нь дэмжин санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлдэг. Уг санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг /зарим тохиолдолд Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулдаг, 2016 оны улсын төсвийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын даргын захирамжаар болон Төсвийн Байнгын хорооны тогтоолоор 2 ч Ажлын хэсэг гаргасан/ холбогдох Байнгын хорооны гаргасан саналуудыг багцлан Төсвийн байнгын хорооны хуралдаанд оруулах /зөвхөн Ажлын хэсэг дэмжээгүй гэх үндэслэлээр оруулаагүй тохиолдол 2016 оны улсын төсвийг хэлэлцэж байхад гарсан/ ба Төсвийн байнгын хороо холбогдох Байнгын хорооны саналыг хэлэлцэн дэмжсэн, дэмжээгүйгээр нь нэгдсэн хуралдаанд оруулдаг. Ийнхүү батлан хамгаалах салбарын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд холбогдох Байнгын хорооноос гаргасан саналыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Улсын төсвийг хэлэлцэх явцад холбогдох Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар бус Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцдэг.

Үүнээс дүгнэхэд батлан хамгаалах салбарын төсвийн төлөвлөлт УИХ-д өргөн барихаас өмнө оновчтой сайн боловсруулагдсан байх шаардлагатай бөгөөд уг төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад шинэ санал гаргах, дэмжүүлэхэд нэн төвөгтэй байдаг. Түүнчлэн төсвийн асуудалд батлан хамгаалах асуудал хариуцдаг байнгын хорооноос илүү Төсвийн байнгын хороо, түүний ажлын хэсэг давуу эрх мэдэлтэй байдаг.

Улсын Их Хурал тусгайлан төсөв баталдаг уу?

Аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий тагнуулын байгууллагын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж санал болгосноор Улсын Их Хурал тусгай зүйл болгон баталж байх зохицуулалтыг Улсын Их Хурал 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиараа Тагнуулын байгууллагын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Түүнчлэн Шүүхийн захиргааны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад “Ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлэх” гэж заасан байдаг бөгөөд уг заалтын дагуу шүүхийн төсвийг Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлдэг. Улсын Их Хурал уг төсвийг төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаар /Сангийн яам зарим жил хянадаг/-ыг баримтлан улсын нэгдсэн төсөвтэй хамтад нь багцлан хэлэлцдэг.

Аюулгүй байдал, батлан хамгаалахын төсвийг шүүхийн төсөвтэй адил, эсхүл зарим улсын парламент тусгайлан хэлэлцэн баталдаг жишиг манайд зохистой эсэхийг нэг талаар судлууштай асуудал юм. Цаашид батлан хамгаалахын төсөв улсын төсөв болон ДНБ-д эзлэх зохистой хувийг тогтоон уг зарчмыг баримтлах нь зүйтэй. Ингэснээр улсын батлан хамгаалах асуудлыг тодорхой төвшинд хүргэх боломж бий болно.

Батлан хамгаалахын төсвийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

Улсын Их Хурал нь батлан хамгаалах салбарт санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын төрийн аудитын байгууллагаар хийлгэдэг²⁰. Өөрөөр хэлбэл, Төрийн аудитын байгууллага нь батлан хамгаалах салбар дахь парламентын хяналт шалгалтыг Төрийн аудитын хуулийн дагуу хэрэгжүүлдэг.

Санхүүгийн тайлангийн аудит нь батлах хамгаалахын сайдын жилийн төсвийн санхүүгийн тайлан, санхүүгийн байдал, үйл ажиллагааны

²⁰ Төрийн аудитын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн. Уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “ Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийнэ.” гэж заасан.

үр дүн болон мөнгөн гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулдаг. Гүйцэтгэлийн аудит нь батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг хэрхэн арвич хямагч, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж байгааг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гаргадаг.

Нийцлийн аудитаар батлан хамгаалах яам болон түүний харьяа байгууллагын үйл ажиллагаандаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гаргадаг.

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийж, дүгнэлтээ Улсын Их Хурал, түүний холбогдох Байнгын хороонд танилцуулдаг.

Өнөөгийн байдлаар төрийн аудитын байгууллагын батлан хамгаалах асуудлаарх дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурал, Байнгын хорооноос авч хэрэгжүүлсэн тодорхой ажлын талаар мэдээлэл байхгүй байгаа бөгөөд аудитын байгууллагын дүгнэлттэй танилцах төдийгөөр ажиллаж ирсэн байдаг.

Түүнчлэн Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо төсвийн зарцуулалттай газар дээр нь танилцаж хяналт тавих эрхтэй боловч хуульд үүнийг үүрэг болгож тусгаагүйгээс өнөөг хүртэл хэрэгжихгүй явж ирсэн.

Цаашид төрийн аудитын байгууллагын дүгнэлттэй танилцан асуудлын утга учир, дутагдлыг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх чиглэлээр Байнгын хороо ажиллах шаардлага эдийн засаг, нийгмийн өмнө гарсаар байна.

Дүгнэлт

Хууль тогтоомжийн хүрээнд

Хууль тогтоомжийн хүрээнд Ардчилсан Үндсэн хууль баталсан 1992 оноос аюулгүй байдал, батлан хамгаалахын салбарын хууль тогтоомжийн шинэтгэлийн ажлыг Улсын Их Хурал нэлээд эрчимтэй хийж, шаардлагатай хууль тогтоомжийг батлан гаргаж ирсэн.

Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг баталсантай холбогдуулан батлан хамгаалахын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, батлан хамгаалах

салбарын хууль тогтоомжийг илүү ардчилсан болгох, хууль тогтоомжийн шинэтгэлийн дараагийн үеийг эхлүүлэх суурь тавигдсан билээ. Энэхүү хууль тогтоомжийн шинэтгэлийн хүрээнд батлан хамгаалах салбарын багц хуулийг Улсын Их Хурал 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанаараа баталсан.

Батлан хамгаалахын багц хууль шинээр батлагдсан нь энэ салбарын хөгжил, шинэчлэлд чухал алхам болсон бөгөөд тэдгээр багц хуулийн биелэлтэд Улсын Их Хурал түүний холбогдох Байнгын хороо хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна.

Засгийн газраас 2016 оны улсын төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцээд цэргийн алба хаагчийг тэтгэвэрт гарахад нь олгодог 36 сарын тэтгэмжийг хэмжээг бууруулахгүй байх нь зүйтэй гэж үзэн хууль санаачлагчид нь буцаахаар шийдвэрлэж, уг асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн буцаасан байдаг. Гэвч уг асуудлыг сар хүрэхгүй хугацааны дараагаар 2017 оны улсын төсвийн тухай хуультай хамт дахин оруулж ирсэн бөгөөд сар хүрэхгүй хугацааны дотор цэргийн алба хаагчдын тэтгэврийн асуудлыг хөндөж, үндэсний аюулгүй байдал, төрийн цэргийн байгууллагуудын байнгын бэлэн байдал, хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдлыг бий болгож, цэргийн алба хаагчдын нийгмийн баталгаа алдагдах, албаа тогтвор суурьшилтай, үнэнч шударгаар хаах сонирхол буурах, баталгаа алдагдах, офицер, ахлагчийн орон тоо нөхөн хангагдахгүй болсноос боловсон хүчний хомсдолд орох зэрэг сөрөг үр дагаврууд бий болохыг харгалзан үзэж уг асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцээд хууль санаачлагчид дахин буцаахаар шийдвэрлэж байсан. Үүнээс дүгнэхэд Засгийн газар төсөвтэй холбогдуулан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа юуны өмнө аюулгүй байдал алдагдах эсэхийг дүгнэх шаардлагатай гэж үзэж байна.

Олон улсын байдал өдрөөс өдөрт хувьсаж байгааг харгалзан шаардлагатай тохиолдолд Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал болон батлан хамгаалахын бодлогын үндэс зэрэг бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлтийг түргэн шуурхай тусгаж байх шаардлага гарч байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийг өргөн мэдүүлээд байгаа бөгөөд дэлхий дахинд кибер аюулгүй байдлыг хангах асуудал өдрөөс өдөрт нэмэгдэж байгааг харгалзан

уг асуудлаарх эрх зүйн орчинг Улсын Их Хурал нэн даруй бүрдүүлэх шаардлагатай байгаа болно.

Парламентын хяналт шалгалтын талаар

Батлан хамгаалах салбарт тавих парламентын хяналт шалгалт төдийлөн хангалттай бус байгааг харгалзан хяналт шалгалтын механизмийг тогтмолжуулан, парламентын хяналт шалгалтыг мэдээлэл авах төдийгээр ашиглах бус, харин хууль яаж “ажиллаж” ямар үр дүнд хүрч байгаа, Засгийн газар түүний гишүүний үйл ажиллагаанд илэрч байгаа зөрчил, улс төрийн бодлого, практик хоёрын зөрөөний шалтгаан, гэм буруу, түүнийг арилгах арга замыг олж тогтоон зохих шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн парламентын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналт шалгалтын хэлбэрүүдийг хэлэлцэх процедурыг нарийвчлан боловсронгуй болгох нь зүйтэй.

Батлан хамгаалахын төсөв батлах талаар

Батлан хамгаалахын төсөв батлах процедурт холбогдох Байнгын хорооны чиг үүргийг тодруулах шаардлага эн тэргүүнд тавигдаж байна. Батлан хамгаалахын төсвийг хэлэлцэх асуудлыг зарим улсын парламент тусгайлан хэлэлцэн баталдаг жишиг манайд зохистой эсэхийг харьцуулан судалж, дүгнэлт гаргах шаардлагатай.

Цаашид батлан хамгаалахын төсөв улсын төсөв болон ДНБ-д эзлэх зохистой хувийг тогтоон уг зарчмыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна.

УИХ-ААС БАТАЛСАН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. 1990-1992 онд Улсын Бага Хурал:

1. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль-1992.05.04 /2016.09.01-ний өдрийн хуулиар хүчингүй болсон/
2. Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хууль-1992.05.13 /2001.12.27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/
3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль-1992.05.29

Хоёр. 1992 оны Улсын Их Хурлын анхны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал:

4. Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль-1993.10.12
5. Монгол Улсын хилийн тухай хууль-1993.10.21
6. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль-1994.06.13
7. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлол батлах тухай Улсын Их Хурлын тогтоол-1994.06.30 /УИХ-ын 2010 оны 48 дугаар, 2011 оны 10 дугаар, 1998 оны 56 дугаар тогтоолоор тус тус хүчингүй болсонд тооцсон/
8. Төрийн нууцын тухай-1995.04.18 /2016.12.01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

Гурав. 1996 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал:

9. Гүйцэтгэх ажлын тухай хууль-1997.12.19.
10. Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хууль-1998.01.08
11. Дайн бүхий байдлын тухай хууль-1998.01.08
12. Дайны байдлын тухай хууль-1998.05.15
13. Дайчилгааны тухай хууль-1998.05.15
14. Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоол-1998.05.15 /УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/
15. Тагнуулын байгууллагын тухай хууль-1999.07.08
16. Үндэсний аюулгүй байдлын тухай-2001.12.27

Дөрөв. 2000 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал:

17. Зэвсэгт хүчний тухай хууль-2002.05.16
18. Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль-2002.05.17 /2010.05.20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/
19. Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль-2002.06.13
20. Төрийн нууцын жагсаалт батлах тухай-2004.01.02 /2016.12.01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний жанжин штабын төрийн захиргааны үйл ажиллагааг 2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн Монгол Улсын яамны эрх зүйн байдлын болон Засгийн газрын агентлагийн тухай хуулиар тус тус зохицуулж байгаа болно.

Тав. 2004 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал:

2004 болон 2008 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал нь үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалах асуудлаарх бие даасан хууль гаргаагүй боловч холбогдох хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулж байсан байна.

Зургаа. 2008 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал:

- 21.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль- 2010.05.20
- 22.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай УИХ-ын тогтоол-2010.07.15
- 23.Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлах тухай УИХ-ын тогтоол-2011.02.10

Долоо. 2012 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал:

- 24.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль-2013.01.31
- 25.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль-2013.05.31
- 26.Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай УИХ-ын тогтоол-2015.10.08

Найм. 2016 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал:

- 27.Батлан хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга-2016.09.01
- 28.Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулга-2016.09.01
- 29.Цэргийн албаны тухай хууль-2016.09.01
- 30.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль-2016.09.01
- 31.Төрийн болон албаны нууцын тухай хууль-2016.12.01

Б. Мэргэн

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАРЫН ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛ: ЕРӨНХИЙЛӨГЧ БА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

Түүхэн хөгжил

1990 оноос өмнө Монгол Улсад Ерөнхийлөгчийн институт байгаагүй бөгөөд Монгол Улсын анхны Ерөнхийлөгч 1990 оны 9 дүгээр сард БНМАУ-ын Ардын их хурлын чуулганаас сонгогдож байв. Монгол Улс 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиараа Ерөнхийлөгчийн институцийг бий болгож, Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10-т зааснаар Ерөнхийлөгчид “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх” бүрэн эрхийг олгосон. Улмаар Ерөнхийлөгч өөрийн санаачилсан эхний хууль болох Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийг 1990 оны анхны ардчилсан сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Бага Хуралд өргөн барьж, уг хууль 1992 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан. Үүгээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл(ҮАБЗ)-ийн түүх эхэлдэг.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл байгуулагдсанаас хойш 1994 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрийн цэргийн бодлогын үндэс, Гадаад бодлогын үзэл баримтлал, 2001 онд Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг тус тус баталжээ. Үүнээс хойш 2010 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэн баталж, Гадаад бодлогын үзэл баримтлал, Батлан хамгаалах бодлогын үндэс зэрэг баримт бичгүүд шинэчлэгдсэн байна.

ҮАБЗ нь гурван гишүүнтэй бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар уг зөвлөлийн жинхэнэ гишүүд юм. Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч ҮАБЗ-ийг тэргүүлдэг бөгөөд Улсын Их Хурал бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг нь тогтоож²¹, Засгийн газар улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангахаар үүргийг хүлээдэг.²² Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын хэрэгжилтэд хяналт тавина хэмээн заасан бөгөөд эндээс энэхүү баримт бичиг нь ҮАБЗ-ийн үйл ажиллагааны чиг баримжааг тодорхойлох үндсэн баримт бичиг болохыг харж болно.

²¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.10

²² Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2.6

Ерөнхийлөгч

Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай болон холбогдох бусад хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;
- Гадаад харилцаанд Монгол Улсыг төлөөлөх;
- Зэвсэгт хүчний ерөнхий командлагч
- Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх;
- Онц байдал, дайны байдал зарлах саналаа УИХ-д өргөн барих. Дайны байдал, онц байдлын үед Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг удирдах;

Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаандаа намын харьяаллаас татгалздаг бөгөөд Ерөнхийлөгч ҮАБЗ-ийг тэргүүлж байгаа нь үндэсний аюулгүй байдлын асуудлаар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын уялдаа холбоог хангаж, үндэсний эрх ашгийг хамгаалах, үндэсний эв нэгдлийг хангах шаардлагаас үүдэлтэй.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүнийг хуулиар тогтоосон байдаг ч онц байдал, дайны байдлын үед зарим яам, агентлагийн удирдлагыг оролцуулан өргөтгөж үндэсний аюулгүй байдлын хороо болгох саналаа УИХ-д оруулахыг Монгол Улсын Ерөнхийлөгчид үүрэг болгосон, харин бусад цагт ерөнхийлөгч энэ талаарх саналаа УИХ-д оруулж шийдвэрлүүлж болох боломжийг хуулиар нээлттэй үлдээсэн байдаг.

Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа тасралтгүй, харилцан уялдаатай байх ёстой. Ялангуяа онц байдал, дайны байдал үүссэн үед улс орны ард иргэд, төр, төрийн болон бусад байгууллага харилцан уялдаатай хамтран ажиллах, нэгдмэл үйл ажиллагаанд шуурхай шилжиж, улсын хязгаарлагдмал нөөц бололцоо, иргэний болон батлан хамгаалах хүчин чадлыг хамгийн үр ашигтайгаар зарцуулж тулгарсан бэрхшээлийг даван туулах шаардлагатай болдог. Монгол Улсын хуулиар энэ үүргийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүлээлгэсэн.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй албадыг онцлон тусгасан байдаг. Тэдгээрийн дотор дипломат алба ч багтдаг. Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах бодлоготой улс

бөгөөд энэ ч үүднээс Ерөнхийлөгчийн гадаад харилцаанд гүйцэтгэх үүрэг өндөр байдаг. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн, гишүүдийн гадаад бодлогын асуудлаар баримтлах бодлогыг Гадаад хэргийн яам боловсруулж, ҮАБЗ хэлэлцэж баталгаажуулдаг.

Зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүрэн эрхийг эрх зүйн эх сурвалжаар нь дараах байдлаар ангилж болохоор байна. Эдгээр нь:

- Үндсэн хууль, түүнд улбаалан Онц байдал, Дайны болон Дайн бүхий байдлын тухай хуулиар олгогдсон онцгой бүрэн эрх
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиар олгогдсон бүрэн эрх зэрэг болно.

Өөрөөр хэлбэл ҮАБЗ-ийн үүргийг онцгой нөхцөл байдал, дайны цагийн болон тайван цагийн үүрэг хэмээн зааглан үзэж болно. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Онц байдлын тухай хууль²³, Дайны болон, Дайн бүхий байдлын тухай хуульд онц байдал, дайны болон дайн бүхий байдал үүссэн үед улс орны шууд удирдлага УИХ-ын шийдвэрлэснээр ҮАБЗ-д шилжихээр, харин тайван цагт ҮАБЗ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай болон, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлаар төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах үүргийг хүлээнэ.

Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл нь тайван цагт:

- үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хуулийн биелэлтийн явцыг хэлэлцэж дүгнэлт гаргах,
- үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн дотоод, гадаад, батлан хамгаалах бодлогын үндсийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон онц чухал асуудлыг шийдвэрлэх чиглэл өгөх,
- үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд онцгой ач холбогдол бүхий асуудлаар судалгаа хийх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд зааснаар тус Зөвлөл нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Өөрийн орны улс төр, нийгмийн амьдралд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг бэхжүүлэх, Үндсэн

²³ Онц байдлын тухай хууль, 8.1. Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах онцгой чиг үүргийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл эрхлэн гүйцэтгэнэ.


хуулиар тодорхойлсон төр, нийгмийн байгууллыг бататгах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах;

- Монгол Улсын үндэсний баялгийг зүй зохистой ашиглах, үндэсний технологийг хамгаалж орчин үеийн ололтоор баяжуулан хөгжүүлэх, дэлхийн аж ахуйн хэлхээ холбоонд идэвхтэй, уян хатан оролцох зэргээр эдийн засгаа дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бие даан хөгжих чадавхыг нэмэгдүүлэх;
- Үндэсний соёл иргэншил, оюуны өв уламжлал, чадавхыг хамгаалан хөгжүүлэх;
- Монгол Улсын байгалийн баялгаа эзэмших бүрэн эрх, экологийн аюулгүй байдлыг хангах;
- Гадаад орон, олон улсын байгууллагатай төр, засгийн дээд хэмжээний хэлэлцээрийн үед баримтлах чиглэл, гадаад орон, олон улсын байгууллагад тодорхой асуудлаар төр, засгийн дээд хэмжээнд байр сууриа илэрхийлэхдээ төрийн гадаад бодлогод нийцүүлж зөвлөлдөн тогтох;
- Төрийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлж, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, улс төрийн гадаад нөхцөл байдлыг харгалзан төрийн цэргийн бодлогын талаарх саналыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
- Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс олон улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, цэрэг, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодорхойлох зэрэг болно.

Зөвлөлийн зохион байгуулалт

Зөвлөлийн үйл ажиллагаа нь хуралдаан, хуулиар заасан чиг үүргийг хэрэгжүүлэх гэсэн хоёр үндсэн хэлбэртэй.

Хуралдаан гишүүд, нарийн бичгийн дарга, зөвлөх, илтгэгч, шинжээч гэсэн энгийн бүтэцтэй байна. Дараах схемээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэр гаргах үйл явцыг схемлэн харуулав.



Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газраас жил бүр төлөвлөн оруулж, Монгол Улсын Ерөнхийлөгч баталдаг. Зөвлөлөөр хэлэлцэх асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн дагуу Монгол Улсын засгийн газрын гишүүд харьяалах асуудлын хүрээнд, цагийн байдал, аюулгүй байдлын гадаад дотоод орчны өрнөлтөөс хамаарч ЗХЖШ-ын дарга, ТЕГ-ын дарга нар оруулж, илтгэх эрхтэй оролцдог.

YABZ-ийн Ажлын албанаас хэлэлцэж буй асуудлын үндэслэл, шийдвэрийн төслийн хууль зүйн үр дагаварын талаарх санал дүгнэлтээ бэлтгэн YABZ-ийн хуралдаанд оруулдаг.

Зөвлөлийн хуралдаанд УИХ-ын дэд дарга, УИХ-ын Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны дарга, УИХ дахь нам эвслийн бүлгийн дарга нар зөвлөх эрхтэйгээр оролцдог.

YABZ-ийн гурван гишүүн харилцан зөвшилцөж, санал нэгдсэн асуудлаар YABZ-ийн хуралдааны эцсийн шийдвэр буюу төрийн холбогдох байгууллагад чиглэл өгсөн Зөвлөмж гардаг.

Бодлогын шинэчлэл

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулийн үзэл санаа, үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчин нөхцөлд нийцүүлсэн олон арван бодлогын баримт бичиг, хуулиудыг батлан гаргасан. Тэдгээр эрх зүйн баримт бичгүүд үндэсний эрх ашгаа дээдлэх төрийн бодлогын үндэс суурь болж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Тэдгээрийн дотор Монгол Улсын анхны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 1994 онд батлагдсан байдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч аюулгүй байдлын гадаад, дотоод шинэ орчин нөхцөлд нийцүүлсэн аюулгүй байдлын шинэ үзэл баримтлал боловсруулах шийдвэрийг 2009 оны 12 дугаар сард гаргаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулсан байдаг. Уг ажлын хэсэг өмнө нь ҮАБЗ-ийн гишүүн байсан хүмүүс, үндэсний аюулгүй байдлын салбарын эрдэмтэн, судлаачид, холбогдох төрийн байгууллагын албан тушаалтан, УИХ-ын гишүүдийг хамарсан өргөн бүрэлдэхүүнтэй байв. Ажлын хэсгээс боловсруулсан төслийг УИХ 2010 оны 7 дугаар сард хэлэлцэн баталжээ.

Энэхүү баримт бичиг нь аюулгүй байдлын үзэл баримтлалын хувьд цогцолбор үзэл баримтлалын ангилалд хамаарах бөгөөд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал нь Оршин тогтнохуйн аюулгүй байдал, Эдийн засгийн аюулгүй байдал, Дотоод аюулгүй байдал, Хүний аюулгүй байдал, Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар шийдвэрлэгдэнэ гэж үздэг. Шинэ үзэл баримтлал нь аюулгүй байдлын үзэл баримтлалын шинэ хандлага болох Хүний аюулгүй байдлын асуудлыг дангаар нь нэг бүлэг болгон авч үзсэнээрээ, мөн Мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинээр тодорхойлсноороо онцлогтой.

Гадаад бодлогын үзэл баримтлал

2011 онд шинэчлэн батлагдсан Гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол Улсын гадаад бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлсон үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд тус улсын гадаад, дотоод нөхцөл байдал нь гадаад бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно” гэж заасан байдаг.²⁴

²⁴ Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоол.

Гадаад бодлогын үзэл баримтлалд 1990-ээд оноос баримталсаар ирсэн гадаад харилцааны олон тулгуурт бодлогоо үргэлжлүүлж, эвсэлд үл нэгдэх, нөхөрсөг хөршийн харилцааг хөгжүүлэх, хөршүүдтэйгээ тэнцвэртэй харилцах, олон тулгуурыг тэнцвэржүүлэх буюу гуравдагч хөршийн бодлогыг баримтлахыг гол чиглэлээ болгосон. Ингэхдээ өөрийн орны газар зүйн болон бусад зайлшгүй онцлогийг харгалзан үзсэн байна.

Батлан хамгаалах бодлогын үндэс

Монгол Улсын Их Хурал 1998 онд “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгийг батлан гаргасан. Уг баримт бичиг нь батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчний хөгжлийн гол чиг баримжаа болж иржээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч хөгжлийн явцад тулгамдсан асуудлууд, тухайлбал орон нутгийн хамгаалалтын эрх зүйн орчныг тодорхой болгох, батлан хамгаалах эрх ашгийн үүднээс эрүүл, боловсролтой, эх оронч үзэлтэй иргэдийг төлөвшүүлж, батлан хамгаалах асуудлаар төрийн бүх шатны болон төрийн бус байгууллага, иргэдийн хүлээх үүргийг тодорхой болгох, Монгол Улсын цэргийн байгуулал, зэвсэгт хүчний бүтцийг боловсронгуй болгох шаардлагыг харгалзан Төрийн цэргийн бодлогын үндэс баримт бичгийг “Батлан хамгаалах бодлогын үндэс” нэртэйгээр илүү өргөн хүрээг хамруулан шинэчлэн боловсруулж 2015 онд Улсын Их Хурлаар батлуулсан.²⁵ 1998 оны баримт бичигт зэвсэгт түрэмгийллээс сэрэмжлэх, түүнийг няцаахад улс орон, зэвсэгт хүчнийг бэлтгэх, ашиглахад чиглэсэн арга хэмжээнүүдийг гол болгон тусгасан бол энэхүү баримт бичигт батлан хамгаалах тогтолцооны үндсийг нэг мөр тодорхойлон, орон нутгийн хамгаалалтыг бэхжүүлж бүх нийтийн оролцоонд тулгуурласан өөрийгөө батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн бодлогыг баримталж, батлан хамгаалах асуудал улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн цогц арга хэмжээнээс бүрдэхийг тусгаснаараа онцлогтой.

²⁵ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаартогтоол.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЧЛӨГЧ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ОНЦЛОХ ХУУЛИЙН ЗААЛТУУД**

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль

§27.1. Засгийн газар Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авч, энэ тухай Ерөнхийлөгчид мэдээлж байна.

Онц байдлын тухай хууль

§8.1. Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах онцгой чиг үүргийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл эрхлэн гүйцэтгэнэ.

Батлан хамгаалах тухай хууль

§9.1.2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Дайн бүхий байдлын тухай хууль

§5.1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс дайн бүхий байдал зарлах нөхцөл бүрдсэн тухай оруулсан санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэж, дайн бүхий байдлыг зарлах эсэх талаар шийдвэр гаргана.

Дайны байдлын тухай хууль

§5.1. Дайны байдал зарлах тухай асуудлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хэлэлцэж, гаргасан шийдвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, дайны байдал зарлах эсэхийг Монгол Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.

§13.1. Монгол Улсын Их Хурал дайны байдал зарламагц Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг өргөтгөн үндэсний аюулгүй байдлын хороог байгуулна.

§13.2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо нь дайны байдлын үеийн засаглалын бүрэн эрх бүхий захиргааны удирдлагын онцгой дээд байгууллага бөгөөд батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийг хариуцна.

Дайчилгааны тухай хууль

§6.1. Дайчилгааг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч зарлана.

Тагнуулын байгууллагын тухай хууль

§16.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь шаардлагатай гэж үзвэл тагнуулын байгууллагын даргын илтгэл мэдээллийг сонсож, тэдгээртэй холбоотой үйл ажиллагаатай танилцаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тогтсоны үндсэн дээр Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар даалгавар өгнө.

Төрийн нууцын тухай хууль

§9.3. Засгийн газар төрийн нууцад хамааруулах тухай асуудлыг нарийвчлан судалж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулан 30 хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн барина.

§21.3. Төрийн нууцыг ил болгох асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд оруулна.

§ 13.1.2.a/ Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд төрийн нууцын хамгаалалтын талаар Засгийн газрын мэдээллийг сонсох, чиглэл өгөх, төрийн нууцыг хамгаалах талаар холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай танилцах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Дүгнэлт

Олон улсын жишгээс үзэхэд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь ихэнхдээ гүйцэтгэх засаглалын харьяа байгууллага байдаг бөгөөд Ерөнхийлөгчийн засаглалтай оронд Ерөнхийлөгч, парламентын засаглалтай оронд Ерөнхий сайд ҮАБЗ-ийг тэргүүлдэг жишиг нийтлэг байна. ҮАБЗ-ийн үндсэн үүрэг нь үндэсний аюулгүй байдлыг хангах Засгийн газрын байгууллагуудын ажлын уялдааг хангахад оршдог. ҮАБЗ-ийн шийдвэрийн хувьд Туркт сайд нарын зөвлөл, ОХУ-д Ерөнхийлөгч, Казахстанд Зөвлөл баталсан тохиолдолд, заавал хэрэгжих, бусад улсад зөвлөмжийн шинжтэй байна.

Харин Монгол Улсын хувьд парламентын засаглалтай орон боловч, ҮАБЗ-ийн тэргүүн нь Ерөнхийлөгч боловч ҮАБЗ нь гүйцэтгэх эрх мэдлийн бүтцэд хамаардаггүй, Зөвлөлийн гишүүдэд Ерөнхий сайдаас бусад Засгийн газрын гишүүд багтдаггүй онцлогтой. Мөн Зөвлөлийн шийдвэр нь зөвлөмжийн шинж чанартай боловч төрийн бүхий л байгууллагууд хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг тогтоосон хугацаанд хариу мэдээлэх үүрэгтэйгээс харахад заавал хэрэгжих шинжтэй болох нь харагдана.

Монгол Улсын Үндсэн хуульд Зөвлөлийн тэргүүн нь Ерөнхийлөгч байна гэж заасан ч Улсын Их Хурал бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг нь тогтоох тул хууль батлахдаа Ерөнхийлөгч нь Зөвлөлийн тэргүүн байдаг парламентын засаглалтай бусад улсын адил гишүүдэд холбогдох сайд, агентлагийн дарга нарыг багтааж, Зөвлөл нь Ерөнхий сайд болон бусад сайд нарт зөвлөх чиг үүрэгтэй бөгөөд зөвлөмжийн хэлбэртэй гаргасан шийдвэрийг нь Засгийн газрын хуралдаанаар баталсан тохиолдолд хэрэгждэг байхаар зохицуулж болох юм.

Т. Наранхүү

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛ

Монгол Улсын батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчний байгуулалтын онцлог, үндсэн чиг үүрэг, шинэчлэл

Эдийн засаг, цэрэг, зэвсгийн хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэх орнууд болох ОХУ, БНХАУ, Япон, БНСУ оршдог Зүүн хойд Азийн бүс нутагт орших өргөн уудам газар нутагтай, далайд гарцгүй геостратегийн байршилтай, хүн ам цөөнтэй зэрэг онцлог нь Монгол Улсын аюулгүй байдлыг нөхцөлдүүлж байдаг.

Мөн энэхүү бүс нутагт нийгэм, улс төрийн эрс тэс тогтолцоо, цэрэг, зэвсгийн тэнцвэргүй харьцаа, цөмийн зэвсгийн хөнөөлийн аюул, газар нутгийн маргаан зэрэг хүйтэн дайны үеийн уламжлалт аюулгүй байдлын сорилтууд оршоор байгаа нь улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд нөлөөлдөг гэж үзэх үндэстэй.

Монгол цэргийн өв уламжлал, түүхэн үүрэг 2225 жилийн өмнө анхны төрт улс байгуулагдсан Хүннү гүрний үеэс эхлэж, XIII зуунд оргилдоо хүрч, дэлхийн талыг эзэлж явсан баялаг түүхтэй. 1911, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараа байнгын цэргийг цөмөө болгосон нийт иргэний оролцоотой шинэ үеийн батлан хамгаалах тогтолцооны үндэс тавигдаж,²⁶ орчин цагийн зэвсэгт хүчинтэй болсон гэж үздэг. 1990-ээд он хүртэлх Монголын зэвсэгт хүчний хөгжил, шинэчлэл нь хуучин Зөвлөлт Холбоот Улстай салшгүй холбоотой. Энэ хугацаанд хоёр орны Засгийн газар хооронд байгуулсан найрамдал, хамтын ажиллагааны гэрээ, протоколын дагуу Монголын зэвсэгт хүчин морьт цэргээс, мотобуудлагын цэрэг болж, хоёр орны цэргүүд мөр зэрэгцэн 1939 оны Халхголын, 1945 оны чөлөөлөх дайнд оролцсон. 1939 онд Монголын зүүн хязгаар нутгаар Халхголд Японы эзлэн түрэмгийлэгчид дайран орж ирснээр Дэлхийн II дайны эхлэл тавигдсан гэж зарим судлаачид үздэг²⁷ нь үнэмшилтэй.

Дайны жилүүдэд (1939-1945) зэвсэгт хүчин байлдааны чадавх эрс дээшилж, зэвсэглэл, техникт чанарын өөрчлөлт гарсан ч дайны дараагаар тухайн үеийн бүтцийг үе шаттайгаар (1945-1954) цомхотгох арга хэмжээг

²⁶ Н.Жалбажав, Монгол Улсын иргэдийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх тогтолцоо, түүний сургалт бэлтгэлийн агуулга, 2014.

²⁷ Р.Болд, Зарлаагүй дайн, 2014Н.Хишигт, Т.Эрдэнэхишиг, Цэргийн гадаад харилцаа, Хорьдугаар зууны Монгол цэрэг, 2001.

хэрэгжүүлсэн байдаг.²⁸ Гэвч хүйтэн дайны сөргөлдөөн идэвхжсэн 1950-иад оны дунд үеэс 1980-аад оны төгсгөл хүртэл зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулж, орчин үеийн зэвсэглэлээр хангах, бие бүрэлдэхүүний байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч байв.

1990-ээд оноос Монгол Улс ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжиж, аюулгүй байдлаа хангах, батлан хамгаалах асуудалдаа бие даасан байр сууриас хандах, өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчнийг бүрдүүлж, хөгжүүлэх шаардлага гарч, эдийн засаг, нийгмийн цогц шинэчлэлийг өрнүүлсэн билээ. Улс орны эдийн засгийн байдал хүндхэн байсантай холбогдуулан зэвсэгт хүчний бүтцийг цомхотгох шаардлага ч тулгарсан. Батлан хамгаалах салбарын шинэчлэл нь эрх зүйн үндсээ бүрдүүлэх, хүйтэн дайны дараах үед улс орныг батлан хамгаалах бодлого, зорилтоо шинээр тодорхойлох, зэвсэгт хүчнийг шинэчлэх, цэргийн итгэлцлийг эрхэмлэсэн батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг бий болгоход чиглэгдэж байв.

Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн гэж үздэг.

Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр захиргааны байгууллагууд болон нийт иргэний оролцоонд тулгуурласан **орон нутгийн хамгаалалт**, мэргэжлийн цэрэгт суурилсан **зэвсэгт хүчин**, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий **дайчилгаа** болно.²⁹

Орон нутгийн хамгаалалт

Орон нутгийн хамгаалалтыг төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурлан зохион байгуулж, уялдуулах нь төвөгтэй хийгээд нүсэр үйл ажиллагаа. Энэ нь дан ганц батлан хамгаалах салбарын асуудал биш, төр, захиргааны байгууллага, нийт иргэний идэвхтэй дэмжлэг, оролцоо, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын нягт харилцан ажиллагаанаас шалтгаалах улс төр, нийгэм, эдийн засаг, оюун санааны нэгдмэл үйл ажиллагаа болдог.

²⁸ Ш.Паламдорж, Цэргийн шинэчлэл ба нийгмийн хөгжил, Хорьдугаар зууны Монгол цэрэг, 2001.

²⁹ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоол.

Орон нутгийн хамгаалалтын зарчим, удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, дэд бүтцийг дайчилгааны сургалт явуулах болон нөөц бүрдүүлэх тогтолцоотой уялдсан байх эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлж байна. Ингэснээр орон нутгийн хамгаалалтын болон дайчилгааны сургалт бэлтгэл нь нэгдсэн төлөвлөлтөөр явагддаг, дайчилгааны нөөц бүрдүүлэх тогтсон журамтай байх, гамшиг, ослын үед хөнөөлийг арилгах томилгоот бүлгүүд бэлтгэгдсэн байх, шаардлагатай техник хэрэгслүүд нь оногдуулан данслагдсан байх, хөрш зэргэлдээ ижил төстэй нэгжүүдтэй харилцан ажиллагааны төлөвлөлтөө тодотгосон байх, удирдлага, мэдээллийн нэгдсэн тогтолцоотой байх зэрэг цогц асуудлыг шийдвэрлэх боломжтой болно.

Олон улсын болон улс төр, эдийн засгийн харилцаа улам нээлттэй болж, эдийн засгийн чөлөөт бүс, дамжин өнгөрөх транзит шугамууд нээгдэж, гадаадын хөрөнгө оруулалт, хил дамнасан гэмт хэрэг, зөрчил нэмэгдэж, байгаль цаг уур, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэл оршсоор, хот суурин газар руу чиглэсэн хөдөлгөөн буураагүй байгаа өнөө үед орон нутгийн хамгаалалтыг хэрэгжүүлснээр улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал тодорхой хэмжээгээр баталгаажиж, хөдөө, орон нутгийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн боломж бүрдэнэ гэж үздэг.

Хэдийгээр хүн ам цөөнтэй, өргөн уудам газар нутагтай ард түмний хувьд орон нутгаа хамгаалах, дайчилгаагаар цэрэг засах, дайнд мордох нь нүүдлийн соёлтой Монгол түмний амьдралд дадсан үйл байсан. Гагцхүү өнөөгийн нийгмийн харилцаа, тогтолцоо, эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн орон нутгийн хамгаалалтыг үндсээр нь цогцлох, төлөвшүүлэх шаардлага байгаа тул энэхүү харилцааг зохицуулах Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн бүр эх орноо хамгаалах, цэргийн алба хаах үүрэгтэй бөгөөд 18-25 насандаа хугацаат цэргийн албыг 12 сарын хугацаанд биеэр хаах, эсвэл дүйцүүлэн хаах боломжтой. Бүх нийтээр цэргийн алба хаах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд цэргийн албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаах, гэрээт цэргийн алба хаах, их, дээд сургуулийн оюутан суралцаж байх хугацаандаа цэргийн сургалт бэлтгэлд хамрагдах боломж нь хууль, тогтоомжоор нээлттэй. 45-60 настай офицер, ахлагч, 18-45 настай цэргийн жинхэнэ албанд тэнцэх иргэнийг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнд тооцдог.

Хэдийгээр Монгол Улс хугацаат цэргийн албатай ч гэсэн мэргэжлийн цэрэгт суурилсан өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй.

Монгол Улсын зэвсэгт хүчин нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах үндсэн чиг үүргээс гадна эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах бэлтгэлийг хангах, улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх, агаарын орон зай, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих, хамгаалах, гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургах, хүн амыг цэргийн хэрэгт сургахад дэмжлэг үзүүлэх, байлдааны зэвсэг, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтад дэмжлэг үзүүлэх, улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд туслах, энхийг дэмжих ажиллагаанд оролцох, улс орныг хөгжүүлэх бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Төрийн цэргийн байгууллын бүрэлдэхүүн болох зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага, тагнуулын байгууллага нь цэргийн нийтлэг дүрмүүдийг дагаж мөрдөх, сургалт бэлтгэлээ хангах, цэргийн алба хаагчийн эрх зүйн хэм хэмжээгээр олгогдсон эрх үүргийг хэрэгжүүлэх, улс орныг батлан хамгаалах үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудлаараа нэгдмэл байх зохицуулалттай. Тайван цагт дээрх байгууллагуудын төрийн захиргааны удирдлагыг салбарын яамд нь хариуцаж, бие даасан үүрэг гүйцэтгэнэ. Улс орны хэмжээнд онцгой нөхцөл байдал үүсэх үед болон дайны байдлын үед хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэнэ.

Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг болон төрөл мэргэжлийн бусад цэргээс бүрддэг. Зэвсэгт хүчний Жанжин штабын бүтцэд төрлийн цэргийн командлалууд, тэдгээрийн удирдлагад байх бригадын зохион байгуулалттай төрөл мэргэжлийн цэргийн нэгтгэл, анги, байгууллагууд байна. Батлан хамгаалах салбарын харьяанд цэргийн сургууль, цэргийн урлаг соёлын байгууллага, цэргийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, цэргийн эмнэлэг, архив байдаг.

Зэвсэгт хүчний шинэчлэлийг тодорхой цаг үед, улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах хэрэгцээ, шаардлагад тулгуурлан тогтмол хэрэгжүүлж ирсэн. 1990-ээд оноос өмнө үндсэндээ ЗХУ-ын тусламжаар зэвсэгт хүчний шинэчлэл хэрэгждэг байв. Харин зах зээлийн

эдийн засаг бүхий ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэнээр улсыг батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний шинэчлэлийг өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчнийг бүрдүүлэх шаардлага тулгарсан. Монгол Улс зэвсэгт хүчний бүтэц зохион байгуулалтын шинэчлэлийг гүйцэтгэх үүрэгт нь нийцүүлэн тухай бүр, зэвсэглэл, техникийн шинэчлэлийг эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Батлан хамгаалах салбарт тогтоосон хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд зарим орноос хүлээн авсан зэвсэглэл, тээврийн болон инженерийн техник хэрэгсэл, материал хэрэглэлийн буцалтгүй тусламж нь зэвсэгт хүчний шинэчлэлд дэмжлэг болж байдаг.

1998 онд батлагдсан Төрийн цэргийн бодлогын үндэс баримт бичигт Зэвсэгт хүчин нь тайван цагт “Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын энхийг сахиулах хүчний хүрээнд үүрэг гүйцэтгэх, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх” үүрэг хүлээхээр тунхаглаж, 2002 онд батлагдсан Зэвсэгт хүчний тухай хууль³⁰, Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох тухай хуулиар³¹ баталгаажиж, улмаар Монгол Улсын зэвсэгт хүчин олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажиллагаанд идэвхтэй оролцох болов. Ингэснээр Монголын зэвсэгт хүчний бүрэлдэхүүн 1945 оноос хойш анх удаа гадаад оронд олон улсын цэргийн ажиллагаанд оролцож, даян дэлхийн энхийн үйлст хувь нэмрээ оруулах болсон.

Хэдийгээр 1990-ээд оны дунд үеэс олон улсын аюулгүй байдлыг сахих хамгаалах үүрэг бүхий НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох санаачлага гарсан ч эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, дээрх ажиллагаанд оролцуулах бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах, мэргэжлийн болон сэтгэл зүй, бие бялдарын бэлтгэлийг хангах, түүнчлэн тэдний ар гэр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг асуудлууд тулгарч байв. Мөн үүрэг гүйцэтгэхэд хэрэгцээтэй техник, материал хэрэгслээр хангах шаардлага ч байв. Дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд төр, засгийн дэмжлэг, батлан хамгаалахын салбарт харилцаа, хамтын ажиллагаатай орнуудын туслалцаа их байсныг тэмдэглэх хэрэгтэй. Монгол Улсын зэвсэгт хүчний бүрэлдэхүүн энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт, дадлагад 1999 оноос, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2002 оноос, олон улсын эвслийн цэргийн ажиллагаанд 2003 оноос оролцож эхэлсэн.

³⁰ Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны 10 дугаар сард Улсын Их Хурлаар батлагдсан.

³¹ Уг хуулийг 2010 онд “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль” болгож, шинэчлэн баталсан.

Монгол Улсын зэвсэгт хүчний НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоо жил ирэх тусам нэмэгдэж, хүрээгээ тэлсээр байгаа. 2002 оноос хойш дэлхийн 14 улсад явагдсан 16 энхийг дэмжих ажиллагаанд давхардсан тоогоор 12600 гаруй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэжээ. Өнөөдрийн байдлаар Афганистан Улсад явагдаж байгаа НАТО-гийн тэргүүлсэн олон улсын эвслийн цэргийн ажиллагаанд 346, АНУ-ын Төвийн командлалын төлөвлөлтийн бүлэгт 3, НҮБ-ын энхийг сахиулах 6 ажиллагаанд 895, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газрын цэргийн зөвлөх 1, НҮБ-ын ЭСАГ-ын Цэргийн харилцааны хэлтэст 1, нийт 1185 цэргийн алба хаагч даян дэлхийн энхийн үйлст Монгол Улсаа төлөөлөн үүрэг гүйцэтгэж байна. /хавсралт 2/

Монголын цэргийн алба хаагчдын хувьд байгаль цаг уурын ямар ч нөхцөлд, хаана ч дасан зохицож, үүрэг гүйцэтгэх чадвартай, өндөр сахилга, зохион байгуулалттай үүрэг гүйцэтгэдэг талаар НҮБ болон хамтарч энхийг дэмжих ажиллагаанд оролцсон улс орны цэргийн багуудын удирдлагаас талархал хүлээдэг болсон нь өнгөрсөн 14 жилийн хичээл зүтгэлийн үр дүн гэж үздэг.

Энхийг дэмжих ажиллагаанд амжилттай оролцох үндэс нь бие бүрэлдэхүүний байнгын сургалт, бэлтгэл байдаг. Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөтгөж, бүс нутгийн энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв болгосноор зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний энхийг дэмжих, хүмүүнлэгийн ажиллагаанд оролцох цэргийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арав гаран хоёр талын болон олон улсын сургалт, дадлагыг жил бүр тогтмол зохион байгуулж байна. Зөвхөн 2015 онд нийт 12 олон улсын болон хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулжээ. Эдгээрт:

- “Хааны эрэлд-2015” олон улсын энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургалт, дадлагыг Номхон далай дахь АНУ-ын Тэнгисийн явган цэргийн командлалтай,
- Тусгай хүчний ангиудын хамтарсан «Баланс межик – 2015 - 1” 3 дахь удаагийн хээрийн сургалт, дадлагыг АНУ-тай,
- “Сэлэнгэ - 2015” байлдааны буудлагатай хамтарсан тактикийн хээрийн сургуулийг ОХУ-тай,
- Тусгай хүчний хамтарсан “Анчин бүргэд - 2015” хээрийн сургуулийг БНХАУ-тай,
- Тусгай хүчний бүлгүүдийн хамтарсан “Нүүдэлчин дайчид - 2015” хээрийн сургуулийг БНТУ-тай,

- “Зам - 2015” инженерийн сургалт, дадлагыг Япон Улстай,
- “Шийдэмгий шийдвэр - 11” энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургалт, дадлагыг Катар Улстай,
- “Нүүдэлчин заан - 2015” хээрийн сургалт, дадлагыг БНЭУ-тай,
- НҮБ-ын цэргийн ажиглагч офицерын дамжаа, НҮБ-ын ар талын офицерын дамжааг АНУ-ын Дэлхийн энхийн санаачилга хөтөлбөртэй тус тус хамтран зохион байгуулж,
- Гадаад улсад зохион байгуулагдсан сургалт, дадлагуудад
- Малайз Улсад явагдсан “Энхийн Илд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургалт, дадлага,
- Тажикстан Улсын Душанбе хотод явагдсан “Бүс нутгийн хамтын ажиллагаа - 2015” энхийг дэмжих ажиллагааны Команд штабын сургуульд Монгол Улсын зэвсэгт хүчний бүрэлдэхүүн тус тус оролцсон байна.

Монгол Улс 2003 оны 11 дүгээр сараас “НАТО-гийн Аюулгүй байдлыг дэмжих олон улсын цэргийн хүчний ажиллагаа” (ISAF)-нд сургалтын хөдөлгөөнт багуудыг илгээх замаар оролцож эхэлсэн ба 2008 оноос оролцоогоо өргөжүүлж өнөөг хүртэл нисдэг тэрэгний сургалт, засварын баг, цэргийн баазын харуул, хамгаалалтын баг илгээсээр байна. Мөн Косовод явагдсан НАТО-гийн тэргүүлсэн энхийг сахиулах ажиллагаа (KFOR)-нд Монгол Улс 2005-2007 онд оролцсон.

Өмнөх Төрийн цэргийн бодлогын үндэс баримт бичгийг хэрэгжүүлсэн 17 жилийн хугацаанд Монгол Улс мэргэжлийн чиг баримжаатай зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд анхаарч ирсэн бол дараагийн 10 жилд олон улсын цэргийн хэрэгт гарч буй өөрчлөлт, хөгжил, улс орныг батлан хамгаалах шаардлагад нийцсэн, байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх бэлэн байдлын зохих шаардлага хангасан бүтэц бүрэлдэхүүн бүхий, гүйцэтгэх үүрэгтээ тохирсон зэвсэглэл, техниктэй мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд төрийн бодлогоо чиглүүлж, түүнийг дэмжсэн эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлж байна.

Цаашид мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлэхийн тулд цэргийн хэргийн хөгжил, технологийн хурдацтай өөрчлөлт, техникийн дэвшлийг дагаад зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хөнгөн хуягласан маневрлаг, туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл, бага оврын нисдэг тэрэг, нам өндөрт хяналт явуулах нисгэгчгүй нисдэг аппарат, нууцлал бүхий холбоо, мэдээллийн хэрэгслээр хангах шаардлага тавигдаж байна.

Нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа

Бүс нутгийн аюулгүй байдлын огцом өөрчлөлт, онц байдал, хямралт нөхцөл үүссэн үед улс орон, орон нутаг, эдийн засаг, нийгмийг богино хугацаанд, хүндрэлгүйгээр, эсхүл бага хохиролтойгоор нөхцөл байдлаас авч гарах, нөөцийг дахин хуваарилах, эдийн засаг, нийгмийг шуурхай тогтворжуулах цогц арга хэмжээг тайван цагт төлөвлөн, хэрэгжүүлэхэд нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа чухал үүрэгтэй.

Дайчилгааны төлөвлөлтөд статистикийн албан ёсны мэдээлэл, зэвсэгт хүчний захиалга, даалгавар, хүн амын бодит хэрэгцээнд тулгуурлан эдийн засаг, нийгмийн бүхий л салбарыг хамруулан зэвсэгт хүчний хэрэгцээг хангах; хүн амын хүнс, хувцас, өргөн хэрэглээний барааны хэрэгцээ, түүний хангалтыг зохион байгуулах; эрүүл мэндийн хэрэгцээг хангах; хүн амын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн хэрэгцээг хангах; боловсрол, соёл, шинжлэх ухааны хэрэгцээг хангах; дэд бүтцийн хэрэгцээг хангах; төсөв, санхүү, мөнгөний хэрэгцээг хангах асуудлыг тооцдог.

Дайчилгааны тухай хуулийн дагуу дайчилгааны бэлэн байдлыг хангах цэрэг-стратегийн сургалтыг бүх сумдын засаг дарга, аймаг нийслэлийн засаг дарга, аймаг нийслэлийн ИТХ-ын дарга, яамдын дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нартай Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төв болон Дорнод аймгийн Халх гол сум, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Орхон аймгуудад тус тус бүсчлэн зохион байгуулж байна. Сургалтаар албан тушаалтнууд батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаатай танилцаад зогсохгүй дайчилгааны үед төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын харилцан ажиллагаа, үүрэг, холбогдох бусад журмыг судалдаг.

Батлан хамгаалах эрх зүйн шинэчлэл

Монгол Улс хүмүүнлэг, ардчилсан эрх зүйт төрийг цогцлоох үйлсийг 1990-ээд оноос эхэлж, улс төр, нийгэм, эдийн засгийн олон талт шинэчлэлийг хэрэгжүүлэн аюулгүй байдлаа хангах, улс орноо батлан хамгаалах асуудлаа бие даан шийдвэрлэх болсноор эдүгээ 25 жил болжээ. Батлан хамгаалах эрх зүйн шинэчлэл чухам энэ л үеэс эхэлж, эрх зүйн тулгуур баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна.

1992 онд баталсан шинэ Үндсэн хуульд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн», «Монгол Улс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй

байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно» хэмээн тунхаглаж, эдгээрт нийцүүлэн Монгол Улсын батлан хамгаалах салбарын эрх зүйн үндэс боловсруулагдсан. Энэхүү шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн боловсруулагдсан батлан хамгаалах салбарын хууль, тогтоомжууд, тэдгээрээр зохицуулж байсан харилцаа, үйл ажиллагааны хүрээнд үе үеийн төр, засаг тухайн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангасан эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлж, тэдгээр нь дэвшилттэй, зарим талаар дутагдалтай байсан хэдий ч зэвсэгт хүчний хөгжлийг өнөөгийн төвшинд хүргэхэд түүхэн үүргээ бүрэн гүйцэтгэсэн гэж үзэх үндэстэй.

УИХ-аар 1994 онд баталсан “Цэргийн номлол” нь улс орныхоо аюулгүй байдлын шинэ нөхцөл, цаашдын төлөвт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр батлан хамгаалахын зорилго, түүнд хүрэх арга замыг зарим талаар тодорхойлсон ч, тэдгээрийг хэрэгжүүлэх нөөцийг бүрэн тодорхойлоогүй нь түүнийг хэрэгжүүлэх явцад хүндрэл, бэрхшээлтэй болгож байв.

Дээрх бодлогын баримт бичгийг сайжруулан, аливаа зэвсэгт түрэмгийлэлд төрөөс хандах хандлагыг тодорхойлох, дайн, зэвсэгт мөргөлдөөний аюулаас сэрэмжлэх, улс орноо гадны зэвсэгт түрэмгийллээс хамгаалах, цэргийн байгуулалт, зэвсэгт тэмцэл явуулах талаар төрөөс баримтлах үзэл баримтлалыг “Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичигт тусгаж, 1998 онд баталсан. Ингэснээр батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны үндэс тавигдсан ч түүнийг хэрэгжүүлэх нөөц, арга хэрэгсэл, стратегийг тодорхойлсон, дараагийн шатны баримт бичиг үгүйлэгдэж, хэрэгжилтийг тооцох, түүндээ хяналт үнэлгээ хийх, шинэчлэн сайжруулах тогтолцоог бий болгох шаардлага гарсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч 2000 онд «Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр»-ийг баталж, түүнд батлан хамгаалах стратегийн дунд хугацааны зорилтуудыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх чиглэлийг заасан ч, түүнд шаардагдах нөөцийн асуудлыг шийдвэрлэж чадаагүй нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байв. 2006 онд дээрх хөтөлбөрийг шинэчилж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч «Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр»-ийг баталж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газраас баталснаар батлан хамгаалах салбарын дунд хугацааны бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга

зам, нөөц тодорхойлогдох нөхцөл бүрдсэн. Гэсэн хэдий ч улс орны эдийн нөхцөл байдлаас шалтгаалан уг хөтөлбөрт тусгагдсан зарим зорилт, арга хэмжээг санхүүжүүлэх боломжгүй болж байсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлал, батлан хамгаалах бодлогын үндэс зэрэг төрөөс баримтлах бодлого, үзэл баримтлалыг баталгаажуулж, тэдгээрт нийцүүлэн Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай, Дайны байдлын тухай, Дайчилгааны тухай, Монгол Улсын хилийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай зэрэг салбарын үндсэн хуулиуд батлагдаж, батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчин, тэдгээртэй холбогдох харилцааг зохицуулж байна.

Эдгээр хууль тогтоомжид батлан хамгаалахын удирдлага, тогтолцоо, зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон байдаг. Тухайлбал, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал нь хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох, төсөв батлах, улсын хил тогтоох, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох, цэргийн дээд цол бий болгох, Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, дайн бүхий байдал зарлах, цуцлах, онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох, дайны байдал зарлах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч бөгөөд Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч нь цэргийн дээд цол хүртээх, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх, бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах, цэрэг хөдөлгөх захирамж өгөх эрхтэй. Харин төрийн гүйцэтгэх дээд байгууллага болох Засгийн газар нь хууль хэрэгжүүлэх, улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах, төсвийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг биелүүлэх эрхийг хэрэгжүүлнэ.

1992 онд баталсан “Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-аар Үндсэн хуулиар хүлээсэн иргэний журамт үүргээ ёсчлон биелүүлэх журам, нөхцөл, цэргийн албаны төрөл зэрэг зохицуулалтаас гадна цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг тодотгож, хуульчилсан.

1998 оны “Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгийг нэр, агуулгын хувьд өргөжүүлж, олон улсад болон бүс нутагт тулгарч байгаа аюулгүй байдлын орчны өөрчлөлт, сорилт, чиг хандлагыг мэдэрсэн, улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлогыг тодорхойлсон “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг 2015 оны 10 дугаар сард шинэчлэн батлагдаж, түүнд нийцүүлэн Батлан хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулга, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн албаны тухай хуулиуд Улсын Их Хурлаар батлагдсан. Дараагийн шатанд тэдгээрт тусгагдсан харилцаа, зохицуулалтыг хэрэгжүүлэх журмуудыг шинэчлэн боловсруулах арга хэмжээг Засгийн газрын төвшинд хэрэгжүүлснээр салбарын эрх зүйн шинэчлэл цогц байдлаар шийдвэрлэгдэж, батлан хамгаалахын болон зэвсэгт хүчний харилцааны арав, цаашилбал хорин жилийн зохицуулалт шинэчлэгдэнэ.

Батлан хамгаалахын мэргэжлийн болон улс төрийн удирдлага, иргэн, цэргийн харилцаа, Парламентын хяналт, батлан хамгаалах төсөв, ил тод байдал

Шинэ Үндсэн хуульд нийцүүлэн Батлан хамгаалах тухай хуулийг 1993 онд, Зэвсэгт хүчний тухай хуулийг 2002 онд баталснаар батлан хамгаалахын удирдлага, зэвсэгт хүчний удирдлага, зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт зэрэг харилцаа хуульчлагдсан. Зэвсэгт хүчний тухай хуульд “Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь төрийн хууль тогтоомжийн биелэлт, зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн удирдлагын үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтыг нээлттэй, ил тод хянах үйл ажиллагаа” хэмээн анх удаа зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хуульчилсан.

1996 онд Батлан хамгаалахын сайдаар анх удаа энгийн хүн томилогдсноор зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт жинхэнэ утгаараа хэрэгжиж эхэлсэн гэж үзэх бөгөөд өнөөдөр ардчилсан орны институцийн хувьд тодорхой төвшинд төлөвшил явагдах эхлэл тавигдсан гэж болно. Бүрэн төлөвшсөн гэж үзэхгүй байна. Учир нь 1996 оноос хойш 20 жилийн хугацаанд батлан хамгаалахын сайдаар 11 энгийн улс төрчид томилогдон ажилласан байдаг. Аливаа шинэчлэлийг хэрэгжүүлэхэд бодлого, чиглэлээр тасралтгүй хангах төр, засгийн дэмжлэг, түүнийг хэрэгжүүлэх төрийн захиргааны тогтвортой удирдлага, хангалттай нөөц зайлшгүй шаардлагатай. Батлан хамгаалахын удирдлага өнгөрсөн хорь

гаран жилд дунджаар хоёр жил тутам солигдож байсан нь салбарын шинэчлэл, тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж ирсэн гэж үзэх үндэстэй.

Монгол Улсын батлан хамгаалахын удирдлагыг 2015 оны 10 дугаар сард шинэчлэгдэн батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”³² баримт бичигт нарийвчлан тодотгож, Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд “төрийн цэргийн байгууллын улс төрийн дээд удирдлагыг Монгол Улсын Их Хурал, төрийн захиргааны удирдлагыг Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалахын болон хууль зүйн сайд, цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штаб” хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Иргэн, цэргийн харилцааг хөгжүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудтай идэвхтэй харилцаж, улсыг батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа, зэвсэгт хүчний шинэчлэлийн асуудлыг нээлттэй танилцуулж, зэвсэгт хүчний хүч хэрэгслээр шаардлагатай тохиолдолд буюу цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд, эсвэл нийтийг хамарсан аюул ослын үед орон нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Тухайлбал, батлан хамгаалахын бодлого, зорилт, зэвсэгт хүчний үйл ажиллагааг хөдөө, орон нутагт танилцуулах үеэр хөдөө, орон нутгийн иргэд салбарын бодлого, үйл ажиллагаатай танилцаад зогсохгүй, цэргийн урлаг, соёлын үйлчилгээ авах, цэргийн эмнэлгийн үзлэг, оношлогоонд хамрагдах, тухайн орон нутагт нэн тэргүүнд шаардлагатай байгаа бага хэмжээний бүтээн байгуулалт, засвар тохижилтын ажлыг гүйцэтгэхэд нь туслах зэргээр бодитой дэмжлэг үзүүлдэг.

Мөн дээрх хуулиудын хүрээнд зэвсэгт хүчинд тавих хяналтыг хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээ нь Улсын Их Хурал /Парламент/-аас батлан хамгаалахын бодлого, төсвийг батлах үйл ажиллагаа болдог. Төсөв батлах үйл ажиллагаа нь Төсвийн тухай хуулиар зохицуулагддаг.


1990-ээд он хүртэл батлан хамгаалах зардлын ихэнх хэсгийг ЗХУ-ын буцалтгүй тусламжаар бүрдүүлж байв.³³ Гаднаас үзүүлж байсан тусламж зогсож, улс орны эдийн засгийн байдал хүндрэхийн хирээр өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчнээ бүрдүүлэх, хөгжүүлэх, шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, ялангуяа тэдгээрийг төсөв, хөрөнгөөр дэмжих эн тэргүүний тулгамдсан асуудал болж байв.

³² Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоол.

³³ Батлан хамгаалахын цагаан ном, 1998.

Монгол Улсын батлан хамгаалахын төсөв, зардлын хувьд улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас улбаалсан хуваарилалтыг аюулгүй байдал, батлан хамгаалахын асуудлыг онцгойлж үзэлгүйгээр, нийгмийн бусад салбаруудтай адилтган, өдөр тутмын үйл ажиллагааныхаа хувьд санхүүжигдэж ирсэн.

Гэсэн хэдий ч хуваарилагдсан төсөв, хөрөнгөөрөө шинэчлэлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, илүү үр ашигтай, оновчтой хуваарилах шаардлагатай байгаа. Дараах графикуудаар сүүлийн 10 жилийн Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ий өсөлт, батлан хамгаалах салбарын төсөв, хөрөнгө оруулалтын хуваарилалтыг харьцуулах боломжтойгоор зэрэгцүүлэв.



Дээрх графикаас харахад ДНБ-ий дундаж өсөлт нь хэдийгээр өнгөрсөн 10 жилийн хугацаанд тогтмол шугаман өсөлттэй /дунджаар 9,4%/ байгаа ч харьцангуй савалгаатай байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн тогтмол өсөлт гэхээсээ илүүтэй, нэг салбараас хараат, тухайлбал, уул уурхайн салбарт дээрх хугацаанд эрчимтэйгээр оруулсан гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн, Монгол Улсын эскпортлож буй эрдэс баялгийн дэлхийн зах зээл дээрх үнэ тогтмол өсч байсантай холбоотой байна. Үүний нотолгоо нь 2008 онд дэлхийн эдийн засаг хямрахад Монгол Улсын 2009 оны ДНБ-ий өсөлт -1,3% болж огцом унасан. Тэгэхлээр Монгол Улсын эдийн засаг нь өөрөө дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, түүхий эдийн ханшаас хамааралтай байх эрсдэлтэй байдаг. Хэдийгээр Монгол Улсын батлан хамгаалах төсөв 1990-ээд оны үеийхээс /ДНБ-ий 2.6 хувь/ буурсан ч сүүлийн арваад жилийн хугацаанд тогтмол өсөлттэй байна.



Улс орнуудын цэргийн зардлын хэмжээг тухайн улсын ДНБ-д эзлэх хувь хэмжээгээр, мөн нэг хүнд ноогдох цэргийн зардлын дундаж хэмжээгээр / дэлхийн дундаж 249 ам.долл/³⁴ тооцдог. Улс орнуудын цэргийн зардлын хэмжээ тухайн улсын ДНБ-д эзлэх хувь хэмжээгээр 10.32 /Өмнөд Судан/ - 0.00 /

Исланд/ хувьтай байгаа бөгөөд энэ жагсаалтанд Монгол Улс 1.12 хувьтайгаар 92 дугаар байранд байна.³⁵ Харин нэг хүнд ноогдох цэргийн зардал Монгол Улсад 2015 онд 34 ам.дол /2015 оны батлан хамгаалахын зардал 201.3 тэрбум төгрөг, нийт хүн ам 3.0 сая, 1 ам.долл 1940 төгрөг/ байна.

Батлан хамгаалах салбарт хуваарилсан төсвийн хувь хэмжээ нэмэгдсэн хэдий ч энэ нь олон улсын жишиг үзүүлэлтээс нилээн доогуур, Зэвсэгт хүчний шинэчлэлийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх хэмжээнд хүрэхгүй байгаа.

Бодлогын хувьд “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”, “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр” гээд дотроо олон дэд төслүүдийг багтаасан салбарын хөгжлийн томоохон хөтөлбөр, төслүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын төвшинд батлуулж, хэрэгжүүлэхээр өнгөрсөн 10 гаруй жил ажилласан. Бүхий л төвшинд дэмжээд хөтөлбөр, төслийг нь баталсан боловч, төсвийн бодлогоор дэмжээгүй учраас зарим дэд төслүүд нь хуваарилсан төсөв, хөрөнгөгүйгээс хэрэгжилт нь зогссон.

Энэ хүндрэлийг “Зэвсэгт хүчнийг 2030 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр” боловсруулахдаа тооцох нь чухал байна. Зэвсэгт хүчний шинэчлэл, хөгжил, дэвшлийн үндэс суурь нь туршилт, судалгаа шинжилгээ болох тул эдгээр асуудлыг шинэ бодлого, төлөвлөлт, төсвийн төлөвлөлтөд нэмэгдүүлэх шаардлагатай. Барууны орнууд туршилт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилдаа салбарын төсвийнхөө 10 орчим хувийг (АНУ-14%, ИБУИНВУ-5%, Япон-7%) зарцуулдаг байхад манайд энэ нь туйлын хангалтгүй буюу 1% орчим байдаг нь хангалтгүй.

³⁴ Anup Shah, World Military Expense, 2013 оны 6 дугаар сар. <http://www.globalissues.org/article/75/world-military-spending>

³⁵ Дэлхийн улс орнуудын статистик, АНУ-ын ТТГ-ын цахим хуудас. <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/rankorder/2034rank.html>

Монгол Улсад төсвийн ил тод байдлын тухай байдлыг Шилэн дансны тухай хуулиар зохицуулдаг. Батлан хамгаалахын төсөв нь батлагдсан дүнгээрээ ил мэдээлэгддэг ч зардлын ангилал, төрөл нь нууцын зэрэглэлд хамаарагддаг. Монгол Улсын хувьд бусдын анхаарлыг татахуйц төсөв, хөрөнгийг батлан хамгаалах болон цэрэг, зэвсгийн шинэчлэлд зарцуулдаггүй, батлан хамгаалахын төсвийн 80 гаруй хувь нь урсгал зардалд хамаарагддаг.

Мөн Улсын Их Хурлаас хууль тогтоох, төрөөс баримтлах бодлого батлах, төсөв батлах үйл ажиллагааныхаа хүрээнд аюулгүй байдлын болон батлан хамгаалах салбарт хяналтаа хэрэгжүүлж байгаа ч уг салбарын шинэчлэлийг хэрэгжүүлэхэд нөлөөлж буй дараах хүчин зүйлүүд байсаар байна гэж үзэж байна. Үүнд: салбарын онцлогийг тусгасан боловсруулалттай мэдээллийн хүртээмж бага, төсвийн хуваарилалтанд нийгэм, эдийн засгийн бусад салбарын эрх ашгийг аюулгүй байдлын болон батлан хамгаалах салбарынхаас өндөрт тавин төсвийг бууруулах зэрэг болно.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд³⁶ “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн”, “Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна” гэсэн үзэл санаанд нийцүүлэн Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагаа явагдаж байна.

Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа дараах бодлогын хүрээнд явагддаг. Үүнд:

- Хоёр хөрш орон, гуравдагч хөрш орнууд, бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхийг чухалчлах. Цэрэг-техникийн гадаад хамтын ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх;
- Энхийг дэмжих зорилготой Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын бусад ажиллагаанд идэвхтэй оролцож, дэлхий дахины

³⁶ Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Төрийн мэдээлэл, дугаар 08 /677/, 2011

энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах;

- Цэргийн хүч хэрэглэх болон хэрэглэхээр заналхийлэхийг зөрчил, маргааныг шийдвэрлэх арга зам гэж үзэхгүй бөгөөд аливаа хүчирхийлэл, түрэмгийллийг үл зөвшөөрөх;
- Цэргийн аюул заналхийлэл, түрэмгийлэлд өртөхөөс бусад нөхцөлд цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй байх;
- Нутаг дэвсгэрээ цөмийн болон бусад үй олноор хөнөөх зэвсгээс ангид байлгаж, хоёр хөрш болон бусад орны эсрэг чиглэсэн цэргийн үйл ажиллагаанд ашиглуулахгүй байх;
- Гадны зэвсэгт түрэмгийлэлд өртөхөөс бусад тохиолдолд дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй байх;
- Монгол Улсын хуульгүйгээр гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх;
- Үй олноор хөнөөх зэвсгийн тархалт, үндэстэн дамнасан гэмт хэрэг, олон улсын терроризмтэй тэмцэх чиглэлээр Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх зэрэг болно.

Дээрх бодлогын хүрээнд батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг дараах чиглэл, хэлбэрүүдээр хөгжүүлж байна. Үүнд:

Хамтын ажиллагааны чиглэлүүд

- Цэргийн;
- Цэрэг-техникийн;
- Цэргийн шинжлэх ухааны;
- Цэргийн эмнэлгийн;
- Соёл, спортын болон хүмүүнлэгийн.

Хамтын ажиллагааны хэлбэр

- Батлан хамгаалахын удирдлагын харилцан айлчлал;
- Цэргийн төлөөлөгч, мэргэжилтнүүдийн солилцоо;
- Зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн нийлүүлэлт;
- Цэргийн техникийн засвар үйлчилгээ;
- Цэргийн боловсон хүчний бэлтгэл, давтан бэлтгэл;
- Зөвлөлдөх уулзалт, туршлага, мэдээлэл солилцох;
- Хээрийн сургууль, цугларалт, хурал, зөвлөлгөөн, семинарт төлөөлөгч харилцан оролцуулах;
- Цэргийн хамтарсан сургууль, дадлага, семинар;
- Цэргийн сургалт, судалгааны байгууллага хоорондын харилцаа;

- Ахмад дайчдын уулзалт, түүхт газруудаар явах аялал;
- Концерт, үзэсгэлэн, кино наадам зэрэг соёл, урлаг, спортын арга хэмжээ;
- Цэргийн амрагч солилцох зэрэг болно.

1990-ээд оны эхнээс улс төрийн шинэ тогтолцоонд шилжиж, гадаад харилцаа идэвхжсэнээр Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаа өргөжиж, 2016 оны 2 дугаар сарын байдлаар 32 оронтой /хавсралт 1/ цэргийн салбарт хамтран ажиллаж байгаа бөгөөд гадаадын 5 улсын Батлан хамгаалахын болон цэргийн атташе Монгол Улсад, Монгол Улсаас гадаадын 6 улсад суугаа Элчин сайдын яаманд Батлан хамгаалахын атташе, НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт цэргийн зөвлөх байнга сууж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлж байна.

Батлан хамгаалах салбарт харилцаа, хамтын ажиллагаатай улс орнуудтай олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар харилцан ярилцаж, санал солилцох, хоёр талын харилцааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх гарц, арга замыг харилцан тохиролцох зорилгоор Батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалтыг тогтмолжуулах, харилцан айлчлалуудыг зохион байгуулах зэргээр хоёр талын харилцааг бэхжүүлэхэд онцгой анхаарч байна. Мөн хоёр талын цэргийн харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд гадаад орнуудад цэргийн боловсон хүчнийг бэлтгэх, энхийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах, хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах зэрэг хамтын ажиллагааны уламжлалт чиглэлүүдээс гадна цэргийн инженер, эмнэлэг, тусгай хүчний болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх талаар сүүлийн жилүүдэд идэвхтэй ажиллаж байгаа.

Монгол Улсын хувьд ОХУ-тай батлан хамгаалах салбарт онцгой харилцаатай. Учир нь Монгол Улсын зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник, хэрэгсэл нь үндсэндээ ЗХУ-д үйлдвэрлэсэн, 1990-ээд оноос өмнөх хоёр орны найрамдалт харилцааны шугамаар ЗХУ-аас буцалтгүй тусламжаар ирсэн байдаг.

Хоёр хөрш оронтой сайн хөршийн, тэнцвэртэй харилцаа хөгжүүлэх Гадаад бодлогын үзэл баримтлалд тулгуурлан БНХАУ-тай батлан хамгаалах салбарт хамтран ажиллаж байна. Монгол Улс нь БНХАУ-аас зэвсэг авдаггүй, харин барилга, инженерийн техник хэрэгсэл авах, Монгол Улсын цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг дэмжих чиглэлд хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд өргөжиж байгаа.

Мөн Гадаад бодлогын үзэл баримтлалд тусгагдсан “гуравдагч хөрш”-тэй харилцах түншлэлийн бодлогын хүрээнд бусад оронтой батлан хамгаалах салбарт адил, тэгш, Монгол Улсын зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлого, үйл ажиллагааг дэмжсэн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

1996 оноос хойш Монгол Улс НАТО-гийн Энхийн төлөө түншлэл / Partnership for Peace/ хөтөлбөрт хамрагдах асуудлыг тавьж,³⁷ НАТО-гийн гишүүн орнуудтай харилцах харилцаагаа идэвхжүүлсэн. 2003 оноос Бельгийн Вант Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Люксембургийн Вант Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Польш Улс зэрэг НАТО-гийн гишүүн орнуудтай цэргийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, Ирак, Афганистан, Косово зэрэг улсуудад явагдсан энхийг сахиулах ажиллагаанд хамтран оролцох болсноор Монгол Улсын Зэвсэгт хүчин олон улсад танигдаж эхэлсэн.

Улмаар НАТО-гийн сайд нарын 2011 оны Берлиний уулзалтаар НАТО-гийн “Даян дэлхийн түншлэл” хөтөлбөрийг шинэ агуулгаар баяжуулснаар Монгол Улс, НАТО хоорондын “Түншлэл, хамтын ажиллагааны тусгай хөтөлбөр”-ийг 2012 оны 3 дугаар сард батлагдаж, хоёр талын хамтын ажиллагаа эрчимжсэн.

Өнөөдрийн байдлаар НАТО-гийн “Батлан хамгаалах боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр” /Defense Education Enhancement Programe/-ийг хүрээнд Батлан хамгаалахын Их сургуулийн багшлах бүрэлдэхүүний заах арга зүй, ур чадварыг дээшлүүлэх, идэвхтэй сургалт явуулах арга зүйн асуудлаар сургалт, семинаруудыг хамтран зохион байгуулж, НАТО-гийн “Энхийн төлөө Шинжлэх ухаан” /Science for Peace and Security/ хөтөлбөрийн хүрээнд “Цэргийн зориулалттай газар орны экологийн геомэдээллийн сан байгуулах” төслийг хэрэгжүүлж байна.

Мөн Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төв нь НАТО-гийн “Боловсрол сургалтын төв”-ийн нэгдсэн сүлжээнд 2014 оны 9 дүгээр сард албан ёсоор элсэж, НАТО-гийн баталгаат сургалт, дадлагуудыг зохион байгуулах эрхтэй болсон. Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх энхийг сахиулагчдыг бэлтгэх, терроризмтэй тэмцэх чиглэлээр хоёр талын болон олон улсын 10 гаруй сургалт, хээрийн дадлагыг жил бүр зохион байгуулж, явуулдаг бүс нутгийн сургалтын төв болон өргөжсөн. Эдгээрээс 2006 оноос Номхон далай дахь АНУ-ын цэргийн командлалтай хамтран тогтмол зохион

³⁷ Ж.Мэндээ, Монгол, НАТО-гийн харилцаанд чанарын өөрчлөлт гарлаа, Ванкувер, 2012, <http://centralasiaprogram.org/wp-content/uploads/2015/04/Yoices-from-CA-1-June-2012.pdf>

байгуулж байгаа “Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургалтыг онцолж болно. Энэхүү олон улсын сургалт, дадлагад 2015 онд дэлхийн 23 орны 1200 гаруй цэргийн алба хаагчид оролцож байсан бол 2016 онд дэлхийн 47 орны 2030 гаруй цэргийн алба хаагчид оролцож, хээрийн сургалт, дадлага, команд штабын сургуульд хамрагдсан. “Хааны эрэлд” олон улсын сургалт, дадлага нь Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудын энхийг дэмжих чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүс нутгийн 5 гол сургуулийн нэг болж чадсан. Эдгээр сургалт, дадлагыг өөрийн оронд зохион байгуулах нь Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний энхийг дэмжих, хүмүүнлэгийн ажиллагаанд оролцох болон цэргийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, Үндэсний аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах Монгол Улсын бодлогыг хэрэгжүүлэхэд үр дүнгээ өгч байна.

2013 оноос хойш БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын цэргийн алба хаагчид бүсийн командлагчаар, нэгжийн даргаар томилогдон ажиллаж эхэлсэн нь Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны төвшин шинэ шатанд хүрсэн, Монгол Улсын энхийг сахиулагчдын ур чадварыг олон улсын төвшинд хүлээн зөвшөөрч, үнэлж эхэлснийг харуулж байна. Мөн Монгол Улсын 1 эмэгтэй цэргийн алба хаагч НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газарт үүрэг гүйцэтгэж байна.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны өөр нэгэн идэвхтэй арга хэмжээ нь зэвсэгт хүчний зэвсэг, техникийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, цэргийн мэргэжилтнүүдээ бэлтгэхэд тусламж, дэмжлэг авахад чиглэгддэг.

Жил бүр Монгол Улсын зэвсэгт хүчний 250 гаруй алба хаагчид харилцаа, хамтын ажиллагаатай 20 гаруй орны 60 гаруй сургууль, дамжаанд суралцаж мэргэжил эзэмшиж, эзэмшсэн мэргэжил, ур чадвараа дээшлүүлж байна.

Монгол Улсын батлан хамгаалах гадаад таатай нөхцлийг бүрдүүлэх, олон улсын тавцанд Монгол Улсын болон зэвсэгт хүчний нэр хүнд, байр суурийг бэхжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулах, цэргийн итгэлцэл, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, зэвсэгт хүчний шинэчлэлийг хэрэгжүүлэх, өөрийн улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах зэргээр Монгол Улс өөрийн аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцсэн хоёр талын болон олон талын батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

2009-2015 онуудын голлох үйл явдлууд

Зэвсэгт хүчний чадавх дээшлэв

2009 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-тай болсон нь Зэвсэгт хүчний шинэчлэлийг түүчээлсэн, зэвсэгт хүчний байгуулалтын цаашдын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх зарчмын шийдвэр болсон.

2010 онд Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, зэвсэгт хүчний бүтцэд барилга инженерийн ангиудыг Баянхонгор, Баян-Өлгий, 2015 онд Архангай, Говь-Алтай аймгуудад шинээр байгуулснаар зэвсэгт хүчний бүтээлч уламжлалыг сэргээж, улсын чанартай авто зам, гүүрийн барилга, орон нутгийн зарим барилгын ажлуудыг гүйцэтгэж, улсын бүтээн байгуулалтын ажилд хувь нэмрээ оруулж байна.

2011 оноос стратегийн орд газруудад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Тээвэрчин” цэргийн багуудыг бэлтгэн оролцуулж, багууд үүргээ амжилттай гүйцэтгэсэн.

2012 оноос цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдыг улс орны бүтээн байгуулалтад оролцуулж, мэргэжил эзэмшүүлэх зорилгоор “Монгол цэрэг бүтээн байгуулалтад” хөтөлбөрийг Засгийн газраас хэрэгжүүлж байгаа. Цаашид НҮБ-ын энхийн ажиллагаанд цэргийн барилга, инженерийн анги, салбар оролцуулах бэлтгэлийг хангах, улс орны стратегийн зориулалттай бүтээн байгуулалтад идэвхтэй оролцох чиглэлийг баримталж байна.

Засгийн газар 2015 онд өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд байгуулагдсан энхийг дэмжих ажиллагааны 3 батальоныг нэгтгэн бригадын зохион байгуулалтанд оруулж, бригадын штабыг байгуулах асуудлыг шийдвэрлэжээ.

Энхийг дэмжих ажиллагааны оролцоо нэмэгдэв

Зэвсэгт хүчин дэлхий нийтийн энх тайвны үйлст оруулж буй хүчин чармайлтаа нэмэгдүүлж, 2009-2010 онд Чад Улс болон Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад явагдсан НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа /MINURCAT/-нд анх удаа батальоны хэмжээний бүрэлдэхүүн, 2011 оноос Судан Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа /UNAMID/-нд цэргийн хээрийн II шатны эмнэлгийн бүрэлдэхүүн, 2011 оноос Өмнөд Судан Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа /UNMISS/-нд 850 хүнтэй батальоны хэмжээний бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж, үүргээ амжилттай гүйцэтгэж байна. Түүнчлэн, 2009 оноос Афганистан

дахь НАТО-гийн тэргүүлж буй “Аюулгүй байдлыг дэмжих олон улсын цэргийн хүчний ажиллагаа”, 2014 оноос уг ажиллагааны үргэлжлэл болох “Шийдвэртэй дэмжлэг” зэрэг ажиллагаанд ХБНГУ, АНУ-тай хамтран үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улсын зэвсэгт хүчнийг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд амжилттай оролцож байгаад НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн тусгайлан баяр хүргэж, 2009 онд Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд зочлохдоо “олон улсын тавцанд нэр хүндтэй Монголын цэрэг дайчдад НҮБ талархаж байдаг” хэмээн онцлон тэмдэглэсэн нь Монгол Улсын олон улсын тавцан дээрх нэр хүнд, зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэлтийг үнэлсэн хэрэг гэж үзэж байна.

Батлан хамгаалахын харилцаа өргөжив

2010 оноос Монгол Улсаас ХБНГУ-д суугаа ЭСЯ-ны дэргэд Батлан хамгаалахын атташе, ОХУ-д суугаа ЭСЯ-ны дэргэд Батлан хамгаалахын атташегийн туслах, 2011 оноос Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны дэргэд Батлан хамгаалахын атташе суулгах асуудлыг шийдвэрлэж, 2015 оноос Монгол Улсад суугаа Турк, БНСУ-ын Элчин сайдын яаманд Цэргийн атташегийн алба нээгдсэний зэрэгцээ, Батлан хамгаалах салбарт харилцаатай зарим улсуудад цэргийн атташе хавсран суулгах тухай асуудлыг ГХЯ-тай хамтран шийдвэрлүүлж, хавсран суух орнуудын тоог 10-аар нэмэгдүүлсэн нь хамтын ажиллагаатай орны тоог нэмэгдүүлж, харилцааг өргөжүүлэв. Ойрын үед БНАСАУ, Турк улсуудад Батлан хамгаалахын атташе суулгах асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа.

Түүнчлэн, НАТО-гийн Умард Атлантын Зөвлөлийн 2012 оны 3 дугаар сарын 19-ний хуралдаанаар “Монгол Улс, НАТО хоорондын түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг батлаж, НАТО-гийн бусад түншийн статустай Австрали, Шинэ Зеланд, Япон, БНСУ, Пакистантай ижил төвшинд харилцаагаа хөгжүүлэх боломжтой болсон.

Монгол Улс 2012 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын гишүүн болсноор хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа өргөжив. Тус байгууллагын Аюулгүй байдлын хамтын ажиллагааны форумын 2015 оны эхний улирлыг Монгол Улс даргалж, ЕАБХАБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт БХЯ-наас томилогдсон цэргийн зөвлөх ажилласан. Украин дахь ЕАБХАБ-ын ажиглагчдын тусгай багийн бүрэлдэхүүнд Монголын мэргэжилтэн үүрэг гүйцэтгэсэн нь НҮБ-аас бусад олон улсын байгууллагын ажиллагаанд оролцсон анхны тохиолдол болсон юм.

2013 онд Цэрэг, техникийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсан нь хөрш хоёр оронтойгоо харилцааны ижил төвшинд харилцах Гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн, өмнөд хөрштэй харилцааны төвшинг дээшлүүлсэн чухал арга хэмжээ болсон.

Мөн 2009-2015 онд батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар Засгийн газар хоорондын 10, Батлан хамгаалах яамд хоорондын 24 гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг, техникийн тохиролцоо байгуулж, хамтран ажилласан байна.

Дээрх хугацаанд батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд дараах томоохон арга хэмжээ зохион байгуулагдаж, зэвсэгт хүчний бүрэлдэхүүн оролцсон байна. Үүнд:

- Цэргийн спортын Олон улсын холбоо /CISM/-нд 10 жилийн дараа гишүүнчлэлээ сэргээж, БНХАУ-ын Гуанжоу хотод болсон Дэлхийн цэргийн аварга шалгаруулах 47 дахь удаагийн тэмцээнд Алдар спорт хорооны эмэгтэй тамирчид багаараа алтан медаль хүртсэн.

- 2010 онд 1990-ээд оноос хойш Зэвсэглэл, техникийг шинэчлэх, сайжруулах ажилд томоохон ахиц гарч агаарын довтолгооноос хамгаалах иж бүрдэл, орчин үеийн хуягт техниктэй болж, ОХУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд 100 гаруй автотехникээр парк шинэчлэгдэж, БНХАУ-ын Батлан хамгаалах яамнаас Монгол Улсын Зэвсэгт хүчний шинэчлэлийг дэмжиж, буцалтгүй тусламжийн хүрээнд 10 сая юаний өртөг бүхий автобус, архивын тоног төхөөрөмж, сургалтын багаж хэрэгслийг 2013 онд, 13 сая юаний өртөг бүхий 22 нэгж барилга зам инженерийн техник, хэрэгслийг 2015 онд, АНУ-аас 6,0 сая гаруй ам. долларын өртөг бүхий “Харрис” радиостанц, барилга инженерийн техник хэрэгсэл, шөнийн харааны дуран хэрэгсэл, ХБНГУ-аас гурван нэр төрлийн 35 иж бүрэн мэс заслын багаж хэрэгслийг 2013 онуудад өгч, 2015 онд Монгол-Австрийн Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн лаборатори, дүрс оношлогоо, мэс засал, мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний тасгуудыг 15,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан байна.

- 2015 онд Монгол Улсын Зэвсэгт хүчний ҮЖҮНХ, ЦДБЭЧ-ын уран бүтээлчид Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Эдинбург хотноо Олон улсын цэргийн хөгжмийн 65 дахь удаагийн наадамд оролцож, Монгол Улсын түүх соёл, Чингис хааны байлдан дагуулалт,

ээнт гүрний сэргэн мандалтыг харуулсан урлагийн тоглолтоо дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн 220,000 гаруй хүнд толилуулжээ.

Дүгнэлт

Өргөн уудам газар нутагтай, хүн ам цөөнтэй, хамгийн том газар нутагтай болон хамгийн их хүн амтай хоёрхон хөрштэй хиллэдэг, далайд гарцгүй зэрэг аюулгүй байдлын өвөрмөц нөхцөлтэй Монгол Улсын аюулгүй байдлын, түүн дотроо батлан хамгаалах салбар нь ардчилсан тогтолцоонд шилжсэн 26 жилийн туршид улс төр, нийгэм, эдийн засгийн боломжоосоо хамаарсан шинэчлэлийг тасралтгүй хэрэгжүүлжээ.

Эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт шинэчлэл эрчимтэй өрнөснөөс батлан хамгаалах салбарын шинэчлэл нь эрчимтэй явагдаж, тодорхой үр дүнд хүрсэн гэж үзэх үндэстэй. Нэгдүгээрт, батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчин нь аюулгүй байдлаа хангах улс төр, дипломатын идэвхтэй хэрэгсэл болж чадсан. Хөрш орнуудтайгаа төдийгүй бүс нутагтаа цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, бусад орнуудтай батлан хамгаалах салбарт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж, улмаар НҮБ-ын болон олон улсын цэргийн бусад ажиллагаанд идэвхтэй оролцож, дэлхийд танигдсан, Монгол Улсын олон улсын нэр хүндийг өргөж чадсан. Хоёрдугаарт, цэргийн мэргэжилтнүүдийн боловсрол, ур чадварыг нэмэгдүүлснээр зэвсэгт хүчний бэлэн байдлын төвшинг шат ахиулж чадсан. Батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаандаа тулгуурлан 20 орчим улсад цэргийн мэргэжилтнүүдийг тогтмол сурган дадлагажуулснаар, бие бүрэлдэхүүний цэргийн мэргэжлийн, хэлний, олон улсын төвшинд үүрэг гүйцэтгэх ур чадвар нэмэгдэж, эх орноо хамгаалах, зэвсэгт хүчний тайван цагийн бусад үүргийг биелүүлэх чадамж өсч, энэ хэмжээгээр зэвсэгт хүчний бэлэн байдлын төвшинг ахиулж байгаа гэж үзэх үндэстэй.

Гэсэн хэдий ч батлан хамгаалах салбарын шинэчлэлд шийдвэрлэх асуудлууд олон байна. Тухайлбал, шинэчлэн баталсан Монгол Улсын батлан хамгаалахын бодлогын үндэс баримт бичигт нийцүүлэн орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бий болгох, төрийн цэргийн байгуулал болон цэрэгжсэн байгууллагуудын зааг ялгааг тодорхой болгох, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчнийг хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх замаар гүйцэтгэх үүрэгтээ тохирсон зэвсэг, техникийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, агаарын цэргийг хөгжүүлэх шаардлага байна.

Хэдийгээр харилцаа, хамтын ажиллагаандаа тулгуурлан зарим төрлийн техник, хэрэгслийн тусламж, дэмжлэгийг авч байгаа ч зэвсэг, техникийн шинэчлэлд төр, засгаас бодитой хандаж, улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах үүргээ биелүүлэх нөхцлийг хангаж, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлага байсаар байна.

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ ОРНУУД


Цэргийн харилцаатай орнууд (харилцаа тогтоосон он)

1. ОХУ	1921	18. Украин	2001
2. БНЭУ	1973	19. Нидерланд	2002
3. БНХАУ	1991	20. Беларусь	2002
4. АНУ	1991	21. Люксембург	2002
5. ХБНГУ	1993	22. Финлянд	2002
6. Канад	1995	23. Болгар	2003
7. Израиль	1995	24. Казахстан	2003
8. БНПУ	1995	25. Кувейт	2006
9. БНФУ	1996	26. Катар	2007
10. БНСУ	1996	27. БНАСАУ	2008
11. Итали	1998	28. Вьетнам	2010
12. Турк	1998	29. Пакистан	2011
13. ИБУИНВУ	1999	30. Чех	2012
14. Бельги	1999	31. Унгар	2013
15. Швейцарь	1999	32. Австри	2014
16. Куба	1999		
17. Япон	2000		

Цэрэг-техникийн хамтын ажиллагааны хэлэлцээртэй орнууд

1. ОХУ	1993, 2004, 2008
2. Украин	2003
3. БНТУ	2003
4. БНХАУ	2013
5. БНБеларусь Улс	2013

Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны оролцоо



Ж. Баярцэцэг

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАРЫН ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛ: ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУД

Хууль сахиулах салбар, түүний тогтолцоо, эрх зүйн орчин

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай хуульд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнаас бүрдэхээр заасан байдаг.

Засгийн газар үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй ба бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагаас үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого болон энэ хуулийг биелүүлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавидаг.

Хууль сахиулах байгууллагууд нь үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэг чухал хэсэг бөгөөд Засгийн газрын үндэсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг ханган, хууль сахиулдаг тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага юм.

Монгол улсад хууль сахиулах байгууллага гэсэн ойлголт 1992 оны Үндсэн хуульд шүүх эрх мэдлийн байгууллага болон хууль сахиулахбайгууллага гэж тодорхойлогдсон. Улмаар УИХ-аас баталсан 16 хуульд“хууль сахиулах байгууллага” гэсэннэр томьёог хэрэглэсэн байх бөгөөд анхных нь 1993 оны Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль, 1997оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль байна. Түүнчлэн, Монгол Улс нэгдэн орсон олон улсын 3 гэрээнд “хууль сахиулах арга хэмжээ, хууль сахиулах үйл ажиллагаа, хууль сахиулах байгууллага” гэсэн нэр томьёог хэрэглэжээ.

Хууль сахиулах гэдэг нь өргөнүтгаараа хууль зүйн хариуцлагыг тогтоосон хуулиудыг зөрчсөн үйлдэл, түүнийг үйлдсэн хүнийг илрүүлэх, таслан зогсоох, шийтгэл хүлээлгэх, хохирогчийн зөрчигдсэн эрхийг сэргээхэд чиглэсэн албадлагын шинжтэй үйл ажиллагаа явуулах тогтолцоог, явцуу утгаараа хууль, шүүхийн шийдвэрийг сахин биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих үйл ажиллагаа хамардаг

байна. Хууль сахиулах гэдэг нь хууль зүйн хариуцлагыг тогтоосон хуулиудыг зөрчсөн үйлдэл, түүнийг үйлдсэн хүнийг илрүүлэх, таслан зогсоох, шийтгэл хүлээлгэх, зөрчигдсэн эрхийг сэргээхэд чиглэсэн албадлагын шинжтэй үйл ажиллагаа явуулах тогтолцоо юм. Хууль сахиулах байгууллагын гол төлөөлөл нь цагдаагийн байгууллага байдаг ба тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх байгууллагууд, шийтгэл оногдуулсан болон зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх талаар гарсан шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллагууд байдаг.³⁸ Хууль сахиулах бодлого, чиг үүргийг Хууль зүй яам гүйцэтгэдэг³⁹. Монгол Улсын Засгийн газрын ерөнхий чиг үүргийн яам болох Хууль зүйн яам нь Шүүх яам, Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам нэртэйгээр 1911 онд байгуулагдсан бөгөөд анхны 5 яамны нэг юм.

Хууль зүй яам дараах чиг үүрэгтэй⁴⁰ :

- эрх зүйн шинэтгэлийн бодлого;
- хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;
- эрх зүйн туслалцаа;
- улсын хил хамгааллын асуудал;
- цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
- Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, хуульчдын олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;
- төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;
- иргэний харьяалал, цагаачлалын асуудал;
- энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;
- төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт;
- иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;
- хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүртгэл;
- оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;
- архивын талаар төрөөс баримтлах бодлого;

³⁸ Хууль сахиулах үйл ажиллагааны өнөөгийн байдал, чиг хандлага” илтгэл, Д.Эрдэнэбаатар, Хууль сахиулахын онол, практикийн олон улсын хурал, 2016

³⁹ Засгийн Газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 2016 оны 7-р сараас эхлэн Хууль зүйн дотоод хэргийн яам нэртэй болсон.

⁴⁰ Засгийн газрын тухай хуулийн 20 зүйлийн 5 заалт

Хууль зүй дотоод хэргийн яамны харьяанд хууль сахиулах чиг үүрэг бүхий дараах агентлаг байгууллага ажилладаг. Үүнд:

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

- гэмт хэргийг таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх
- гэмт хэрэг, зөрчил гарсан тухай мэдээллийг хүлээн авах, гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, үзлэг хийх, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах
- нийтийн эзэмшлийн газарт хяналт тавих, эргүүл ажиллуулах
- мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах
- хууль, дүрэм, журмыг сахиулж нийтийн хэв журмыг хамгаалах
- нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах
- төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомжид заасан үүрэг гүйцэтгэх
- иргэн, хуулийн этгээд галт зэвсэг өмчлөх, ашиглах, галт зэвсэг, сум үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх, эзэмших журмын биелэлтэд хяналт тавих
- зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоо бүртгэлийг хөтлөх

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР

- Улсын хил хамгаалалтыг зохион байгуулах
- Монгол Улсын олон улсын гэрээнд хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх
- улсын хилийн шугам, тэмдэг, холбоосны байршлыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байж, хилийн асуудлыг хууль зүйн дагуу шийдвэрлэх
- улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу нэвтрүүлэх
- шүүн таслах ажиллагаа болон хорих анги, цагдан хорих байрнаас оргон зайлж улсын хил нэвтрэхийг завдсан, нэвтэрсэн яллагдагч, ялтны талаарх мэдээлэл, лавлагааг гаргаж өгөх,

- хилийн бүс орчимд эрэн сурвалжлагдаж байгаа яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах ажиллагаанд оролцох, хүн хүч, автомашин, техник хэрэгслээр туслах

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР

- шүүхийн болон бусад байгууллагын шийдвэрийг гүйцэтгэх талаар төр засгаас тодорхойлсон бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх
- аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих
- албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх
- шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтлөх
- согтуурах, мансуурах донтой этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх болон захиргааны журмаар баривчлах шийтгэл ногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗАР

- гадаадын иргэний эрх зүйн байдал, харьяат цагаачлалын асуудлаар төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- гадаадын иргэний эрх зүйн байдал, харьяат цагаачлалын асуудлаар Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
- гадаадын иргэнд хувийн урилга, энгийн зэргийн виз, визийн зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, хүчингүй болгох, түр буюу удаан хугацаагаар оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг бүртгэх, зөвшөөрөл, оршин суух үнэмлэх олгох, хугацааг сунгах, хяналт тавих
- Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллыг сэргээн тогтоох хүсэлтийг хүлээн авч холбогдох дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх
- гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, гадаадын болон олон улсын төрийн бус байгууллагын

Төлөөлөгчийн газрыг нээн ажиллуулах зөвшөөрөл олгох, хяналт тавих, хугацааг сунгах, татан буулгах

ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР⁴¹

- шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах
- гэрч, хохирогчийг хамгаалах
- яллагдагч, ялтныг хуяглан хүргэх
- яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх
- ялтан шилжүүлэх
- оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

- эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах
- ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах
- тэсэрч дэлбэрэх бодис, сум, галт хэрэгсэл, цацраг идэвхт үүсгүүр, хими, биологийн болон аюул учруулж болзошгүй бусад объектод криминалистикийн шинжилгээ хийх
- иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч, хариуцагч /иргэн/ нь иргэний эрх зүйн чадамжтай эсэхэд сэтгэцийн шинжилгээ хийх
- хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний биед шинжилгээ хийх

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

- улсын бүртгэлийн хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулах
- иргэний улсын бүртгэлийг эрхлэн хөтлөх
- хуулийн этгээдийн улсын бүртгэлийг эрхлэн хөтлөх
- эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг эрхлэн хөтлөх

⁴¹ Тахарын Ерөнхий газар нь 2013 оны 7 дугаар сарын 5-нд УИХ-аар батлагдсан Тахарын албаны тухай хуулиар байгуулагдан, 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар татан буугдаж, чиг үүргийг нь ЦЕГ, ШШГЕГ-т шилжүүлсэн.

- улсын бүртгэлийн эх нотлох баримтын архив болон цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах
- улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн болон төрөлжсөн бусад байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах
- улсын бүртгэлийн үйл ажиллагааны тайлан мэдээг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, хуулийн дагуу мэдээлэх, үйл ажиллагааны мэдээ, тайланд дүн шинжилгээ, судалгаа хийх
- улсын бүртгэлийн аргачлал, арга зүйг олон улсын ангилал, стандартын жишигт нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр гаргаж мөрдүүлэх

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

- шинжлэх ухааны суурь ба хавсарга судалгааг гүйцэтгэх
- мэргэжлийн давтан, мэргэшүүлэх, удирдлагын төвшний сертификат, диплом, бакалавр, магистр, докторын зэргийн шаталсан сургалт явуулах
- багш, эрдэм шинжилгээний ажилтныг давтан сургах, мэргэшсэн боловсон хүчин, судлаачийг сонгон шалгаруулах замаар профессор багш нарын чадварлаг нөөцийг бүрдүүлэх
- хууль сахиулах болон тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагын хүний нөөцийг бэлтгэх

Манай улсад хууль сахиулах ажиллагааны үндэслэл, журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Цөмийн энергийн тухай зэрэг байгууллагын хэм хэмжээг тогтоосон салбарын 10 орчим хуулиар зохицуулж байна. Үүнээс гадна эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэхийн тулд хойшлуулшгүй ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнууд болон Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд, нийтдээ хорь гаруй субъектүүд тус тусын салбарын хуулиар зарим эрх хэмжээ олгогдсон, хэрэгжүүлэх журмыг нь агентлаг, байгууллагын даргын шийдвэрээр тогтоох зэргээр зохицуулж байна.

Хууль сахиулах салбарын шинэчлэл

Монгол Улс үндэсний аюулгүй байдлыг хамгаалах байгууллагууд болох цэрэг, цагдаа, шүүхийн тогтолцоог өнөөгийн нийгэмд нийцүүлэн боловсронгуй болгохдоо холбогдох хуулиудыг ганц нэгээр нь өөрчилж, зарим эрх зүйн орчны шинэчлэл хэрэгжүүлж ирсэн боловч салбарыг бүхэлд нь хамарсан цогц шинэчлэл дутагдалтай явж иржээ. Нэн ялангуяа 1990 оноос хойшхи хууль сахиулах салбарын шинэчлэл ийм хэлбэрээр удаашралтай явагдсан. Тухайлбал 1993 онд баталсан Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуульд 1995, 1996, 1997, 1998, 1999, 2000, 2002, 2003, 2007, 2009 онуудад нийт 16 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг.

Монгол Улсын Засгийн газар 2012-2016 онд хууль сахиулах салбарт эрх зүйн болон тогтолцооны цогц шинэчлэл хийх зорилго тавьж ажилласан. Энэ хүрээнд хууль сахиулах салбарын эрх зүйн орчин болон бүтэц зохион байгуулалт, санхүү, дэд бүтцийг иж бүрнээр нь шинэчлэх зорилгот тавьж өргөн хүрээтэй ажил зохион байгуулжээ. Үүнд:

1. Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг хууль дээдлэх ёсны зарчимд нийцүүлэн нэг бүрчлэн зохицуулсан хуулийн тогтолцоог бий болгох.
2. Хууль зүйн яамны чиг үүрэг, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хууль зүйн бодлогыг шинжлэх ухааны үндэстэй, хүний эрх, эрх зүйт ёсны зарчимд нийцүүлэх механизмыг бүрдүүлэх.
3. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрүүгийн цагдаагийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг мөрдөх алба болгон нэгтгэн зохион байгуулж, мөрдөх албаны дэргэд шүүх шинжилгээний бүтцийг бий болгох
4. Захиргааны болон эрүүгийн зөрчлийг бүртгэх нэгдсэн сан бий болгож, эргүүлийн цагдаа, хилийн алба, татвар, бусад мэргэжлийн хяналтын үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагын менежментийг нэвтрүүлэх.
5. Шүүхэд мөрдөн байцаалтын шатны шүүгчийн бүтцийг бий болгож, хүний эрхийн баталгааг дээшлүүлэх
6. Шүүхэд “Маршалын алба” бий болгож, эрүүгийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албыг ялгавартай зохион байгуулах.
7. Нийтэд тустай үйл ажиллагааны хууль баталж, иргэний нийгмийн хяналтыг дээшлүүлэх.

8. Иргэний үндсэн эрхийн хяналтыг шүүхээр хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.
9. Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бий болгох.
10. Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар мэргэшсэн нэгж байгуулах.
11. Шүүхээс гадуур хүний эрхийг хязгаарлаж, эрүүгийн хэргийг байцаан шалгадаг тогтолцоог халж, шүүхийн хяналтын дор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох.
12. Прокурорын байгууллагын хүний эрхийн болон гүйцэтгэх ажлын хяналт, процессын маргаан шийдвэрлэх чиг үүргийг шүүхэд шилжүүлэх.
13. Цагдаагийн хэв журам, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг орон нутгийн мэдлийн төвшинд зохион байгуулж, иргэний хяналтын механизм бүрдүүлэх.

Энэхүү Засгийн Газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хууль сахиулах салбарын дараах хуулиуд 2012-2016 онд батлагджээ.⁴²

- Эрүүгийн хууль (2015 оны 12 дугаар сарын 3)
- Зөрчлийн тухай хууль (2015 оны 12 дугаар сарын 3)
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай (2013 оны 7 дугаар сарын 5)
- Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай (2013 оны 7 дугаар сарын 5)
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга (2013 оны 5 дугаар сарын 31)
- Цагдаагийн албаны тухай (2013 оны 7 дугаар сарын 5)
- Тахарын албаны тухай (2013 оны 7 дугаар сарын 5)
- Галт зэвсгийн тухай (2015 оны 8 дугаар сарын 7)
- Прокурорын байгууллагын тухай
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга (2016 оны 5 дугаар сарын 19)

⁴² Эдгээр хуулиудаас Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль нь 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр дагаж мөрдөх хугацааг хойшлуулан 2017 оны 7 дугаар сарын 01 болгосон. Тахарын албаны тухай хууль 2016 оны 07 дугаар сарын 21-нд хүчингүй болсон. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга УИХ-аар дахин хэлэлцэгдэж 2016 оны 12 дугаар сарын 22-нд батлагдсан.

Түүнчлэн, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэг хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

“Хууль сахиулах үйл ажиллагаа”-нд гэмт хэрэг илрүүлэх хойшлуулгүй ажиллагаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах гүйцэтгэх ажил, нийгмийн хэв журам сахиулах, нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа хамрагддаг. Гэмт хэрэг мөрдөх, зөрчлийг шалгах, нийгмийн хэв журам сахиулах, аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй субъект болох ял эдлүүлэх, хил хамгаалах, онцгой байдал, харьяатын албаны алба хаагчийн эрх зүйн байдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Монгол Улсын Хилийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай зэрэг тухайн салбарын хуулиар зохицуулдаг.

Хууль сахиулах байгууллагыг цэрэгжсэн байгууллага гэж үзэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагатай нийлүүлээд хүчний байгууллага гэж үздэг байсан нь иргэнд аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг бууруулсан шинжтэй байсан. Иймд иргэнд үйлчилдэг байгууллагыг цэргийн байгууллагаас хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын иргэнд үйлчлэх чиг үүргийг боловсронгуй болгох нь хууль сахиулах салбарын шинэчлэлийн зорилго байв⁴³. Үүний хүрээнд хууль сахиулах байгууллагуудад бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны дараах шинэчлэл хийсэн.

Цагдаагийн байгууллага нь хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэгтэй. Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн гурван чиг үүрэг байдаг байна. Нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэргийн талаарх өргөдөл гомдлыг шийдвэрлэх үедээ иргэнд үйлчилдэг байна. Гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх болон таслан зогсоох, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх таслан зогсоох хязгаарлах үед хууль сахиулах чиг үүргээ биелүүлдэг байгууллага байна. Эдгээр чиг үүргийг илүү тодорхой болгох, үйл ажиллагааны процесс, үйлчилгээний чанар хүртээмж, боловсон хүчинг сайжруулах зорилгоор Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэн боловсруулан батлуулсан ба хууль эрх зүйн орчин, бүтэц, стратеги, үйл ажиллагааны технологи, хамтын ажиллагааг шинэчлэн улмаар хууль сахиулах үйл ажиллагаанд хүний оролцоог багасган мэдээллийн технологид түшиглэн ажиллах цогц

⁴³ Хууль сахиулах үйл ажиллагааны шинэтгэл, Г.Оюунболд, “Хууль сахиулах” сэтгүүл, 2014.1

тогтолцоог бүрдүүлэх зорилготой юм.

Цагдаагийн байгууллагад дэд бүтцийн шинэчлэл хийснээр иргэнд биш, даргад үйлчилдэг, хүчний маягийн цэрэгжсэн тогтолцоог өөрчлөх, үндсэн чиг үүргийн болон дэмжлэг үзүүлэх боловсон хүчний харицааг зөв зохистой төлөвлөх ажил хийгдэж эхэлсэн байна.⁴⁴ Жишээ нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрыг байгуулж 1000 гаруй дотоодын цэргийн алба хаагчийг цагдаагийн мэргэшсэн албан тушаалд томилохоор сургалтанд хамруулж, Засгийн газраас тогтоосон жишиг нормативын дагуу хүн амын нягтаршлыг харгалзан дүүргийн цагдаагийн хэлтсүүдийг нэмж байгуулсан.

Цагдаагийн байгууллагад гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах шууд үүрэгтэй болон захиргааны ажилтны зохистой харьцаа алдагдан нийт гэмт хэргийг нийт алба хаагчид хуваахад 350, харин шууд үүрэг хүлээсэн алба хаагчид хуваахад энэ тоо 2 дахин өсч 784 болсон байдаг. Иймээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг стандартад оруулж, Хууль зүйн яамнаас хяналт тавих журмыг боловсруулах, цагдаагийн менежементийг сайжруулж, удирдах ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, төлөвлөгөө, тайлангийн биелэлтэд үнэлгээ шинжилгээ хийсний үндсэн дээр 2010 онд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, 2014 онд Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг тус тус боловсруулан хууль сахиулах ажиллагааны жишиг нормативтой болсон⁴⁵.

Энэхүү шинэчлэлийн хүрээнд Тахарын алба⁴⁶ байгуулагдсан нь хууль сахиулах чиг үүргийн чухал хэсэг болох шүүхийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилготой байсан. Шүүн таслах ажиллагааг аюулгүй явуулах нөхцлийг хангаагүй нөхцөлд шүүх хурал хэвийн явахгүй бөгөөд үүний улмаас иргэд шударга шүүхээр шүүлгэх эрх нь зөрчигдөхөд хүрдэг тул шүүгч шүүхийн аюулгүй байдлыг ханган, шаардлагатай бол улсын яллагчийн аюулгүй байдлыг хангаж, гэрч хохирогчийг хамгаалж, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхээс оргон зайлсан ялтанг эрэн сурвалжлах чиг үүргийг уг алба гүйцэтгэх болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг шинэчлэхдээ иргэний шийдвэр гүйцэтгэх болон ял эдлүүлэх, нийгэмшүүлэх, хорихоос өөр

⁴⁴ Хууль зүйн сайдын Х.Тэмүүжингийн ярилцлага, Цагдаагийн байгууллагад хийж буй шинэтгэл, 2013

⁴⁵ “Цагдаагийн байгууллагын шинэчлэл”, Ж.Ганбаатар, Хууль сахиулахуй сэтгүүл 2014.1

⁴⁶ Тахарын албаны хуулийг 2016 оны 7 сарын 21 нд хүчингүй болгон Тахарын албыг татан буулган чиг үүргийг ЦЕГ, ШШГЕГ-т шилжүүлсэн.

төрлийн ялыг хэрэгжүүлэх үүднээс хууль тогтоомжийн болон үйл ажиллагааг боловсронгуй болгон ялтанд хорих ял эдлүүлэх, хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгт шалгагдаж байгаа этгээдийг цагдан хорих зэрэг чиг үүргийг тодорхой стандартад оруулж зохицуулах зорилготой байсан.

Хил хамгаалах байгууллага нь хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн дэглэм сахих, хил хамгаалах үндсэн гурван чиг үүрэгтэй ба үүний эхний хоёр нь хууль сахиулах чиг үүрэгт хамаарах бөгөөд үлдсэн нь хилийн аюулгүй байдлыг батлан хамгаалах чиг үүрэгт хамаарна. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны шинэтгэлтэй уялдуулан хилийн шалган нэвтрүүлэх албаны чиг үүргийг шилжүүлсэн⁴⁷.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боловч иргэнд үйлчилгээ үзүүлдэг. Хилийн шалган нэвтрүүлэх чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан виз олгох, хянах мөн үйлчилгээний хэлбэртэй хууль сахиулах шинжтэй байна, Иргэний харьяалалын асуудал мөн үйлчилгээний хэлбэртэй хууль сахиулах шинжтэй байна.

Хууль сахиулах байгууллагын хяналт, иргэдийн оролцоо

Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт маш чухал байдаг. Иймээс хууль сахиулах салбарын шинэчлэлийн хүрээнд Хууль зүйн яамнаас дотоод хяналтыг боловсронгуй болгох зорилгоор цогц арга хэмжээ авсан. Үүнд харьяа хууль сахиулах байгууллагуудад дотоод хяналтын чиг үүрэг бүхий тусгай нэгжийг байгуулан албан хаагчдын албан тушаалын зэрэглэл нэгээр илүү байхаар заан бүтцийг батлан хэрэгжүүлсэн. Түүнчлэн, байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд чиглэсэн хяналт- шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлж, төлөвлөлт, гүйцэтгэл, дунд болон урт хугацааны үр дүн, үр нөлөөг сайжруулахад анхаарч, “Агентлаг, байгууллагын эрсдлийн үнэлгээ хийх аргачлал”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”, “Хэрэглэгчийн үнэлгээний шалгуур үзүүлэлт”, “Хүний эрхийг хангах шалгуур үзүүлэлт”, “Захиргааны зардал ба үр дүнгийн тооцоо”, “Төрийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох аргачлал”, “Дотоод аудитын журам”-ыг батлан мөрдүүлж эхэлжээ.

Түүнчлэн, олон улсын ISO31000:2009 стандартын дагуу эрсдлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажилласнаар байгууллагын онцлог

⁴⁷ Хилийн тухай хуулийн 2013 оны 7 сарын 26-ны нэмэлт өөрчлөлт. 2016 оны 12-р сарын 28-нд батлагдсан Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар уг чиг үүрэг хил хамгаалах байгууллагад шилжсэн.

эрсдлийг урьдчилан тодорхойлж, түүнд чиглэсэн дотоод аудит, зардал, үр дүнгийн тооцоог хийж, эрсдлийн менежментийг төлөвлөн хэрэгжүүлж эхэлснээр үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан илрүүлэх, түүнтэй уялдуулан бодлого, зохион байгуулалтын арга хэмжээ авах дотоод хяналтын механизм бүрдсэн.

Хууль зүйн сайдын дэргэд хөндлөнгийн, хараат бус гишүүдийн бүрэлдэхүүнтэй дотоод аудитын хороо ажиллаж, харьяа агентлаг, байгууллагад дотоод аудитын нэгжүүд байгуулагдан дотоод аудитын журмын⁴⁸ хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг болсон.

Цагдаагийн албаны тухай шинэ хуульд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсыг хангах ажлыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэхээр хяналт тавих тусгайлсан бүлэг зохицуулалт туссан. Энэхүү хяналтын зорилт нь цагдаагийн алба хаагч өөрөө хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль бус үйлдлийг таслан зогсоох, цагдаагийн алба хаагчийн буруугаас байгууллага, аж ахуйн нэгж, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалах, улмаар цагдаагийн алба хаагчийн хууль дээдлэн биелүүлэх хандлагыг төлөвшүүлэх, хуулийг зөв хэрэглэх чадвар, дадлага эзэмшүүлэх явдалд орших юм.

Цагдаагийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагаан дахь дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Дотоод хяналт, аюулгүй байдлын албыг байгуулж үйл ажиллагааных нь үндсэн чиглэлийг тодорхойлсон. Түүнчлэн, иргэнд суурилсан хяналтыг нэвтрүүлэн, цагдаагийн албаны үйл ажиллагааг иргэний хяналтад оруулж, тэдний өмнө хариуцлагатай хууль сахиулах үйл ажиллагааг явуулах, хариуцлага хүлээдэг механизмыг бий болгох зорилго тавьсан байна. Цагдаагийн бодлого, үйл ажиллагааны стратегийн үндсэн баримт бичиг болох “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”⁴⁹-т цэрэг, хүчний байгууллагын тогтолцоонд суурилсан хуучин, хэвшмэл хандлагыг өөрчлөн цагдаагийн үйл ажиллагааны маркетингийн удирдлагыг чанартай, шуурхай, соёлтой үйлчилгээг олон нийтийн итгэл, дэмжлэг, иргэний хяналтад тулгуурлан хөгжүүлэх талаар заасан.

Энэ хүрээнд шинээр олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөл⁵⁰ байгуулагдсан нь цагдаагийн үйл ажиллагаанд хууль тогтоомж зөрчигдөхөөс сэргийлэх, цагдаагийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

⁴⁸ Засгийн газрын 2012 оны 129 дүгээртөгтоол

⁴⁹ Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоол

⁵⁰ Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл

Энэ нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, олон нийтийн итгэлийг хүлээж, иргэний дэмжлэгийг авах цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр болох юм. Иргэний зөвлөл нь 5-7 иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус байх ба аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байгуулагдан, цагдаагийн байгууллагын төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх, сургалт, үйл ажиллагаандаа орчин үеийн технологи нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэйгээр байгуулсан. Иргэний зөвлөлийн 5-7 гишүүнийг анх томилохдоо таван гишүүнтэй бол нэг гишүүн нь нэг жил, хоёр гишүүн нь хоёр жил, хоёр гишүүн нь гурван жил, долоон гишүүнтэй бол нэг гишүүн нь нэг жил, гурван гишүүн нь хоёр жил, гурван гишүүн нь гурван жилийн хугацаатай байхаар тус тус томилно.⁵¹

Иргэний зөвлөлийн үүргээ гүйцэтгэх хэвийн нөхцлийг бүрдүүлэхийн тулд “Иргэний зөвлөлийн дүрэм”, “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам”⁵² зэргийг батлан иргэний зөвлөлийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж өгснөөр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажил сайжрах нөхцөл бололцоо бүрдэж, олон нийтэд ил тод, нээлттэй болж, иргэдийн үнэлгээ нэмэгдэж, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааг явуулахад дэмжлэг болсон.

Иргэний зөвлөл нь шинээр байгуулагдсан шинэлэг бүтэц тул цаашид үйл ажиллагааг нь улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал, бие даасан байдлыг баталгаажуулж, улс төрөөс болон цагдаагийн байгууллагын дарга нараас хараат бус байлгах, санхүүжилтийн хувьд хараат бус байх, цагдаагийн байгууллагатай нягт хамтын ажиллагааг бий болгох шаардлагатай. Түүнчлэн, үйл ажиллагааг нь улам боловсронгуй болгон олон нийтийн оролцоог дэмждэг байх, олон нийтийг болон цагдаагийн алба хаагчдыг оролцуулан сонсгол хийх, асуудлыг шийдвэрлэх, сайжруулах талаар бодлогын зөвлөмж гаргах, статистик мэдээ, тайлан, мэдэгдэлд дүн шинжилгээ хийдэг болох шаардлагатай.

⁵¹ “Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл

⁵² Хууль зүйн сайдын 2014 оны 89 дүгээр тушаал

Хууль сахиулах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Хууль сахиулах салбарт гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулах, зээл тусламжийн хүрээнд хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийг өргөжүүлэх нь маш чухал юм. Үүний хүрээнд:

- олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орох,
- эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулах,
- төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх,
- НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудтай хамтарч ажиллах,
- сургалт семинар зохион байгуулах, туршлага солилцох зэрэг үйл ажиллагаа зохион байгуулдаг.

Хууль зүйн яам 14 орны Засгийн газар болон Хууль зүйн яам болон бусад холбогдох яамдуудын хооронд хамтын ажиллагааны тухай 48 харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан, тухай бүр нь шинэчлэн хэрэгжилтийг хангаж байна. Үүнд ялангуяа хоёр хөрш орнуудтай сайн хамтын ажиллагаатай ба ОХУ-тай хамтын ажиллагааны төрөл хэлбэр бүрийг зохицуулсан 17 гэрээ, санамж бичгийг байгуулсан бол БНХАУ-тай 5 гэрээ байгуулан ажиллаж байна.

Түүнчлэн, олон улсын байгууллага, хөтөлбөрүүдтэй нягт хамтран ажиллаж НҮБХХ, НҮБХАС, Ханнс-Зайделийн сан, ГТХТС, АНУ, БНСУ зэрэг улсуудын хөгжлийн хөтөлбөр, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагатай хамтран ажиллаж урт, богино хугацааны төсөл арга хэмжээг хэрэгжүүлдэг. 2015 онд Хууль зүйн яам Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төвтэй хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулсан.

Олон улсын холбогдох гэрээ хэлэлцээрт нэгдэн орох нь олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чухал ач холбогдолтой байдаг. Үүний хүрээнд НҮБ-аас баталсан гол суурь хүний эрхийн гэрээ, конвенцид нэгдэн орсон ба Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт протокол, Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай НҮБ-ын конвенцид 2015 онд нэгдэн орсон. Мөн нэгдэн орсон гэрээний үүргийн хүрээнд Монгол Улсын Засгийн Газрын тайланг боловсруулан НҮБ-ын зохих хороонд хэлэлцүүлэн, тайлагнадаг. 2012-2016 онуудад Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын дунд хугацааны сайн дурын илтгэл, Арьс өнгөөр алагчлах үзлийн бүх хэлбэрийг


устгах олон улсын конвенцийн Монгол Улсын Засгийн газрын 19, 20, 21 дүгээр илтгэл, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын ээлжит 2 дахь илтгэл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн 6 дугаар илтгэл, Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын II илтгэлийг боловсруулж, НҮБ-ын холбогдох Хороо, байгууллагуудаар хэлэлцүүлэн хамгаалсан.

Хууль сахиулах байгууллага ялангуяа цагдаагийн байгууллагын чиг үүрэгт чухал үүрэгтэй хоёр талт хэлэлцээр нь гадаад улсуудтай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байдаг. Монгол Улс нь Иргэний хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай, Эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай, Гэмт этгээд шилжүүлэх тухай, Ялтан шилжүүлэх тухай нийт 20 улстай 28 төрлийн гэрээг байгуулсан байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН УЛСУУД

- | | |
|-------------------------------|-------------------------------|
| 1. Унгар Ард улс | 11. Казакстан улс |
| 2. Болгар Ард улс | 12. Польш улс |
| 3. Социалист Румын улс | 13. Оросын холбооны улс |
| 4. Социалист Чехословак улс | 14. Солонгос улс |
| 5. Словак улс | 15. Украин улс |
| 6. Канад улс | 16. Социалист Вьетнам улс |
| 7. Ардчилсан Солонгос Ард улс | 17. Киргиз улс |
| 8. Куба улс | 18. Турк |
| 9. Хятад улс | 19. Энэтхэг улс |
| 10. Франц улс | 20. БНХАУ-ын ЗЗОБ Хонконг улс |

Монгол Улс нь анх Бүгд Найрамдах Унгар Ард Улстай 1968 онд Иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулсан ба үүнээс хойш хуучнаар социалист орон гэгдэж байсан 10 гаруй орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг байгуулсан. Тухайн үед эрх зүйн туслалцааны асуудлыг багцаар нь буюу иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, эрүүгийн хэргийн асуудлуудыг нэгтгэн нэг гэрээнд багтааж зохицуулалтыг хийдэг байжээ. 1990 оноос хойш бусад улс орнуудын нийтлэг хандлагыг харгалзан эрх зүйн туслалцааны гэрээг салбар эрх зүй тус бүрээр байгуулж байна.



Монгол Улс нь гадаад орнуудтай ялтан шилжүүлэх асуудлыг зохицуулсан 7 хоёр талт гэрээ байгуулсан бөгөөд одоогийн байдлаар БНХАУ-ын ЗЗОБ Хонконг, БНКаЗУ-тай байгуулахаар ажиллаж байна.

ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

Бүгд Найрамдах Куба Улс	1989.08.16
Бүгд Найрамдах Польш Улс	1998.10.19
Оросын Холбооны Улс	1999.04.20
Бүгд Найрамдах Турк Улс	2000.05.02
Бүгд Найрамдах Солонгос Улс	2007.05.28
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	2011.06.16
Канад Улс	2014.10.20
Бүгд Найрамдах Энэтхэг Улс	2015.05.17
БНХАУ-ын ЗЗОБ Хонконг	2016.02.01

Ялтан шилжүүлэх ажлын хүрээнд БНХАУ-аас 2015 онд 1, БНСУ-аас 2014 онд 2, БНЧУ-аас 2014 онд 1, БНКаЗУ-аас 2014 онд 2, БНСУ руу 2014 онд 1, ОХУ руу 2014 онд 4 иргэнийг тус тус шилжүүлсэн байна.

Түүнчлэн БНХАУ-д хорих ял эдэлж байгаа 19 иргэн, БНСУ-д хорих ял эдэлж байгаа 4 иргэн, ОХУ-д ял эдэлж байгаа 1 иргэн эдлээгүй үлдсэн ялаа Монгол Улсад эдлэх хүсэлтээ гаргасаны дагуу шилжүүлэх ажиллагаа хийгдэж байна.

Монгол Улс нь Ялтан шилжүүлэх тухай 1978 оны Берлиний конвенцид нэгдэн орсон байдаг бөгөөд одоогийн байдлаар тус конвенц нь хүчин төгөлдөр үйлчилж байна. (Болгар, Унгар, Куба, Монгол, Польш, Чех, Словак, Орос, Ардчилсан Солонгос зэрэг улсууд гишүүн байна). Мөн Монгол Улс нь Ялтан шилжүүлэх тухай Европын зөвлөлийн конвенцид нэгдэх хүсэлтээ илэрхийлэн гишүүнээр элсэх чиглэлээр ажиллаж байна.⁵³

Хууль сахиулах байгууллага түүн дотроо цагдаагийн байгууллага НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд хууль сахиулагчийн хувиар оролцох UNPOL буюу НҮБ-ын энхийг сахиулах цагдаагийн үйл ажиллагаанд 2016 оноос нэгдсэн. Ингэснээр цагдаагийн байгууллагын гадаад харилцаа хамтын ажиллагааг сайжруулах, олон улсын тавцанд цагдаагийн байгууллагын нэр хүндийг өргөх ач холбогдолтой. Цаашид жил бүр цагдаагийн албан хаагч нь шат дараалалтайгаар НҮБ-ын энхийг сахиулах цагдаагийн үйл ажиллагаанд хамрагдана.

Дүгнэлт

Хууль зүйн салбарын шинэчлэл нь Монгол Улсад шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх чухал үйл хэрэг шинэчлэл амжилттай хэрэгжсэнээр хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, уг үйл ажиллагааны явцад хүний эрхийг хамгаалах асуудалд дэвшил буй болно гэсэн хүлээлт иргэд болон салбарын ажиллагсадын дунд байсаар байгаа нь сайшаалтай хэрэг юм. Иймээс цаашид хууль сахиулах салбарын шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай. Хууль зүйн салбарын шинэчлэл нь эрх зүйн орчин, институцийн хувьд өөрчлөх, бүтэц зохион байгуулалт, санхүү, дэд бүтцийг иж бүрнээр нь цогцоор шинэчлэхэд цаг хугацаа шаардагдахын сацуу Засгийн газар болон хууль сахиулах байгууллагуудын хүсэл зориг, улс төрийн дэмжлэгээс ихээхэн хамаарна. Иймээс батлагдсан болон боловсруулсан хуулийн төслийг УИХ-аар батлуулан хэрэгжилтийг хангахаас гадна, салбарын ажилтан, алба хаагчдад тайлбарлан таниулж ойлгуулах, сурталчлах, үйл ажиллагаандаа ашиглах аргачилсан зааварчилгаа гаргах, хуулийн зүйл заалтыг хэрхэн ашиглах талаарх сургалтыг зохион байгуулах шаардлагатай.

⁵³ Конвенцид Европын зөвлөлийн гишүүн 47 улс, гишүүн бус 19 улс нэгдэж орсон.

Түүнчлэн, үйл ажиллагааны хувьд дараах зохицуулалт хийх шаардлагатай.

- Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн стандартанд оруулан, иргэдэд үйлчлэх чиг үүргийг бэхжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмж, боловсон хүчний чадвар, хандлагыг улам сайжруулах;
- Хууль сахиулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, шинэчлэлийг салбарын бодлого, хөгжлийн хөтөлбөртэй уялдуулж, олон улсын хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаатай уялдуулан зохион байгуулах;
- Хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах, чадавхжуулах, хууль сахиулагчдыг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх;
- Хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, дэд бүтцийг шинэчлэн, хуульд заасан үүргээ стандартын дагуу явуулах боломж бүрдүүлэх;
- Хууль сахиулах байгууллагуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог нэмэгдүүлэх;
- Хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн солилцоог сайжруулах, мэдээллийн нэгдсэн сантай болох, статистикийн мэдээлэл боловсруулах арга зүй, аргачлалыг сайжруулах;
- Хууль сахиулах байгууллагын шинэчлэл, дэд бүтэц, үйл ажиллагааны шинэчлэлд шаардагдах санхүү төсөвтэй байх, олон улсын байгууллагын дэмжлэг, хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг болно.

Б.Алтанхүү

МОНГОЛ УЛСЫН ХИЛ ХАМГААЛАХ САЛБАРЫН ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛ

Монгол Улсын хил тогтоогдож, баталгаажсан нь

XX зуунд Монгол улсын түүхэнд тохиолдсон томоохон үйл явдлуудаас 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон, 1924 онд анхны Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхаглан зарласан, 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүнээр элссэн зэрэгтэй дүйцэхүйц чухал үйл явдал бол Монгол Улс хөрш орнуудтайгаа хилийн гэрээ байгуулж улсын хилээ тодорхойлж, газар дээр нь тогтоон тэмдэглэж, тодотгосон явдал билээ. Үүгээрээ Монгол Улсын хил XX дугаар зууны дунд хагасаас олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, олон улсын гэрээгээр баталгаажсаны зэрэгцээ Монгол Улс нь дэлхийд газар нутаг, хилийн маргаангүй цөөхөн орны нэгэнд тооцогдох болсон.

Түүхэн талаасаа 1915 оны Монгол, Орос, Хятад гурван улсын Хиагтын гэрээгээр тогтоосон Хаант Монгол улсын нутаг дэвсгэрийн зах хязгаар нь одоогийн Монгол Улсын гадаад хилийн үндэс болж байна. Монгол Улсын хойд хилийг Монгол Улс Манж чин улсад дагаар орсны дараа Хаант Орос улс, Манж Чин улсын хооронд байгуулсан 1689 оны Нерчүүгийн хилийн гэрээ, 1727 оны Буурын болон Хиагтын гэрээ, 1864 оны Тарвагатайн протокол, 1881 оны Санкт-Петербургийн гэрээгээр анх үүсгэн тогтоожээ. Энэхүү түүхэн хилийг баримтлан БНМАУ, ЗСБНХУ (хуучин нэрээр)-ын хооронд байгуулсан 1958, 1976 оны хилийн гэрээнүүдээр Монгол Улсын ОХУ-тай хиллэдэг хойд хилийг тодотгож тогтоосон.

Хилийн шугамыг бодит газар дээр нь тогтоон тэмдэглэх ажлыг БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулсан Монгол-Зөвлөлтийн улсын хилийн тухай 1958 оны Гэрээ, 1959-1960 онд хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэсэн баримт бичгийн дагуу 1977-1979 онд явуулжээ. Монгол, Оросын улсын хилийн анх удаагийн хамтарсан шалгалтыг 1987-1996 онд хийж дуусгасан.

Монгол Улсын БНХАУ-тай хиллэдэг өмнө зүгийн хил нь 1695-1850 онд орон нутгийн хэмжээнд Ар, Өвөр Монголын эртний аймаг, хошуудын бэлчээр нутгийн хуваариас үүсгэн тогтоогдож, овоо тэмдгүүдээр тэмдэглэгдсэн байдаг. Энэхүү хилийг үндэслэн Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1962 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “БНМАУ ба

БНХАУ-ын хилийн Гэрээ”-гээр Монгол Улсын өмнөд хилийг тодорхойлон тогтоосон.

1964 оны 06 дугаар сарын 30-ны өдөр гарын үсэг зурсан “БНМАУ-ын Засгийн газар ба БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан хоёр улсын хилийн тухай Протокол”-ын дагуу 1962-1964 онд хилээ газар дээр нь тогтоон тэмдэглэж, 1982-1984 онд анх удаа хамтран шалгаж, хоёр дахь удаагийн хамтарсан шалгалтыг 2001-2005 онд явуулж дуусгасан. 1962 оны “БНМАУ ба БНХАУ-ын хилийн гэрээ”-г НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газарт олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн 14375 тоот бүртгэлд 1975 оны 10 дугаар сарын 09-нд бүртгүүлснээр манай улсын өмнөд хил эрх зүйн хувьд олон улсын хэмжээнд баталгаажсан байна.

Хил хамгаалах байгууллагын үүсэл хөгжил

1911 онд Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тогтоосны дараа Богд хаант Монгол Улсын Засгийн газар хойт зүгийн зах хязгаарыг хамгаалж ирсэн эртний өрхийн гэр болон суман харуулуудыг өөрчлөн зохион байгуулж, Хаант Орос, Монгол Улсын хилийг өрхийн харуулуудаар хамгаалуулж, тэдгээр нь улсын хил хамгаалахын зэрэгцээ сүм, дуган шүтээний бүрэн бүтэн байдлыг давхар хариуцдаг байлаа. Улсын хилийг тогтоон тэмдэглээгүй, хилийн шугамын явалт тодорхой болж олон улсын гэрээгээр баталгаажаагүй энэ үед газар нутгийн хязгаарыг цөөн тооны харуулаар мануулж байсан байна.

1930-аад оны эхээр хурцадсан Монгол улсын гадаад, дотоод цэрэг, улс төрийн нөхцөл байдалтай уялдуулан тухайн үед үйл ажиллагаа явуулж байсан хилийн харуулын цагдааг татан буулгаж, улсын хилийг мэргэжлийн цэргийн хүчээр хамгаалах зорилгоор хилийн отряд, комендатуруудыг байгуулж эхэлжээ. 1933 оны нэгдүгээр сарын 20-ны өдрийн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 3 дугаар тогтоолоор Дотоодыг хамгаалах газарт Цэргийн бөгөөд Хязгаарын хэлтэс байгуулж, баруун ба өмнөд хязгаарыг хамгаалах үүрэг бүхий анхны хилийн отряд, комендатуруудыг байгуулснаар орчин үеийн Хил хамгаалах байгууллага үүссэн байна.

Уг хэлтэс 1940 онд Дотоод явдлын яамны харьяанд Цэргийн ба хязгаарын хэргийг удирдах газар болж өргөжсөн боловч 1945 онд дэлхийн II дайн дуусч, олон улсын хамтын ажиллагааны шинэ үе эхэлж, хөрш улсуудтай найрсаг харилцаа хөгжиж ирснээр 1950-иад оны эхээр Хязгаарын цэргийг татан буулгав. 1950-1955 онд Дотоод явдлын яаманд Хязгаарын ба дотоодын цэргийн албыг эрхлэх хэлтэс, 1955-1959 онд

Цэргийн ба Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа Хилийн албаны хэлтэс тус тус байгуулан, тэдгээрийн харьяа хилийн пункт, байцаан өнгөрүүлэх цэгүүдийн цомхон хүчээр улсын хилийн дэглэм, журмыг түүхийн энэ зурвас үед сахиулж байжээ.

“Хүйтэн дайн”-ы үе болох 1960-аад оны үеийн олон улсын цэрэг, улс төрийн нөхцөл байдалтай уялдуулан 1959 онд Нийгмийг Аюулаас Хамгаалах яам (НАХЯ) байгуулагдав. Хязгаарын цэргийг дахин байгуулах шаардлага бий болж, тус яамны бүтцэд Хилийн албаны хэлтсийг, 1967 оноос НАХЯ-ны Хязгаарын ба Дотоод цэргийн хэрэг эрхлэх газрыг байгуулж, 1979 оноос Хязгаарын ба Дотоодын цэргийг удирдах ерөнхий газар болсон байна.

1990 оны эхээр Монгол улс ардчилсан зах зээлийн шинэ нийгэмд шилжснээр НАХЯ татан буугдаж түүний оронд байгуулагдсан Улсын Аюулгүй байдлыг хангах ерөнхий газар (УАБХЕГ)-ын харьяанд Хилийн цэрэг тодорхой хугацаанд үйл ажиллагаагаа явуулав. 1993 онд Хилийн тухай хууль шинээр батлагдаж Хилийн цэргийг удирдах газар (ХЦУГ) байгуулагдав.

ХЦУГ нь 1996 он хүртэл Засгийн газрын дэд бүтцийн бие даасан байгууллагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд 1996-2000 онд Батлан хамгаалах яамны харьяа Засгийн газрын тохируулагч агентлаг - Хилийн цэргийг удирдах газар, 2000 оноос Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Засгийн газрын тохируулагч агентлаг - Хилийн цэргийг удирдах газар нэртэйгээр тус тус үйл ажиллагаагаа явуулав. 2002 оноос нэр нь Хил хамгаалах ерөнхий газар болж, түүнээс хойш Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Засгийн газрын тохируулагч агентлагийн статустайгаар ажиллаж ирлээ.

Орчин үеийн хил хамгаалах байгууллага үүссэн үеэс эхлэн Хил хамгаалах байгууллага нь 1939 оны Халхын голын дайн, 1945 оны чөлөөлөх дайн, 1940-1948 оны баруун хилийн тулгаралт, байлдаануудад амжилттай оролцож, олон зуун хилчид эх орныхоо тусгаар тогтнол, улсын хилийн халдашгүй дархан байдлын төлөө алтан амиа зориулж, 14 Монгол улсын баатар эх оронч хилчдийг эгнээнээсээ төрүүлсэн байдаг.

Хил хамгаалах байгууллага нь орчин үеийн хил хамгаалах байгууллага үүсэн бие болсон цагаас хөгжлийн цаг хугацааны турш туршлагажин хөгжиж, мэргэшсэн бие бүрэлдэхүүн, тогтсон бүтэц, бүрэлдэхүүн, арга тактикийн, эх оронч үзэл баримтлалтай, нийгэмд танигдсан, нэр хүндтэй, орчин үеийн мэргэжлийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага болон хөгжиж ирсэн.

Улсын хил хамгаалах бодлого, эрх зүй

Хилийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд “Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ” гэж заасан.

Монгол Улсын хилийн харилцаа 1970 оныг хүртэл НАХЯ, ХЦУГ-ын тусгай дүрэм, заавраар зохицуулагдаж байсан бөгөөд улсын хил, хилийн харилцаа, хил хамгаалах байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт, хилийн асуудлыг тусгайлан хуулиар зохицуулах бодит шаардлага зэргийг харгалзан БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1973 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 161 дүгээр зарлигаар анхны “БНМАУ-ын Хил хамгаалах хууль”-ийг батлан мөрдүүлсэн.

Энэ хууль нь Монгол улсын хилийн харилцаатай холбоотой асуудлыг зохицуулах эрх зүйн шинэ орчин бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой байсан бөгөөд тухайн үеийн улсын хилийн талаарх бодлого нь улсын хилийн хамгаалалт, ялангуяа Монгол - Хятадын хилийн хамгаалалтыг бүхэлд нь сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал байжээ. Хэдийгээр энэ хууль батлагдан мөрдөгдөж байсан ч 1958, 1976 оны БНМАУ, ЗСБНХУ-ын Хилийн гэрээ, 1980 оны Монгол - Зөвлөлтийн улсын хилийн дэглэм, хилийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын гэрээ, 1962 оны БНМАУ, БНХАУ-ын хилийн гэрээ, 1988 оны Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай БНМАУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ зэрэг Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, баримт бичгүүд 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль, 1993 оны Хилийн тухай хууль батлагдах хүртэл хугацаанд бүрэн утгаараа хэрэгжиж байсан билээ.

Энэ хугацаанд Монгол Улсын БНХАУ-тай хиллэдэг өмнөд хилийн хамгаалалтад ихээхэн ач холбогдол өгч өндөр хэмжээнд цэрэгжүүлэн хамгаалж байсан бол хуучнаар ЗХУ-тай хиллэдэг байсан хойд хилд

“найрамдлын хил” нэрэн дор хамгаалалтын нягтрал бага цөөн тооны хилийн пункт, байцаан өнгөрүүлэх цэгүүд ажиллаж байв. Тухайн үеийн төр засгаас улс орны гадаад, дотоод нөхцөл байдлыг харгалзан 1960-аад оноос өмнөд хилийн, 1990-ээд оноос нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг харгалзан хойд хилийн хамгаалалтыг бэхжүүлэх талаар дэс дараатай арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн байна.

Энэ үед үндсэндээ хамгаалалтгүй шахам байсан хойд хилийн хамгаалалтыг бэхжүүлэх хүрээнд хил хамгаалах байгууллагын анги, салбар байгуулах, чадавхжуулах арга хэмжээг нэгэн зэрэг авч хэрэгжүүлсний үр дүнд Монгол улсын хил бүрэн хэмжээгээр Хил хамгаалах байгууллагын хяналтад хамрагдсан юм.

Тухайн үед улсын хил хамгаалалт дэлхийн II дайнаас хойш тухайн үеийн социалист, капиталист нийгмүүдийн үзэл суртлын зөрчлийн нөлөөгөөр зонхилох шинжтэй байсан хил дамнасан тагнуул, туршуул, үзэл суртлын эсрэг үйл ажиллагаа, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, улс төрийн шинжтэй гэмт хэргийн эсрэг тэмцэхэд чиглэж байсан. 1990-ээд оны нийгмийн шилжилтээс хойш хил хамгаалалтын асуудал ашиг орлого олох зорилготой зохион байгуулалттай бүлэг болон ганцаарчилсан этгээдүүдийн бараа бүтээгдэхүүн, хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг галт хэрэгсэл, мал амьтан хууль бусаар хил давуулах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа болсон байна.

Хил хамгаалах байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт

Монгол Улс 1990-ээд оны эхээр ардчилсан нийгэмд шилжсэний дараахан 1992 онд шинээр батлагдсан Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд ...“Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна. Монгол Улсын хилийг хуулиар бататгана”... гэж заасан байдаг. Шинээр батлагдсан Үндсэн хуулийн үзэл агуулга, дээрх заалтын дагуу Монгол Улсын Их Хурлаас 1993 онд Хилийн тухай хуулийг баталж, шинэ улс төр, нийгмийн тогтолцоонд улсын хилийн хамгаалалтыг улс орны хэмжээнд удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Хил хамгаалах байгууллагын тогтолцоо, бүрэн эрхийг анх тодорхойлж өгсөн.

2016 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх хэсэгт ...“Хил хамгаалах байгууллага гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбар”... гэж заасан.

Улсын хил хамгааллын асуудал нь Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бөгөөд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах төрийн захиргааны байгууллага болох Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ) нь мөн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ХХЕГ-аас гадна Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар гэсэн 5 агентлаг үйл ажиллагаа явуулдагаас ХХЕГ болон ЦЕГ нь Засгийн газрын тохируулагч агентлагийн статустайгаар ажиллаж байна.

Хил хамгаалах байгууллагын үндсэн хүч хэрэгсэл нь Хилийн цэрэг байх бөгөөд хилийн цэрэг нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай штаб, анги, салбар, зэвсэглэл, техник, ар тал, хангалт, эмнэлэг, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжтэй байна. Хилийн цэрэг нь бие даасан үүрэг гүйцэтгэх бөгөөд бүтэц, чиг үүргийг нь хуулиар тусгайлан тогтооно. Тайван цагт төрийн цэргийн байгуулалд багтаж, дайны байдлын үед зэвсэгт хүчний бүтцэд үүрэг гүйцэтгэх эрх зүйн зохицуулалттай. Хилийн цэрэг нь цэргийн нийтлэг дүрэм журмуудыг дагаж мөрдөж, цэргийн алба хаагчийн эрх зүйн хэм хэмжээгээр олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

Үйл ажиллагааны хувьд шинэчлэн батлагдсан Хилийн тухай хуулиар Улсын хил хамгаалах байгууллагын чиг үүргийг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

1. улсын хилийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
2. улс орны хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах;
3. хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, улсын хилийн дэглэмийг сахиулах;
4. улсын хилийн шугамыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх;
5. хил орчмын дэглэмийг сахиулан, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хилийн зөрчлийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх;
6. улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах;

7. улсын хилийн зурвас, хилийн боомтод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох арга хэмжээ авах;
8. хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох;
9. агаарын хилийг зөрчсөн байж болзошгүй нисгэгчтэй болон нисгэгчгүй нисэх хэрэгслийг зэвсэгт хүчний агаарын цэргийн анги, салбарт шуурхай дэмжуулах;
10. хуульд заасан бусад чиг үүрэг.


Хил хамгаалах байгууллага Монгол Улсын Хилийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого зэрэг баримт бичгийг удирдлага болгон 1962 оны Монгол - Хятадын хилийн гэрээ, 2010 оны Монгол - Хятадын хилийн дэглэмийн гэрээ, 1958, 1976 Монгол - Оросын хилийн гэрээ, 2006 оны Монгол - Оросын хилийн дэглэмийн гэрээ, хилийн асуудлаар байгуулсан бусад хэлэлцээр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэм”, “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.

Хил хамгаалах байгууллага нь ХХЕГ, хилийн цэргийн штаб, хилийн отряд, анги, застав, харуулын зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсын хилийн хамгаалалтыг хилийн болон шалган нэвтрүүлэх отряд, түүний харьяа застав, хангалт үйлчилгээний ангиудын хүч хэрэгслээр төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагууд, хууль, хүчний байгууллагуудтай хамтран ажиллаж, хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугаа ард иргэдийн туслалцаанд түшиглэн зохион байгуулдаг.

Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүн


Хил хамгаалах байгууллагын байнгын бүрэлдэхүүнд офицер, ахлагч, энгийн ажилтнууд, байнгын бус бүрэлдэхүүнд гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчид үүрэг гүйцэтгэдэг.

График 1. Хил хамгаалах байгууллагын байнгын бүрэлдэхүүний боловсролын эзлэх хувь.




Боловсролын хувьд офицеруудын 94.5 хувь, ахлагч нарын 21.8 хувь, энгийн ажилтнуудын 20 хувь, нийт албан хаагчдын 42,5 хувь нь дээд боловсролтой байна.

График 2. Хил хамгаалах байгууллагын байнгын бүрэлдэхүүний хүйсийн харьцаа.



Хил хамгаалах байгууллагын нийт алба хаагчдын 64.7 хувийг эрэгтэй, 35.3 хувийг эмэгтэй албан хаагчид эзлэж байна. Офицрийн бүрэлдэхүүний 86.6 хувь нь эрэгтэй, 13.4 хувь нь эмэгтэй, ахлагчийн бүрэлдэхүүний 78.4 хувь эрэгтэй, 21.6 хувь эмэгтэй, энгийн албан хаагчдын 20.7 хувь эрэгтэй, 79.3 хувь эмэгтэй байна.

**График 3. Хил хамгаалах байгууллагын байнгын
бүрэлдэхүүний насны байдал.**



Насны хувьд офицеруудын 73.0 хувь, ахлагч нарын 78.4 хувь, энгийн ажилтнуудын 54.7 хувь, нийт албан хаагчдын 62.9 хувь нь 18-35 настай байна.

Хүний нөөцийн боловсрол, хилийн сургууль

Цэргийн мэргэжлийн офицер, ахлагч нарыг гадаад, дотоодын цэргийн сургуульд, тусгай мэргэжлийн албан тушаалтныг гадаад, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд гэрээгээр, удирдах албан тушаалтныг гадаад, дотоодын цэргийн академи, Хууль сахиулахын их сургуулийн болон бусад их дээд сургуулийн магистр, докторын сургалтаар тус тус бэлтгэдэг. Тусгай мэргэжилтэй боловсон хүчнийг иргэний их, дээд болон тусгай мэргэжлийн сургууль төгсөгчдөөс судалгаа хийж, сонгон шалгаруулж Хилийн сургуульд цэргийн албаны сургалтад хамруулна.


Хил хамгаалах байгууллагын ахлагчийн албан тушаалд ажиллахаар мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн иргэнийг харуулын дарга, хилчин-шалгагч, гэрээт хилчин, холбоочин, албаны нохой хөтлөгч, сургагч, хөгжимчин, зэвсгийн бага мэргэжилтэн, жагсаалын дарга, бичиг хэрэг, архивын ажилтан зэрэг чиглэлээр сургалтад хамруулж, мэргэжил эзэмшүүлдэг.

Бусад тусгай мэргэжлийн хүмүүсийг мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд захиалгаар бэлтгэнэ. Гадаад хэлний анхан шатны сургалтыг өөрийн харьяа нэгжүүдэд, дунд ба гүнзгийрүүлсэн шатны сургалтыг Хил хамгаалах ерөнхий газар, Хууль сахиулахын их сургуулийн гадаад хэлний тэнхим болон бусад гадаад, дотоодын сургалтаар зохион байгуулна.

Офицерийн бүрэлдэхүүнийг ХХЕГ-ын харьяа Хилийн цэргийн дээд сургуульд бэлтгэж ирсэн бөгөөд уг сургууль 2010 онд шинээр байгуулагдсан Дотоод хэргийн их сургуулийн бүтцэд Хилийн албаны дээд сургууль нэрээр шилжсэн. 2013 оноос ДХИС нь Хууль сахиулахын их сургууль болж өөрчлөгдөхөд Хилийн албаны дээд сургууль Хилийн сургууль нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. ХСИС-ийн Хилийн сургуульд 4 жилийн хугацаатайгаар офицер цолтой бүрэлдэхүүнийг Хил хамгаалах байгууллагын захиалгаар бэлтгэж байна.

Хилийн сургууль нь ХСИС-ийн бүрэлдэхүүн 7 сургуулийн нэг бөгөөд дараах бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хилийн сургуулийн бүтэц



Хилийн сургуульд хилийн алба, хилийн хяналт, байгууламжийн ашиглалтын алба, Хилийн боомтын аюулгүй байдлын алба, Ар талын алба, Мэдээлэл, соёл, сурталчилгааны албаны мэргэжлээр баклаврын, Хил судлал, Хил хамгаалалтын стратеги-тактик, команд-штабын мэргэжлээр магистрын, Хил судлалын мэргэжлээр докторын зэрэг тус тус хамгаалуулдаг.

Гадаадын болон дотоодын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагаа

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дурдсанаар Монгол Улсын оршин тогтнохуйн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болсон хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах гол механизм болсон Хил

хамгаалах байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий бусад байгууллагуудтай Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр нягт хамтран ажиллана.

Үүний зэрэгцээ үндсэн чиг үүрэг-улсын хилийн хамгаалалтын асуудлаар өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд улсын хил дээр гарсан зэвсэгт халдлага, түрэмгийллийг таслан зогсоох ажиллагаа, шаардлагатай тохиолдолд хил хамгаалалтад дэмжлэг авах асуудлаар Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Зэвсэгт хүчний жанжин штабтай, улсын хилд гарч болзошгүй болон гарсан гэмт хэрэг, зөрчлийн асуудлаар Тагнуулын болон Цагдаагийн байгууллагуудтай, хилийн хэсэгт гарсан байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх асуудлаар Онцгой байдлын байгууллагатай, мөн хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахтай холбоотой асуудлаар холбогдох бусад байгууллагатай тус тус хамтран ажиллана.

Зэвсэгт хүчний жанжин штаб, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газартай онцгой нөхцөл байдал үүссэн үед шат шатанд харилцах, хамтран ажиллах, команд - штабын дадлага, сэдэвчилсэн сургуулиудыг зохиох, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудтай тэмцээн, уралдаан зохион байгуулах, хууль хяналтын байгууллагуудтай харилцан мэдээ, мэдээлэл солилцох журам байгуулан хамтран ажиллаж байна. Мөн улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангуулж, боомтын журам сахиулах чиг үүргийн хүрээнд хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй гааль, мэргэжлийн хяналт, гадаадын иргэн, харьяатын алба зэрэг хилийн хяналтын байгууллагуудтай харилцан ажиллагааг зохион байгуулж, хамтран ажиллана.

Түүнчлэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан улсын хилийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг холбогдох хуульд заасны дагуу хэрэгжүүлэхийн зэрэгцээ төрийн захиргааны бусад байгууллага, аж ахуйн нэгж нь Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, улсын хил хамгаалах байгууллагад дэмжлэг, туслалцаа үзүүлж, хил хамгаалалтад шаардагдах бүтээгдэхүүнээр тэргүүн ээлжинд хангаж, хамтран ажиллах хууль зүйн зохицуулалттай.

Хил хамгаалах байгууллага нь ОХУ, БНХАУ-тай хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор

ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны Хилийн алба, БНХАУ-ын НАХЯ-ны Хилийн цэргийг удирдах газар, БХЯ-ны Байлдааны бэлтгэлийн газрын Хил хамгаалах газартай удирдлагын төвшинд уулзалт, хэлэлцээ хийж, уулзалтын протокол, хөтөлбөр байгуулж нягт хамтран ажиллахын зэрэгцээ хоёр улсын хилийн дэглэмийг хүндэтгэн сахиулах зорилгоор хилийн төлөөлөгчийн шугамаар тодорхой хилийн хэсэгт хилийн асуудлыг хамтран шийдвэрлэж, улсын хилийг хамтран хамгаалах зарчмыг баримтлан ажиллаж байна. Мөн БНЭУ, Финлянд, Европын холбооны гадаад хил хариуцсан хилийн агентлаг Фронтекстэй туршлага солилцох чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Өнөөгийн Хил хамгаалах байгууллага нь хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, улсын хил хамгаалалтад холбогдох хууль, тогтоомж бусад эрх зүйн актуудыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн өөрчлөх, тодотгох; улсын хил хамгаалалтад гэрээт хилчний албыг нэвтрүүлж, боловсронгуй болгох; хил хамгаалалтыг байгаль, цаг агаар, газар орон, цагийн байдал, хүч хэрэгсэлдээ тохируулан бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах; хил хамгаалах байгууллагын илт тод нээлттэй байдлыг сайжруулах, байгууллагын чадавхи, гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх; хил хамгаалалтад орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1993 онд Хилийн тухай хууль батлагдсанаас хойш түүнд 13 удаа нэмэлт, өөрчлөлт хийгдсэн боловч 2014 оныг хүртэл зарчмын шинжтэй нэмэлт өөрчлөлтүүд орж байсангүй. 2014 онд Хилийн боомтын тухай хууль батлагдан гарч, Хилийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, мөн оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хилийн шалган нэвтрүүлэх албыг Хил хамгаалах ерөнхий газрын бүтцээс гаргаж Гадаадын иргэн, харьяатын албанд шилжүүлэн тус газрыг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар болгон өөрчилсөн. Үүгээр Хил хамгаалах байгууллага нь боомтын аюулгүй байдал, боомтын журмын хэрэгжилтыг дагнан хариуцах болж мөн Замын-Үүд, Алтанбулагийн чөлөөт бүсийн хамгаалалтыг хариуцах болсон.

2016 онд хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн болон хил орчмын дэглэм, хилийн боомт, түүнд мөрдөх журмын зохицуулалтыг боловсронгуй болгох, хилийн нөхцөл байдал, байгаль орчин, цаг агаар, физик, газар зүйн онцлогт тохируулан улсын хил хамгаалалтыг бүсчлэн

зохион байгуулах, хилийн аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагын тогтолцоо, хилчдийн эрх зүйн байдал, улсын хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоог шинэчлэн тодорхойлох, хуульд хэрэглэсэн нэр томъёог олон улсын эрх зүйн зарчим, Монгол Улсын Их Хурлаас 2010 онд баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-тай нийцүүлэх, улсын хил хамгаалалтыг олон улсын төвшинд хүргэх шаардлага зүй ёсоор гарч байгаатай холбогдуулан Хилийн тухай хуулийг шинэчилэн найруулж УИХ-д өргөн мэдүүлсэн нь 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдав.

Энэ хуулийн хүрээнд 2014 онд ХХЕГ-аас шилжүүлсэн улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх чиг үүргийг Гадаадын иргэн, харьяатын газраас Хил хамгаалах ерөнхий газарт буцааж харьяалуулсны зэрэгцээ улсын хил хамгаалалтыг өөрийн улсын онцлогт тохирсон бүсчилсэн байдлаар зохион байгуулах, түүнтэй холбоотой зохицуулалт, улсын хил дамнасан гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хил орчмын нутаг дэвсгэрт ард, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах үед тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх үндэслэл, улсын хилийн аюулгүй байдлыг хангахад оролцох төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг тодотгож, Улсын хил хамгаалахад туслах хүчний зөвлөл, туслах хүчний гишүүн, иргэний эрх, үүргийг тус тус нарийвчлан тусгасан нь Монгол Улсын хил, хилийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгоход чухал алхам болсон. Шинээр батлагдсан хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хил хамгаалалтын чиглэлээр мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг шинэчлэх, шинээр боловсруулах шаардлага урган гарч байна.

2006 оноос Хил хамгаалах байгууллагад цэргийн алба хаасан иргэдээс сайн дурын үндсэн дээр шалгаруулан авч, улсын хилийг гэрээний үндсэн дээр хамгаалуулах шинэ тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү гэрээт хилчин төслийг улам бүр боловсронгуй болгож, хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлж, тэдгээрт тавих шаардлага, чадавхыг өндөржүүлэн төслийг үе шаттайгаар өргөжүүлснээр хил хамгаалах бүрэлдэхүүний дунд эзлэх гэрээт хилчдийн хувь хэмжээ өсөн нэмэгдэж, хил хамгаалалтын үр дүн дээшилж, хил хамгаалах албыг мэргэжлийн чиг хандлагатай болгож хөгжүүлэх зорилтын хэрэгжилтэд ахиц гарч байна.

Улсын хил хамгаалалтыг олон улсын жишигт нийцүүлж, өөрийн улсын байгаль, газар зүй, цаг агаарын онцлогт тохирсон бүсчилсэн байдлаар зохион байгуулах ажлыг эхлүүлж, улсын хилийг бүсчилсэн хамгаалалтад шилжүүлэх ажиллагааны хүрээнд олон улсын эрдэм

шинжилгээний хурлууд, судалгаа шинжилгээний ажлуудыг гүйцэтгэж, “Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталгаажуулан үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Шинээр батлагдсан Хилийн тухай хуулиар бүсчилсэн хил хамгаалалтын эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн.

Улсын хил хамгаалалтад хяналт, дохиолол, холбооны зориулалттай орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын цаг уур, газар орны нөхцөл байдалд нийцсэн, улсын хил хамгаалалтын онцлогт тохирсон дэвшилтэд техник, технологийн талаар судалгаа явуулж, гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарсан туршилт, судалгаануудыг зохион байгуулж, хилийн зарим хэсгийн хамгаалалтад оруулж эхэлсэн. Ялангуяа нисгэгчгүй бага, том оврийн нисэх хэрэгсэл, хүн, тээврийн хэрэгслийг илрүүлэх, мэдрэх, мэдээллэх төрөл бүрийн мэдрэгч, радар, кабель, утсан болон инфра мэдрэх төхөөрөмжүүдийг дурдаж болно.

Монгол Улсын хил хамгаалалтад орон нутгийн төрийн болон өөрөө удирдах байгууллагууд, иргэн, аж ахуйн нэгж байгууллага чухал үүрэгтэй байна. Монгол Улсын Хилийн тухай хууль, Ерөнхийлөгчийн зарлигаар улсын хил хамгаалалтад иргэдийг оршин суугаа байрлалаар нь оролцуулах эрх зүйн үндэстэй. Улсын хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг татан оролцуулах чиглэлд анхаарч, хил хамгаалалтад тэдний идэвх оролцоог нэмэгдүүлэх чиглэлд тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна. Орон нутгийн аймаг, сумдын удирдлага, хууль хяналтын байгууллагын салбар, нэгжүүд, улсын хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийн хамтарсан зөвлөлгөөнийг бүсчилсэн байдлаар нэгтгэн зохион байгуулж, орон нутгийн байгууллага, иргэдтэй хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

Дүгнэлт

ХХ зууны Монгол Улсын түүхэнд орох томоохон үйл явдал бол хөрш улсуудтай олон улсын гэрээгээр улсын хилээ тогтоож, баталгаажуулсан, газар нутаг, хил хязгаарын аливаа маргаангүй байгаа явдал юм. Монгол Улсын төр, засгаас хоёр хөрштэйгээ байгуулсан хилийн гэрээнүүдийг улам баталгаажуулж, хилийн нийт шугамын дагуу хамтарсан шалгалтуудыг хийж, улсын хилийн шугамын явалтыг илүү тодорхой болгож, хилийн дэглэмийн гэрээнүүдийг тухай бүрт нь шинэчилж, эдгээрт нийцүүлэн улсын хил хамгаалах албаны дүрэм, журам, заавруудаа өөрчлөн шинэчилж, улсын хилээ улам найдвартай хамгаалах талаар олон чухал

арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсний үр дүнд хилийн асуудлыг гэрээ хэлэлцээрийн арга хэрэгслээр шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлж чадсан байна.

Бодлогын үүднээс ОХУ-тай байгуулсан хилийн гэрээг НҮБ-д бүртгүүлэх, хилийн дэглэмийн гэрээнүүдийг чанд хэрэгжүүлэх, энэ зорилгоор хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, Монгол, Оросын улсын хилийг хамтран шалгах, багана, тэмдэг, хилийн шугамын явалтыг сэргээх, шинэчлэх ажлыг ойрын хугацаанд ОХУ-ын талтай хамтран зохион байгуулах, хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг мэргэжлийн чиг хандлагатай болгох, гэрээт хилчний албыг олон улсын жишигт нийцүүлэн төлөвшүүлэх, Хил хамгаалах байгууллагыг хөгжүүлэх (хүний нөөцийг чадавхжуулах, зэвсэг, техник хэрэгсэл, бие бүрэлдэхүүний нийгмийн асуудал, орон сууцны асуудлыг шийдвэрлэх), хил орчмын дэд бүтцийг сайжруулах (хязгаар нутгаа эзгүйдэхээс хамгаалах бодлого, улсын төв-бүсийн төв-хил хязгаар-т төвлөрсөн хөгжлийн төвүүд) зэрэг олон чухал асуудлыг өнөөгийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэл, хандлага, чадавхтай уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хил хамгаалалтад дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх нь цөөн хүн амтай, том газар нутаг, урт хил хязгаартай Монгол орны хувьд чухал асуудал юм. Орчин үеийн хяналт, дохиолол, мэдээллийн хэрэгслийг нэвтрүүлж, ашиглах нь хэдийгээр улс орны зүгээс тодорхой хэмжээний санхүүжилт шаардах боловч тодорхой хугацааны дараа хүн хүч, зардал хэмнэх, хилийн аюулгүй байдлыг найдвартай хангах нөхцөл болж байгаа юм.

Өнөөгийн Хил хамгаалах байгууллага нь өөрийн гэсэн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүн, арга тактик, хүч хэрэгсэл бүхий баатарлаг түүхтэй, эх оронч үзэл баримтлал, мэргэжлийн хилчидтэй, орчин үеийн Монгол төрийн мэргэжлийн тусгай алба болон төлөвшиж, Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн аюулгүй байдлыг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэж байна.

Ж. Мөнхболд

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛ

Түүхэн товчоо

Аливаа тусгаар улсын төрийн байгуулалтын тогтолцоонд улс орны хууль, эрх зүйн хэм хэмжээ, хүн амыг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, өмч хөрөнгийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалах үндсэн бүтэц нь Цагдаагийн байгууллага байдаг. Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангаж ирсэн орчин цагийн цагдаагийн үйл ажиллагааг эрдэмтэн судлаач нар дараах байдлаар түүхчлэн үечилж иржээ.

Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын үе /1911-1920 он/

Тухайн үеийн Монгол Улсын цагдаагийн зохион байгуулалт нь ерөнхий харьяаллаараа цэргийн яаманд харьяалагдаж, манаа цагдаагийн хороо, дотоодын цэрэг гэсэн үндсэн 2 нэгжтэй, тодорхой нутаг дэвсгэрт үйл ажиллагааны чиглэлээсээ хамаарч ангийн зохион байгуулалттай морьт цагдаа, явган цагдаа гэсэн хэлбэртэй байв. Үндсэн үйл ажиллагаа нь объектын болон нутаг дэвсгэрийн эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэж байжээ⁵⁴. Морьт цагдаа нь албан зарлага хийх, хоригдсон этгээдийг хянан харгалзах, яамдын харуулын үйл ажиллагааг эрхлэх зэрэг үндсэн үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ 1913 оны 9 сараас гэмт хэрэг илрүүлэх, тагнах үйл ажиллагаа явуулах үүрэг гүйцэтгэдэг болжээ. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх цагдаагийн үйл ажиллагаанд дорвитой өөрчлөлт гарахгүй байсан тул цагдаагийн үүрэгт зарим өөрчлөлт оруулж олон яамд, ноёдын манаа, хорих ял эдэлж буй этгээдийг хянан харгалзах үйл ажиллагааг хязгаарлаж, Усан хөөргийн газарт⁵⁵ цагийн манаа суулгаж, гал гарвал цэргийн яамнаас хүч нэмэгдүүлж ажилладаг байв. Улаанбаатар хотын эргүүл, харуул, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг Дотоод хэргийг бүгд ерөнхийлөн шийтгэх яам⁵⁶ дангаар захирах болжээ.

⁵⁴ Энэ үеийн цагдаагийн эргүүлийн талаар тухайн үед Монголд ирж байсан Оросын эрдэмтэн Майский: "Монголд байгаа наймаачин газар сайгүй л өөрийн цагдаагийн онцгой газартай, цагдаагийн онцгой манаатай, мөн Өргөө, Хиагт, Улиастай, Ховдод байх түшмэдийн дэргэд консулын онцгой шүүхтэй байх ажээ" гэж тэмдэглэжээ.

⁵⁵ Гал түймэртэй тэмцэх газар

⁵⁶ УТА.хөмрөг а-3, данс 1, хадгаламжийн нэгж 295. Хуудас 2.

“Социализм” байгуулалтын үе /1921-1989/

1924, 1940, 1960 онд БНМАУ-ын Үндсэн хуулийг шинэчлэн баталсантай уялдуулж, шүүх, хууль сахиулах тогтолцоог тухайн үедээ боловсронгуй болгож, НАХЯ-ны бүтцэд Цагдан сэргийлэх байгууллагыг хамааруулан, чиг үүргийг нь тодорхойлж иржээ. Тухайлбал, цагдан сэргийлэх анги, хороо, хэлтэс, газар байгуулагдсан нь бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчний хувьд тус байгууллагын хөгжлийг зохих төвшинд хүргэж, үүнтэй холбоотойгоор цагдан сэргийлэхийн дүрэм, журам, заавар, удирдамж зэрэг эрх зүйн баримт бичиг мөрдөж байв⁵⁷.

1921 оны 3 сарын 24-ны өдөр Түр засгийн газар, МАН-ын төв хорооны хамтарсан хурлаар Цэргийн яамны бүрэлдэхүүнд “Сэргийлэх салаа” байгуулж, тухайн салааны үүргийг ард түмний амь бие, эд хөрөнгөд халдагсадтай тэмцэх, хувьсгалт хэв журам, энх амгалан байдал сахиулах гэж тодорхойлсон байна.

1932 оны 2 сард Улаанбаатар хотын цагдаагийн газрыг дотоодыг хамгаалах газрын харьяанд шилжүүлж, 1934 оны 2 сард “Ардын цагдан сэргийлэх газрын шинэ дүрэм”-ийг баталж, үйл ажиллагааны журмыг тодорхойлж, боловсон хүчний нөөцтэй болох байнгын болон түр курстэй байхыг заасан байна.

1936 онд Дотоодыг хамгаалах газрыг Дотоод явдлын яам болгон өөрчлөхөд Цагдан сэргийлэх газар нь тус яамны харьяа бие даасан газар болж өргөтгөн зохион байгуулагдсан байна. Гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг өргөтгөн зохион байгуулж, гүйцэтгэх албаны хэлтэс болгон зохион байгуулж, 1937 онд эрүүгийн тасаг, 1938 онд эдийн засгийн тасаг, 1940 онд хурууны хээний шинжээч, гэрэл зургийн лабораторитой болж гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа шинжлэх ухааны ололт ашиглаж эхэлсэн байна. 1939 оноос гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хууль сурталчлах ажлыг хийж эхлэхийн зэрэгцээ ард иргэдэд тулгарах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэхүү бодлогын хүрээнд ядуучуудад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, сайн дурын уран сайханчдыг цагдаагийн нэрээр хөдөө орон нутагт урлагийн тоглолт хийлгэх зэрэг үйл ажиллагааг явуулж байж.

1936 оноос Цагдаагийн хүний нөөцийн боловсролын байдлыг анхаарч, алба хаагч нарт ерөнхий эрдэм, улс төр, газар зүй, хими, дотоод албаны дүрэм, сахилгын дүрэм, тусгай мэдлэг эзэмшүүлэх курс, семинаруудыг зохион байгуулж хэвшсэн байна.

⁵⁷ ХСИС-ийн дэд захирал, доктор, профессор Б.Бат-Эрдэнийн “Монгол Улсын цагдаагийн номлол” төслийн 8 дах тал. УБ., 2011 он.

1945 оны 7 дугаар сард Цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, мөрдөн байцаалт, хэргийн газрын үзлэг, нэгжлэгийг хуулийн дагуу хийх, олон нийтийн хамтын ажиллагааг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, өргөдөл гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх, хотын амгалан тайван байдлыг сахиулах, эргүүл шалгалтыг өргөн зохион байгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, удирдах болон бага тушаалын албанд цэргийн алба хаасан хүмүүсээс томилохыг чухалчлан авч үзэж байсан. Үүний зэрэгцээ гэмт хэрэгтэй тэмцэхэд шинжлэх ухаан, технологийн ололтыг ашиглах зорилгоор 1944 онд “Шинжлэн магадлах техникийн тасаг” байгуулжээ.

1946 оноос гүйцэтгэх ажилтнууд /төлөөлөгч/ эрүүгийн хэрэг бүртгэж, шүүхэд шилжүүлдэг байсныг өөрчилж мөрдөн байцаах албыг бие даалган зохион байгуулж байв⁵⁸.

1954 оноос ЗХУ-д цагдаагийн 2 жилийн курс, цагдан сэргийлэхийн дээд сургуульд алба хаагч нарыг сургах үйл ажиллагаа эхэлсэн байна.

1960 онд баталсан БНМАУ-ын Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах хэм хэмжээг баталгаажуулан заасан нь шүүх, хууль сахиулах байгууллагуудын ажлын хариуцлагыг өндөржүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн ба цагдаагийн байгууллагаас прокурор, шүүхийн байгууллагуудтай харилцан ажиллах тогтолцоо бүрджээ. 1960 оноос эхлэн Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг боловсруулж, тухайн үйл ажиллагааны гол чиглэлүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах⁵⁹, шинжлэх ухаан технологийг түлхүү ашиглах, тэргүүн туршлага, санаачлага нэвтрүүлэх гэж тодорхойлж байсан байна. Түүнчлэн, Цагдаагийн үйл ажиллагаанд туслах олон нийтийн бригад, өсвөрийн сэргийлэгчдийн бүлэг олноор байгуулагдаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болсон. Тухайн үед хийгдэж байсан чухал ажлын нэг нь өмчийн эсрэг⁶⁰ гэмт явдалтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, бүтцийн нэгжүүдэд эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн ажилтнуудыг томилж ажиллуулж эхэлсэн.

1980 оны эхэн үеэс олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, зарим хэлбэр /ардын нөхөрлөл,

⁵⁸ 2002 оны 9 сард гүйцэтгэх ажилтан- хэрэг бүртгэгч нарыг хэрэг бүртгэх эрхгүй болгож гүйцэтгэх ажлын чанар үр дүнг сайжруулах бодлого явагдсан.

⁵⁹ Гэмт хэргийн 10 жилийн судалгаа явуулж, судалгаанд үндэслэн Шүүх, Прокурор, НАХЯ, ХААЯ-наас хамтарсан ажил зохиож байсан. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дүн шинжилгээ хийж, тухайн дүн шинжилгээнд тулгуурлан дараагийн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулдаг болсон

⁶⁰ Эдийн засгийн гэмт хэрэг

олон нийтийн бригад/ бий болсон боловч тодорхой бодлого, номлолгүйн улмаас жинхэнэ утгаараа хэрэгжиж чадаагүй.

1970-1980 онуудад криминалистикийн албыг техник, тоног төхөөрөмжөөр хангах ажил идэвхтэй өрнөж, алба хаагч нарт криминалистикийн арга зүй, тактик эзэмшүүлэх сургалт зохион байгуулагдаж, хими физик, биологийн тусгай лаборатори, шинжээч бий болгохын зэрэгцээ БНАГУ, ЗХУ, БНСЧСУ, БНПАУ-ын тусламжаар төрөлжсөн лабораториудыг бэхжүүлсэн байна. 1970-1989 оны хооронд Монгол Улсын хүн амын тоо нэлээд хэмжээгээр нэмэгдэхийн хирээр гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдэж Цагдаагийн байгууллагад удирдлагын болон бүтцийн шинэчлэлт шаардлагатай болсон байна. Энэхүү ажлын хүрээнд 1980-1985 онд Цагдаагийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх үйл ажиллагаа явагдаж олон дүрэм, журам, заавар⁶¹ шинэчлэгдэн батлагджээ.

Ардчилал, шинэчлэлийн үеийн Цагдаагийн байгууллага /1990 оноос хойш/

Монгол Улс 1990 оноос эхлэн нээлттэй эдийн засаг бүхий хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах шилжилтийн үед орсноор тухайн нийгэмд тохирсон Цагдаагийн байгууллагын шинэчлэл явагдаж эхэлсэн. Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотой Цагдаагийн байгууллагын эрх зүйн орчин шинэчлэгдэж, 1990 онд Монголын Цагдаагийн Ерөнхий газар болж, анх удаа төрийн захиргааны төв байгууллагын статустай⁶², цагдаагийн ажилтнууд ямар нэгэн намын харьяалалгүй, ил тод, шударга ёсны, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, хууль дээдлэх зарчмыг үндэс суурь болгон ажиллаж эхэлсэн байна.

1993 онд Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль батлагдаж, байгууллагын нэр, үйл ажиллагааны зарчимд зарим өөрчлөлт орсон боловч нийгмийн эрэлт хэрэгцээ, хүлээлтийг бүрэн хангаагүй бөгөөд улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүйн салбарт гарсан гүнзгий өөрчлөлтүүдтэй хөл нийлүүлэн алхах боломжийг бүрдүүлээгүй.

Тухайн хуулийн дагуу Цагдаагийн ерөнхий газар нь Эрүүгийн цагдаагийн газар, Улсын мөрдөн байцаах газар, Замын цагдаагийн

⁶¹ Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм, Гүйцэтгэх ажлын заавар, Эргүүл постын заавар, Сахилга батын дүрэм, өргөдөл гомдол барагдуулах заавар, гэмт хэрэг илрүүлэх арга, тактикийн тухай заавар.

⁶² 1916 оноос цэргийн яамны харьяа, 1932 оноос Дотоод явдлын яамны харьяа, 1956 оноос Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа байгууллага байсан.

газар, Гал түймэртэй тэмцэх газар⁶³, Аж ахуй санхүүгийн алба, Дотоодын цэргийн штаб⁶⁴, криминалистикийн шинжилгээний төв⁶⁵, иргэний бүртгэл мэдээллийн төв, цагдаагийн дээд сургууль, холбооны анги, цагдан хорих төв гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан. ЦЕГ-ын бүтцэд мөн чиглэлийн хэлтэс, тасаг, алба, Нийслэл, Аймгийн цагдаагийн газар, хэлтсүүд харьяалагдан зохион байгуулагдсан.

Засгийн газрын бүтцэд цагдаагийн байгууллага байсныг Цагдаагийн байгууллагын тухай хуульд оруулсан 1996 оны өөрчлөлтөөр Хууль зүйн яамны харьяа тохируулагч агентлаг болгон өөрчлөн зохион байгуулж, шинэ бүтэц, зохион байгуулалтаар ажиллаж эхэлсэн. Тухайн үед эрүүгийн цагдаа, мөрдөн байцаах газрыг нэгтгэх тухай асуудал эрчимтэй яригдаж байсан.

2002 онд эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийтгэх хууль шинэчлэгдэн батлагдсанаар Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж, гүйцэтгэх ажилтан-хэрэг бүртгэгч нар хэрэг бүртгэх эрхгүй болж, гэмт хэрэгтэй тэмцэхэд эрүүгийн тагнуулын ажлын чанар, үр дүнг дээшлүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж байсан.

Үүний зэрэгцээ Криминалистикийн шинжилгээний төвийг Шүүхийн шинжилгээний үндэсний төв, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн зэргээр нэр томьёог нь өөрчлөн зохион байгуулж бие даасан агентлаг болгож, Хэрэг бүртгэх газрыг шинээр байгуулж, улсын хэмжээний хэрэг бүртгэх нэгжүүдийг нэгтгэх үйл ажиллагаа явагдсан. 2004-2009 онуудад ЦЕГ-ын бүтцэд анх удаа дотоод аюулгүй байдал, хяналт, шалгалтын хэлтэс, хөдөлгөөнт эргүүлийн газар байгуулж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, алба хаагч нарын ажлын ачааллыг тооцох, 100.000 хүн амд 1 цагдаагийн хэлтэс байгуулах, цагдаагийн алба хаагчийн техник, тусгай хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх⁶⁶, иргэд, цагдаагийн харилцааг сайжруулах аян

⁶³ ЦСБ, УАХБ, Улсын прокурор, Цэргийн прокурорт харьяалагдаж байсан мөрдөн байцаах чиг үүрэг бүхий нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулсан, гэмт хэрэг төрөлжүүлэн мөрдөх хэлтсийн бүтэцтэй байсан. Энэ нь тухайн үед Мөрдөн байцаах албыг бие даасан статустай үйл ажиллагаа явуулах бодлоготой байсан ч үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж УАХБ-ын мөрдөн байцаах хэлтсийг эргүүлэн шилжүүлж байсан.

⁶⁴ Дотоодын цэрэг нь Монгол цэргийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд улсын чухал объектууд болон цэргийн албаны бусад зорилтыг биелүүлдэг, дайны хийгээд тайван нөхцөлд цэргийн ар тал, улс орны дотоодод олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал дэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, учирч болох аюулыг үгүй болгох чиг үүргийг хэрэгжүүлэх чухал нэгж гэж тооцон бие даасан хуультай, 2 анги салбартайгаар Цагдаагийн байгуулагад шилжүүлж байсан.

⁶⁵ Тухайн төвийн удирдлагаа алба хаагч нараас анх удаа нууц санал хураалтаар сонгож, томилуулж байсан.

⁶⁶ 600 цагдаагийн алба хаагчийн иж бүрэн тусгай хэргэсэл, тоноглол захиалж, хангалт хийсэн.

зохион байгуулж “амар тайван амьдралын төлөө хамтдаа” уриа гаргаж цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн өгөх үнэлгээг дээшлүүлсэн зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн хүний нөөцийг бэхжүүлэх ажлын хүрээнд БНТУ, ОХУ-ын ДХЯ-ны харьяа их сургууль, академиудад Тусгай сэтгэл зүй, Эдийн засгийн аюулгүй байдал, Тусгай техник, Криминалистик, Олон улсын эрх зүйн чиглэлээр бакалаврын болон докторантурын сургалтад суралцах алба хаагчийн тоог нэмэгдүүлж, мэргэшсэн алба хаагч нараар цагдаагийн байгууллагын боловсон хүчнийг бэхжүүлэх бодлого эрчимжиж байв.

Цагдаагийн ерөнхий газар⁶⁷ нь удирдлагын хувьд Хууль Зүй, дотоод хэргийн яаманд шууд харьяалагдах бөгөөд, Засгийн газрын хуралдаанаар ЦЕГ-ын удирдлагыг томилдог, 1 тэргүүн дэд дарга, дэмжлэг үзүүлэх асуудал эрхэлсэн дэд дарга 1, дотоод хяналт, аюулгүй байдал эрхэлсэн дэд дарга 1, нийт 3 дэд дарга бүхий тухайн албыг Тэргүүн комиссар тэргүүлдэг байна. Бүтцийн хувьд Гэмт хэрэгтэй тэмцэх алба, Нийтийн хэв журам хамгаалах алба, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Дэмжлэг үзүүлэх алба, Дотоод хяналт-аюулгүй байдлын гэсэн үндсэн 5 алба, 34 газар, 89 хэлтэс, 10 төв, 228 тасаг, 83 хэсэг, 10000 гаруй алба хаагч нэгдмэл, төвлөрсөн удирдлагаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт нь Хуулийг дээдлэн, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, иргэдийн амар тайван амьдралын баталгааг хангах мэргэжлийн, чадварлаг, үнэнч шударга, мэргэшсэн алба хаагчдыг үр дүнтэй, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэж байна.

Нийт алба хаагчдын бүтцийг авч үзвэл төрийн тусгай алба хаагч 93%, төрийн захиргааны алба хаагч 3%, Төрийн үйлчилгээний алба хаагч 7%, хүйсийн хувьд эмэгтэй алба хаагч 10%, мэргэжлийн хувьд хуульч, эрх зүйч мэргэжлийн алба хаагч 50%, боловсролын хувьд бакавларын зэрэгтэй алба хаагч 60%, магистрын зэрэгтэй 5,2%, докторын зэрэгтэй 0.04%, бүрэн дунд 30%, бүрэн бус дунд 1% байна. Цагдаагийн нэг алба хаагчид 306 иргэн оногдож, нийт бие бүрэлдэхүүний 70 хувь нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, 30 хувь нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

67 2016 оны 10 сарын байдлаар

Цагдаагийн алба хаагчдын давтан, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй⁶⁸ Сургалт, дадлагын төв 2014 оны 02 дугаар сард байгуулагдсанаас хойш алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр⁶⁹ нийт 343 сэдвээр 1252 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 6500⁷⁰ орчим алба хаагчийг сургалтад хамруулжээ. Үүний зэрэгцээ цагдаагийн алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийн төвшнийг дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна.⁷¹

Өнөөгийн байдлаар цагдаагийн мэргэжлийн алба хаагч, бие бүрэлдэхүүнийг дотооддоо Хууль сахиулахын их сургуульд, гадаадад ОХУ, БНТУ-ын мэргэжлийн их, дээд сургууль, академиудад захиалгаар бэлтгэдэг.

Хууль сахиулахын их сургуулийн цагдаагийн алба хаагч нарыг бэлтгэдэг бүрэлдэхүүн сургууль болох Цагдаагийн сургууль нь Цагдаагийн эрх зүйн тэнхим, Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим, Мөрдөх ажиллагаа онол тактикийн тэнхим, Шинжлэн магадлах ухааны тэнхим, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тэнхим, Мэдээллийн технологийн тэнхимийн бүтэцтэйгээр цагдаагийн алба хаагчдыг бэлтгэдэг байна.

Цагдаагийн алба хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг⁷² дараах тогтолцоогоор явуулж байна.
Үүнд:

- Цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалт /1 сараас 1 жил хүртэл/;

⁶⁸ Цагдаагийн байгууллагын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд онцгойлон анхаарч цагдаагийн алба хаагчийн сургалттай холбогдох асуудлыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж, даган мөрдөж буй Цагдаагийн албаны тухай хуульд тусгайлан зааж зохицуулсан. Цагдаагийн албаны тухай хуулийн Цагдаагийн албаны сургалтын байгууллага гэсэн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хууль сахиулагчийг бэлтгэх сургуулийн бүрэлдэхүүнд цагдаагийн алба хаагч, ажилтныг бэлтгэх үүрэг бүхий сургалтын байгууллага байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан сургах, албаны сургалт явуулах сургалтын төвийг хот, орон нутагт бүсчлэн байгуулж болно” гэж тус тус заасан нь цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан, мэргэшүүлэх сургалтын байгууллагын тогтолцоог төдийгүй сургалтын зорилго, төрөл, хэлбэрийг тогтоосон байна

⁶⁹ Мэргэшүүлэх болон давтан сургалт, Цагдаагийн газар, хэлтэст явуулах албаны сургалт, Гадаад сургалт, Зайны сургалт гэсэн чиглэлээр явагдаж байна

⁷⁰ <https://www.police.gov.mn/news/list/type/79/menuid/26>

⁷¹ Хууль сахиулахын их сургуулиас хууль сахиулах салбарын алба хаагчдыг гадаад хэлтэй болгоход чиглэсэн TRIO 2015-2020 хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна.

⁷² Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан, мэргэшүүлэх сургалт нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон одоо даган мөрдөж байгаа Цагдаагийн байгууллагын сургалтын бодлого хэрэгжүүлэх (код 117), Ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх (код 243), Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх (код 942), Гадаадад суралцагчийг сонгон шалгаруулах, богино хугацааны сургалтад оролцуулах (код 944) журмууд мөн холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулагдаж байна.

- Цагдаа-хууль сахиулах ажил бакалаврын зэрэг олгох сургалт /4-5 жил өдөр эчнээ хэлбэрээр/;
- Цагдаагийн удирдлага-стратегии тактик мэргэжлийн магистр /2 жил/;
- Цагдаа судлал судалгааны магистр /2 жил/;
- Цагдаа судлал докторын сургалт /3-5 жил/.

Цагдаагийн ерөнхий газар болон хууль сахиулах чиг үүрэг бүхий бусад байгууллагын хамтын ажиллагаа.

Цагдаагийн байгууллага бусад хууль сахиулах чиг үүрэг бүхий дараах байгууллагуудтай харилцан ажиллагаатай ажиллаж байна. Үүнд:

- Шүүхийн байгууллага ⁷³;
- Прокурорын байгууллага ⁷⁴;
- Авлигатай тэмцэх газар ⁷⁵;
- Тагнуулын ерөнхий газар ⁷⁶;
- Хил хамгаалах ерөнхий газар ⁷⁷;

⁷³ Ершөөл үзүүлэх, Шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тоо бүртгэлийг хөтлөх, лавлагаа олгох, Ялтай эсэх лавлагааны тодорхойлолтын загвар”, “Ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудасны загвар”, “Хууль тогтоомжийн хүрээнд ялтай эсэх лавлагааг тодорхойлолтоор авах эрх бүхий байгууллагын жагсаалт”, “Ял шийтгэлийн тэмдэглэлийн загвар” / гэх мэт;

⁷⁴ Улсын Ерөнхий прокурорын 2015 оны А/88 дугаар тушаалаар баталсан “Прокурорын хяналтын ажилд болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд эрүүгийн байцаан шийтгэх хуулийг дагаж мөрдөх ажлын аргачилсан заавар”, МУЕП-ын 2015 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын заавар”, МУЕП-ын 2015 оны А/91 дүгээр тушаалаар баталсан “Прокурор хилийн хориг тавих, цуцлах журам”, МУЕП, ЦЕГ-ын дарга нарын хамтарсан 2014 оны А/27/312 дугаар тушаалаар баталсан “Прокурор, Цагдаагийн байгууллагын хооронд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу өршөөгдсөн хүний талаарх мэдээлэл солилцох журам” гэх мэт;

⁷⁵ Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх газартай 2015 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны Санамж бичиг”, АТГ, ТЕГ, ЦЕГ, ИХШХЕГ-ын дарга нарын хамтарсан 2015 оны А/71/А/60/А/51/А/227 дугаар тушаалаар баталсан “Хилийн хориг цуцлах журам” гэх мэт;

⁷⁶ Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлт бодисын эргэлтэд хяналт тавих хууль, Онц байдлын тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Монгол Улсын төрийн ордны тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2000 оны 272/326/344 дүгээр тушаалаар баталсан “Нэг бүрийн тусгай хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн маягт батлах тухай”, ЦЕГ, ИНЕГ, ГЕГ, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга нарын хамтарсан 2014 оны 203/А/135/А/57/04/358 дугаарын тушаалаар баталсан “Албаны үнэрч нохойг хамтран ашиглах журам” гэх мэт;

⁷⁷ Монгол Улсын Хилийн тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлт бодисын эргэлтэд хяналт

- Шүүхийн шийдвэрийн ерөнхий газар ⁷⁸;
- Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар ⁷⁹;
- Улсын бүртгэлийн ерөнхий газар ⁸⁰;
- Тахарын ерөнхий газар ⁸¹;

Эрх зүйн шинэчлэл

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа эрх зүйн баримт бичгийг хууль тогтоомж, өнөөгийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянаж, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр гаргах шаардлагатай эрх зүйн баримт бичгийг боловсруулж батлуулах зорилгоор дотоод журамд кодификаци хийсэн⁸².

- “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийг 1993 оноос мөрдөж эхэлснээс хойш 20 жилийн дараа эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурлаар 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулсан.

Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэн батлуулсантай холбоотойгоор Засгийн газрын 9 тогтоолоор 11 журам, хөтөлбөр, жагсаалт, Хууль зүйн сайдын 12 тушаалаар 15 дүрэм, журам, заавар, ЦЕГ-ын даргын 11 тушаалаар 18 дүрэм, журам, заавар зэрэг эрх зүйн актыг батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн.

тавих хууль, Онц байдлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, ХХЕГ, ЦЕГ-ын дарга нарын хамтарсан 2015 оны 02/28 дугаар “Хамтран ажиллах төлөвлөгөө” гэх мэт;

⁷⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, МУЕП-ын 2015 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын заавар”, МУЕП-ын 2015 оны А/91 дүгээр тушаалаар баталсан “Прокурор хилийн хориг тавих, цуцлах журам” гэх мэт;

⁷⁹ Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль, Онц байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль;

⁸⁰ Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль;

⁸¹ Тахарын албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль.

⁸² Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн ажил, хөдөлмөрийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийн жагсаалт, эрх зүйн үндэслэл, эрх зүйн баримт бичгийн бүртгэлийн дугаар /код/-ыг буюу ЦЕГ-ын даргын 2010 оны 172 тушаалаар “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын жагсаалтыг анх удаа баталж, түүний дагуу 9 бүлэг, 193 журмыг кодлон үе шаттайгаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн. Түүнчлэн, ЦЕГ-ын даргын 2014 оны 856 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын жагсаалтыг шинэчлэн баталж, түүний дагуу 9 бүлэг, 256 журмыг батлуулаад мөрдөн ажиллаж байна.

Шинэчлэлийн үзэл баримтлал

1992 онд Монгол Улсын Үндсэн хууль баталснаар хууль тогтоомжийг түүнд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажил эхэлсэн бөгөөд “Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах тухай” Улсын Бага Хурлын 1992 оны 14 дүгээр тогтоолын дагуу төрийн байгууллагын шинэтгэлийг хийх ажлын хүрээнд 1993 оны 12 дугаар сарын 2-ны өдөр “Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийг батлан гаргасан билээ.

1998 онд Улсын Их Хурал эрх зүйн бодлогын цаашдын чиг хандлагыг тодорхойлсон “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд уг хөтөлбөрт “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын үр дүнг сайжруулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагыг шинэчлэн зохион байгуулах чиглэлээр цагдаагийн байгууллагын зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, боловсон хүчний хангалтыг сайжруулах, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авна” гэж заажээ.

“Цагдаагийн байгууллагын тухай хууль” хүчин төгөлдөр мөрдөгдөж, “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр” амжилттай хэрэгжиж эхэлснээр тус байгууллага бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, зэвсэглэмжийн хувьд бэхжиж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах чадавх нь мэдэгдэхүйц дээшлэв.

Гэвч цагдаагийн байгууллагын тогтолцоонд шинэтгэлийг цаашид гүнзгийрүүлэх зайлшгүй шаардлага байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн байдал, гэмт хэргийн гаралт, илрүүлэлтийн динамик болон бусад үзүүлэлтүүдээс тод харагдсаар байгаа билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ивээл дор 2011 оны 4 дүгээр сард зохион байгуулсан “Шүүх эрх мэдлийн байгууллагын шинэчлэл” чуулга уулзалтын явцад Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх зайлшгүй шаардлага байгааг онцлон тэмдэглэсэн билээ.

Монголын цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг цогц байдлаар, далайцтай хийх нь цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх үндсэн нөхцөл болно хэмээн гадаадын зарим улсын тэргүүлэх экспертүүд⁸³ үзэж буй бөгөөд олон улсын илүү өргөн цар хүрээтэй, урт хугацааны хамтын ажиллагаанд

⁸³ Ирвин Бейкин. Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ба чадавхийн үнэлгээ. УБ., 2007. Стив Корич. Монголын цагдаагийн байгууллагын чадавхи, үйл ажиллагааны үнэлгээний тайлан. УБ., 2009.

тулгуурласан шинэтгэл (реформ) хийх замаар л цагдаагийн ажлыг мэргэжлийн төвшинд хүргэж, ард иргэдийн итгэлийг эргэн олж авах ба зөвлөлт маягийн цагдаагийн арга барилаас барууны хэв маяг руу ийнхүү шилжихэд Монгол Улсын Засгийн газар, Цагдаагийн ерөнхий газар болон олон улсын байгууллагуудын байнгын анхаарал, идэвхтэй оролцоо шаардагдана хэмээн зөвлөж байгаа нь цагдаагийн шинэтгэлийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх хам нөхцөл болсон.

“Монгол Улсын цагдаагийн байгууллагын шинэтгэлийн бодлого” нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Цагдаагийн номлолд нийцүүлэн цагдаагийн байгууллагыг дэлхий нийтийн чиг хандлага, шинжлэх ухаан, технологийн хөгжил дэвшилд ойртуулан жинхэнэ утгаар нь орчин үеийн мэргэжлийн байгууллага болгон цогц байдлаар өөрчлөн зохион байгуулахад чиглэгдсэн стратегийн төвшний бодлогын тулгуур баримт бичиг мөн бөгөөд зорилго нь цагдаагийн байгууллагын шинэтгэлийн үзэл баримтлал, стратегийг тодорхойлох, үүний үндсэн дээр бүтэц, зохион байгуулалтыг нь өөрчлөх, хүний нөөцийг нь сургаж дадлагажуулах, технологийн шинэчлэл хийх, эрх зүйн орчныг нь сайжруулах, байгууллагын соёл, үнэт зүйлийг нь төлөвшүүлэх, улмаар үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, чадавхыг нь сайжруулах, үр ашгийг нь дээшлүүлэх замаар цагдаагийн үйлчилгээг хууль ёст, чанартай, ил тод, хүртээмжтэй, шуурхай болгоход оршино.

Цагдаагийн байгууллагын шинэчлэл

Шинэтгэлийн бодлогын стратегийг Монгол Улсын цагдаа, дотоодын цэргийн бүх алба, салбар, нэгжид хамааралтай байхаар тооцсон бөгөөд үйл ажиллагааг нь шүүх эрх мэдлийн болон нутгийн удирдлагын байгууллагуудтай нягт уялдуулан, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлт, чиг хандлагад нийцүүлэн цогц байдлаар хэрэгжүүлэхэд чиглүүлсэн байна.

Цагдаагийн шинэтгэлийн бодлогыг дараах үндсэн чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Цагдаагийн эрх зүйн орчны шинэтгэл. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хуулийн хүрээнд чиглэсэн зорилготой, давхардал, хийдэлгүй явуулах, цагдаагийн ажилтны эрх зүй, нийгмийн баталгааг найдвартай хангах эрх зүйн орчныг үлэмж сайжруулна.
- Цагдаагийн бүтцийн шинэтгэл. Гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах, нийгмийн

аюулгүй байдлыг хангах чиг үүргийг үр дүнтэй гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цагдаагийн нөөцийг оновчтой ашиглан, чадавхыг бүрэн дайчлах боломжийг бүрдүүлэхэд чиглүүлж, олон улсын цагдаагийн тэргүүний жишигт нийцүүлэн, байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон шинэчилнэ.

- Цагдаагийн үйл ажиллагааны шинэтгэл. Цагдаагийн мэргэжлийн үйлчилгээг ард иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэхийн тулд гэмт хэрэг, зөрчлийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажилд түлхүү анхаарах, гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах, нийгмийн аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник, технологийг өргөнөөр нэвтрүүлэх, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг бодитойгоор идэвхжүүлэн, шинэ шатанд гаргана.

- Цагдаагийн хүний нөөцийн шинэтгэл. Хуулиар хүлээсэн үүргээ мэргэжлийн төвшинд, чанартай биелүүлэх чадамжтай, өндөр боловсрол, соёл, ёс суртахуунтай, бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй алба хаагчдаар цагдаагийн бие бүрэлдэхүүнийг бэхжүүлэх, тэднийг сургаж дадлагажуулах, манлайлах чадвар бүхий цагдаагийн дээд, дунд, доод шатны удирдах ажилтныг бэлтгэх тогтолцоог шинээр бий болгоно.

- Цагдаагийн техник, технологийн шинэтгэл. Цагдаагийн албадын үйл ажиллагаанд шинжлэх ухааны агууламж бүхий дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, өргөн ашиглах замаар мэдээллийн хангамжийг сайжруулан, гэмт хэрэг, зөрчлийг урьдчилан сэргийлэх, халуун мөрөөр нь илрүүлэх, нотлох ажиллагааг мэргэжлийн төвшинд хүргэн эрчимжүүлнэ.

- Цагдаагийн инновацийн шинэтгэл. Цагдаагийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг цагдаагийн байгууллагын гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах, нийгмийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд байнга, тасралтгүй, эрчимтэй нэвтрүүлэх зорилгоор “цагдаагийн шинжлэх ухаан – цагдаагийн боловсрол – цагдаагийн үйлчилгээ” сүлжээг бий болгон хөгжүүлнэ.

- Цагдаагийн соёл, үнэт зүйлийн шинэтгэл. Цагдаагийн хамт олны дотоод уур амьсгалыг эрүүлжүүлэх, алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээх, сахилга батжуулах, хувийн зохион байгуулалтыг дээшлүүлэх, гадаад үзэмжийг сайжруулах замаар цагдаагийн үйлчилгээг нийцтэй болгох, улмаар ард иргэдийн итгэлийг эргүүлэн олж авахад байгууллагын дотоод соёл, үнэт зүйл чухал хүчин зүйл мөн хэмээн үзэж, тэдгээрийг бий болгон төлөвшүүлэх зэрэг болно.

Цагдаагийн байгууллагын шинэчлэлийн тойм⁸⁴.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2012 оны 4 дүгээр сард Цагдаагийн алба, алба хаагчийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Шинэчлэлийн Засгийн газраас хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд боловсруулсан зарим хуулийн төслийг өргөн барьсныг Улсын Их Хурал хэлэлцэж 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуулийг батлан, 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтсон.

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах гэж байсныг шинэ хуулиар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэж өргөжүүлсэн.

Цагдаа гэдэг нь төрөөс хариуцуулсан хууль, нутаг дэвсгэрт хуулийг сахиулах, нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, энэ зорилгоор хүч хэрэглэх эрх хуулиар олгогдсон төрийн төлөөлөгч гэсэн ерөнхий ойлголт байдаг. Үүнийг “constabulary, gendarmerie, police force, police department, police service, law enforcement agency” гэх зэргээр янз бүрээр нэрлэж ажилтнуудыг нь “police officers, troops, sheriffs, constables, rangers, peace officers” гэх зэргээр нэрлэдэг.

Үүнээс “Police service” гэдгийг сүүлийн үед манайд хэрэглэж байгаа, ‘service’ гэдэг үг нь элдэв янзын үйлчилгээний утга агуулах боловч үндсэн утга нь засгийн газраас олон нийтийн төлөө бий болгосон тогтолцоог хэлдэг. Гадаад орнуудын цагдааг ихэвчлэн “Police service” гэх зэргээр нэрлэж байгааг хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах алба гэж ойлгох нь зөв болов уу. Энэ утгаараа Цагдаагийн албаны тухай хууль болж өөрчлөгдөв.

Энэ хуульд урьд байсан зарим процессын шинжтэй хэм хэмжээнүүд тусгагдаагүй. Учир нь энэ хуулиар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны тогтолцоог тодорхойлж байгаа тул одоогийн хуульд байгаа Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх үндэслэл, журам, хойшлуулшгүй ажиллагаа явуулах зэрэг цагдаагийн үйл ажиллагааны талаар Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөлд тусгагдахаар болсон.

Олон нийтийн дэмжлэг, хүндлэлийг олж олон нийтийн санаа бодол, тэдний дэмжлэгт тулгуурласнаар цагдаа амжилттай ажилладаг талаар судлаачид дүгнэсэн байна.

⁸⁴ Эх сурвалжийг ЦЕГ-аас авсан.

1705 оноос баруун Европт Police science буюу цагдаа судлалын ухааныг үүсгэн орчин үеийн цагдаагийн ойлголтын талаар судалж хөгжүүлж ирэхдээ цагдаагийн албаны хөгжилд хамгийн чухал хоёр зүйл бол нэгдүгээрт иргэний хяналт⁸⁵, хоёрдугаарт улс төрөөс⁸⁶ ангид байх явдал гэж үзсэн байдаг. Цагдаагийн албаны үйл ажиллагаанд иргэдээс үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдийн өмнө хариуцлага хүлээдэг болгохын тулд иргэний хяналт гэсэн тогтолцоо бий болсон.

Цагдаагийн албаны тухай хуульд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх, сургалт, үйл ажиллагаандаа орчин үеийн технологи нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлтэй байхаар тусгасан. Энэ нь тус хуульд заасан “хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, олон нийтийн итгэлийг хүлээж, иргэний дэмжлэгийг авах” үйл ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх чухал механизм юм.

Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн албаны үйл ажиллагааны зарчмыг “иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах” гэж тодорхойлсон. Үүний дагуу Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа гэсэн бүлэг нэмж тусгасан. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах үүрэг бүхий олон нийтийн цагдаагийн ажилтныг гэрээ байгуулан ажиллуулах, түүнд олгох урамшил, холбооны болон тусгай хэрэгслээр хангах, сургах зардлыг хариуцна. Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн тухайн жилдээ ажиллуулах Олон нийтийн цагдаагийн ажилтны тоог тогтоохоор хуульчилсан байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын удирдлагын үндсэн зарчмыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан улс үндэсний нэгдмэл хөгжлийн зорилгод нийцүүлэн, дэлхийн улс орнуудын цагдаагийн хөгжлийн чиг хандлагыг баримтлан нэгдмэл төвлөрсөн байхаар заасан болно.

⁸⁵ democratic control

⁸⁶ political neutrality

Хууль эрх зүй

Цагдаагийн албаны тухай хууль нь цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон.

Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа, удирдлагын үндсэн зарчим, тогтолцоо, нутаг дэвсгэрийн болон хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, цагдаагийн албаны туг, бэлгэ тэмдэг, цагдаагийн тангараг, цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг, цагдаагийн байгууллагын захиргааны үүргийг судалгаа, шинжилгээний үндэстэй томьёолон тодорхойлсон.

Цагдаагийн төв байгууллага, нутаг дэвсгэрийн болон хотын цагдаагийн газрын үүрэг, цагдаагийн албаны сургалтын байгууллага, судалгааны төв, цагдаагийн байгууллагын байршил, цагдаагийн байгууллагын удирдлага, Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагыг удирдах, цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх, иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих бусад хяналт, олон нийтийн цагдаагийн ажилтан, иргэд аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах, байгууллага, иргэдийн үүрэг, тусламцаа зэрэг нийгмийн өмнө тулгарсан цагдаагийн үйл ажиллагаа, чадавхтай холбогдсон олон төрлийн харилцааг зохицуулна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, алба хаагчийн агсамж, үйл ажиллагаандаа тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж ашиглах, цагдаагийн байгууллагын санхүүжилт, алба хаагчийн эрх, үүрэг, алба хаагч, ажилтны баталгаа, цагдаагийн алба хаагчид олгох нөхөн олговор, тусламж, бусад баталгаа зэрэг нарийвчилсан зохицуулалтыг шинэлэг байдлаар оруулсан байна.

Цагдаагийн байгууллагын олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа, олон нийтийн цагдаагийн ажилтны эрх үүрэг, цагдаагийн байгууллагын ухаалаг буюу иргэнд ойрхон бүтэц зэрэг асуудлуудыг шийдвэрлэнэ.

Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөнтэй холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох бусад хуулиудыг боловсруулан батлуулж, түр хугацаанд зарим харилцааг зохицуулах зайлшгүй шаардлага бий болсон юм. Үүнд:

-Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааны хугацаа нь нэг дор дуусгавар болохоор байгаа тул хуульд заасан хугацаа дуусахад 60 орчим хувь нь солигдохгүй үлдэж, улмаар тус бодлого, байр суурь нь тогтвортой үргэлжлэхээр зохицуулах;

-Цагдаагийн алба хаагчдын эрх зүйн байдлыг дордуулахгүй, албандаа хандах үнэлэмжийг бууруулахгүй, сэтгэл зүйд нь нөлөөлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийн дагуу 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн урьд хэрэглэж байсан цолыг хэвээр үлдээж ёслолын хувцсан дээр зүүж хэрэглэхээр;

-Захиргааны журмаар баривчлах шийтгэл биелүүлэх чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад, мөн Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг эмнэлгийн байгууллагад шилжүүлэхээр болсонтой холбоотойгоор урьд нь тухайн чиг үүргийг гүйцэтгэж байсан алба хаагчдын ажилласан хугацааг тооцох, дээрх чиг үүргийг үе шаттайгаар тухайн байгууллагад шилжүүлэх;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, мөрдөх хүртэл дээрх хорих байгууллагаас суллагдсан хүнд хяналт тавих чиг үүргийг цагдаагийн байгууллага хэвээр гүйцэтгэж, “Тахарын албаны тухай хууль” хэрэгжиж шүүхийн хуягийн алба байгуулагдах хүртэл хугацаанд шүүхийн хамгаалалтыг цагдаагийн байгууллагаас үргэлжлүүлэн гүйцэтгэх зохицуулалт хийх,

-Хууль сахиулах үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж батлагдах хүртэл хугацаанд цагдаагийн алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэхдээ биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх асуудлыг зохицуулсан журам баталж хэрэгжүүлэх;

-Цагдаагийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө цагдаагийн болон дотоодын цэргийн байгууллагад ажиллаж байсан алба хаагч, ажилтны цалин хөлс, хангамжийн нөхцөлийг дордуулахгүй байх арга хэмжээг Засгийн газар авах зэрэг харилцааг тус тус зохицуулахаар тусгажээ.

Цагдаагийн байгууллагын бүтцэд Иргэний зөвлөлийг ажиллуулж эхэлснээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд тодорхой ахиц дэвшил гарч, хүний эрх, эрх чөлөө хамгаалагдах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлын чанар, хамтын ажиллагаа сайжрах, нутаг дэвсгэрийн

цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих эрх зүйн орчин бүрдэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод, олон нийтэд нээлттэй болох; цагдаагийн байгууллагад өгөх иргэдийн үнэлгээ өсөж, тэднийг үл хүндэтгэсэн хандлага багасах; цагдаагийн албан хаагчийн ёс зүй дээшлэх, салбар дахь авлига буурах ач холбогдолтой юм.

Дүгнэлт

Монгол Улсын цагдаагийн байгууллага, түүний үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг өнгөрсөн зууны 11 оноос хойш өнөөдрийг⁸⁷ хүртэл 10 жилийн давтамжтайгаар эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, хүний нөөц, технологийн хүрээнд шинэчлэх үйл явц хэрэгжиж, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа байнга шинэчлэгдэж байх нөхцөлийг хангаж иржээ.

Гэвч түүхэн үеүдэд хийгдсэн шинэтгэлийн зарим үйл явцад дутагдалтай талууд байсан нь цөөнгүй ажиглагдаж байв. Тухайлбал, 2012 оноос хойш явагдсан шинэтгэлийн үйл ажиллагаанд судалгаанд суурилсан үйл ажиллагаа дутагдаж, байгууллагын бие бүрэлдэхүүнийг судлалгүйгээр огцом өөрчилсөн нь бусад ач холбогдолтой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх болсон. Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнд өөрчлөлтийг хүлээж авах, өөрчлөлтийг эсэргүүцэх, өөрчлөлтөд эргэлзэх байдал зэрэгээр нь урьдчилан судалгаа хийж, тухайн судалгаанд үндэслэн хүний нөөцийн менежментийг явуулсан бол илүү үр дүнд хүрэх байсан болов уу. Цагдаагийн байгууллагад эрсдлийн болон зөрчлийн менежментийг явуулсан боловч өөрчлөлтийн болон хөгжлийн менежментийн дутагдалтай тал ажиглагдаж байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь мэргэжлийн үйлчилгээ мөн бөгөөд ил тод, тунгалаг, шударга, тэгш, хараат бус, хэний ч нөлөөнд автахгүй байж, гагцхүү хууль ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангахад чиглэгдэхийн зэрэгцээ Цагдаагийн албаны бүх шатанд эрх мэдэл, хариуцлагын механизм тодорхой, алба хаагч нь зэвсэг хэрэглэхээс аль болох зайлсхийх бодлого баримтлах шаардлага тулгарч байна.

Хүний нөөцийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, хүний хөгжил, төлөвшлийн орчныг бүрдүүлж, тасралтгүй суралцагч байгууллага байхад үйл ажиллагааг нь чиглүүлэхэд мэргэшсэн удирдах

⁸⁷ Тухайлбал, 1911-1992 онд цагдаагийн дүрэм, журамд 17 удаа, бүтцийг 29 удаа, хүний нөөцийн талаар 14 удаа, сургалт, сургуулийг 8 удаа, техник тоног төхөөрөмжийн талаар 10 орчим удаагийн дорвитой шинэтгэл хийгдэж байжээ.

ажилтны оролцоог нэмэгдүүлэх, цагдаагийн байгууллагад үүрэг болгосон гэмт хэрэг, зөрчлийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажилд түлхүү анхаарах, гэмт халдлагаас хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник, технологийг өргөнөөр нэвтрүүлэх, мэдээллийн хангамжийг сайжруулах, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг бодитойгоор идэвхжүүлэн, шинэ шатанд гаргах нь орчин үеийн цагдаагийн мэргэжлийн байгууллага болгон хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зарчим, арга замыг тодорхойлсон тулгуур баримт бичиг болох “Монгол Улсын Цагдаагийн номлол”⁸⁸- ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс батлан гаргаж, үндсэн чиглэл, зарчим, үнэт зүйлсийг зөв томъёолох, тухайлбал Цагдаагийн байгууллагын үнэт зүйлийг эрхэмлэн дээдлэх⁸⁹, бишрэн шүтэх⁹⁰, бахархан дуурайх үнэт зүйл⁹¹ хэмээн ангилан тодорхойлох нь Цагдаагийн байгууллагын дотоод соёл, үнэт зүйлийг бий болгон төлөвшүүлэхэд онцгой ач холбогдолтой.

⁸⁸ Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын цагдаагийн хууль тогтоомж, иргэн, нийгмийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болно.

⁸⁹ Цагдаагийн ажилтны тангараг, тусгай цол, дүрэмт хувцас, үнэмлэх, энгэрийн тэмдэг нь цагдаагийн алба хаагчийн ямагт эрхэмлэн дээдлэх үнэт зүйл болно.

⁹⁰ Монгол эх орон, ард түмэн, цагдаагийн албаны нэр хүнд нь цагдаагийн алба хаагчийн ямагт бишрэн шүтэх үнэт зүйл болно.

⁹¹ Цагдаагийн түүхэн уламжлал, хуримтлуулсан туршлага, ахмад ажилтны сургааль, зөвлөгөө нь цагдаагийн алба хаагчийн ямагт бахархан дуурайх үнэт зүйл болно.


ХИЛЧДИЙН ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ



ДЭЭД ОФИЦЕРЫН МӨРДЭС



ЁСЛОЛЫН МӨРДЭС



ОФИЦЕР, АХЛАГЧИЙН МӨРДЭС



БҮСИЙН ЯЛГАХ ТЭМДЭГ



ЧИМЭГ, ХЭРЭГЛЭЛ



Z.BOLDBAATAR



MONGOLIA
D.SUKHBAATAR
B (II)

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙН ДҮРЭМТ ХУВЦАС



Ёслолын



Өдөр тутмын



Хээрийн

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦОЛ



1. Тэргүүн комиссар
2. Тэргүүн дэд комиссар
3. Дэд комиссар
4. Туслах комиссар
5. Хурандаа
6. Дэд хурандаа
7. Хошууч
8. Ахмад
9. Ахлах дэслэгч
10. Дэслэгч
11. Ахлах ахлагч
12. Ахлагч
13. Дэд ахлагч

Цагдаагийн сонсогчийн цол

14. Ахлах түрүүч
15. Дэд түрүүч
16. Түрүүч
17. Сонсогч

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ



Нэг бүрийн хамгаалах хэрэгслүүд



Машины радио станцууд

Гар радио станцууд



Хууль зүйн ухааны (ph) доктор
Урианхан Б.Пүрэв

МОНГОЛ УЛСЫН ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ

Түүхэн хөгжил

Социализмын үед буюу 1990 он хүртэл Монгол улсад хувийн хамгаалалт хариуцсан хувийн өмчит аж ахуйн нэгж, хуулийн этгээд байсангүй. Харин харуул хамгаалалт дагнан эрхэлдэг нэгжүүд байсан юм. Жишээлбэл, Ноосны үйлдвэрүүдийн нэгдэл, Арьс, ширний үйлдвэрүүдийн нэгдэл, Оёдлын үйлдвэрүүдийн нэгдэл зэрэг томоохон нэгдлүүд харьяа үйлдвэрүүдийнхээ хамгаалалтыг хариуцсан харуул хамгаалалтын албатай байлаа. Тэд бүгд төрийн өмчит аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүн хэсэг байсан бөгөөд томоохон нь 200 гаруй ажиллагсадтай байжээ. Чухал гэж үзсэн улсын өмчит аж ахуйн нэгжүүдийг тэднээс санхүүждэг гэрээт цагдаа нар хамгаалдаг байлаа.

Засгийн газрын дэргэдэх Цагдаагийн ерөнхий газраас Засгийн газарт оруулсан бичигт нийт цагдаа нарын 71 хувь нь харуул манааны үүрэг гүйцэтгэж байгааг дурдаад, тэднийг харуул манааны ажлаас чөлөөлж хэв журам зохицуулах ажилд шилжүүлэх арга хэмжээ авах санал тавьсныг Засгийн газар 1990 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дэмжиж 14 дүгээр протокол гаргажээ. Тэр протоколын дагуу цагдаагийн хамгаалалтад байсан зарим байгууллага, аж ахуйн нэгжийг хамгаалалтнаас гаргаж, заримыг нь дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлсэн боловч олон газар цагдаагийн хамгаалалтад хэвээр үлджээ. Тийнхүү үлдсэн дотроос нилээд объектыг ялгаж Улаанбаатар хотын цагдаагийн газрын харьяанд харуулын тасаг байгуулж, уг тасагт цагдаагийн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан хөдөлмөрийн чадвар сайтай хүмүүсийг голлон ажиллуулахаар ЦЕГ-ын даргын 1990 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 919 дүгээр тушаал гарчээ. Мөн өдөр ЦЕГ-ын даргын 920 дугаар тушаалаар цагдаагийн дохиоллын хамгаалалтын алба байгуулж, хүссэн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг хамгаалалтад авч аж ахуйн тооцоон дээр ажиллуулах болжээ. Дохиоллын хамгаалалтын албанд бүхэлдээ цагдаагийн алба хаагч нар ажилладаг байв.

Цагдаагийн хамгаалалтад үлдсэн олон объектыг цаашид цагдаа хамгаалах шаардлагагүй гэж үзэн гэрээг цуцалж, тэднийг өөрсдийнх нь хүсэлтээр хамгаалж байх “Дэлгэрэх” нэгдлийг Улаанбаатар хотын цагдаагийн газрын дэргэд байгуулж аж ахуйн тооцоон дээр ажиллуулах тухай 17 дугаар тушаалыг ЦЕГ-ын дарга 1993 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр гаргажээ. Энэ бол цэрэг, цагдаагийн алба хаагчгүй, энгийн гэрээт хамгаалалтын аж ахуйн нэгж бөгөөд харин төрийн өмчит байсан юм. Үүнтэй холбогдуулан Улаанбаатар хотын цагдаагийн газрын гэрээт харуулын тасгийг 1993 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 172 дугаар тушаалаар татан буулгасан байна. Засгийн газар 1993 оны 5 дугаар сарын 14-ний өдөр “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектын жагсаалт батлах тухай” 82 дугаар тогтоол гаргаж, ингэснээр цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад зөвхөн улсын онц чухал объектууд үлдэж, бусад нь энгийн харуул хамгаалалтад шилжжээ.

Цагдаагийн байгууллагад ажиллаж байгаад чөлөөлөгдсөн зарим хүн нэгдэж 1998 онд Улаанбаатар хотод “Цагаан бар” нэртэй харуул хамгаалалтын компани байгуулсан нь Монгол улсын хувийн хамгаалалтын анхны аж ахуйн нэгж (хуулийн этгээд) байлаа. Энэ компани нь төрийн зарим байгууллага (Жишээ нь, Татварын ерөнхий газар) төрийн ба хувийн өмчит аж ахуйн нэгж, айл өрхийг дохиоллоор болон харуулчин хүнээр хамгаалж эхэлсэн юм. 1999 онд уг компани задарч “Цагаан бар”, “Бамбай” (Security service), “Улаанбаатар секурити” гэсэн гурван компани болжээ. Тэр үед харуул хамгаалалтын тухай хууль гараагүй байсан тул хувийн хамгаалалтын компаниуд аж ахуйн нэгжийн буюу Компанийн тухай хуулийг баримтлан ажиллаж байв.

Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль тогтоомж

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр Монгол улсын Их хурлаар баталсан “Гэрээт харуул хамгаалалтын тухай” хууль нь гэрээт харуул хамгаалалт эрхлэх хувийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулсан гол баримт бичиг болж байна.

Хуулийн 7 дугаар зүйлд зааснаар гэрээт харуул хамгаалалт эрхлэх аж ахуйн нэгж нь төрийн эрх бүхий байгууллагаас гэрээт харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрөл (лиценз)-ийг урьдчилан авах ёстой байлаа. Төрийн байгууллагаас олгодог зөвшөөрөл (лиценз)-ийг цөөлөх зорилгоор 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр УИХ хууль гаргаж, урьдчилан зөвшөөрөл авахыг өөрчилж, аймаг, нийслэлийн цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ гэж тогтоон, зөвшөөрөлтэй холбоотой заалтуудын заримыг хүчингүй

болгож, заримыг “бүртгүүлэх” болгон өөрчилсөн юм. Хуульд үүнээс өөр өөрчлөлт, нэмэлт ороогүй одоо мөрдөж байна.

Хуулийн 3 дугаар зүйлд “харуул хамгаалалт” гэж “харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгчийн эд хөрөнгө, объектыг хамгаалах үйл ажиллагааг”; “харуул хамгаалалтын байгууллага” гэж энэ хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлж, харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг” тус тус хэлнэ гэж зааснаас үзвэл гэрээт харуул хамгаалалтыг зөвхөн хуулийн этгээд эрхлэх ба хувь хүн ганцаараа эрхлэхийг зөвшөөрөөгүй, ер нь тийм бодит боломж ч үгүй юм. Харин хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар хувь хүн энгийн жижүүр, манаачийн үүрэг гүйцэтгэж болох ба тэр харилцаа хөдөлмөрийн гэрээгээр зохицуулагдана. Мөн зүйлд төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй гэсэн нь тайлбарлалтгүй ойлгомжтой юм.

Хуулийн 7 дугаар зүйлд заахдаа, харуул хамгаалалт эрхлэх байгууллага нь бүртгүүлэхийг хүссэн өрөгдөл, холбогдох материал, алба хаагч тус бүрийн тодорхойлолт, эрүүл мэндийн магадлагааг аймаг, хотын цагдаагийн байгууллагад ирүүлнэ. Цагдаагийн байгууллага хянаад 30 хоногийн дотор бүртгэх, эсэхийг шийдэж хариуг бичгээр мэдэгдэнэ. Энэ зүйлийн “холбогдох материал” гэдэгт энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байгааг нотлох баримтууд бүрдүүлэхийг хэлж байгаа юм. Тухайлбал :

- эрх, үүргээ хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчинтэй,
- зэвсэг техник, тусгай хэрэгсэлтэй,
- хууль тогтоомжийн лавлагаатай,
- өөрийгөө санхүүжүүлэх чадвартай.

Харуул хамгаалалтын алба хаагч гэж харуул хамгаалалтын байгууллагад харуул хамгаалалттай холбоотой тодорхой үүрэг гүйцэтгэж буй этгээдийг хэлнэ гэж хуулийн 3.1.4-д заажээ. Хуулийн 13 дугаар зүйлд заахдаа харуул хамгаалалтын алба хаагчаар 20 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, холбогдох сургалтанд хамрагдсан, ял шийтгэлгүй хүнийг ажиллуулна гэжээ.

Хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар харуул хамгаалалтын алба хаагч ижил загварын дүрэмт хувцас, тухайн байгууллагын онцлогийг тусгасан

ялгах тэмдэг хэрэглэнэ. Дүрэмт хувцасны загвар болон ялгах тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллага тогтооно.

Харуул хамгаалалтын үйл ажиллагааг зохицуулах үндсэн баримт бичиг нь харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээдээс үйлчлүүлэгчтэй хийсэн гэрээ байхаар хуульд заажээ. Гэрээ нь гэрээт харуул хамгаалалтын хууль болон иргэний хуулийн холбогдох заалтуудад чанд нийцсэн байх ёстой. Гэрээний заалтын тухайд зориуд тэмдэглэх нэг заалт хуульд бий. Энэ нь хуулийн 9 дүгээр зүйл бөгөөд харуул хамгаалалтын байгууллага болон түүний алба хаагч нь тодорхой хүний хувийн амьдрал, улс төр, шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй холбоотой баримт мэдээ цуглуулах, хэвлэн нийтлэх, үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр тэдгээрийн тухай аливаа мэдээллийг иргэн, хуулийн этгээд, хэвлэл мэдээллийн байгууллагад өгөхийг хориглоно гэжээ.

Харуул хамгаалалтын алба хаагч үүрэг гүйцэтгэхдээ зэвсэггүй тулалдах мэх, мөн гав, резинэн ба цахилгаан бороохой, нулимс асгаруулагч зэрэг нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болохыг хууль (20 дугаар зүйл) зөвшөөрчээ. Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх нөхцөлийг “Харуул хамгаалалтын алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэнийг хүч хэрэглэхгүйгээр таслан зогсоох боломжгүй бол” гэж тодорхойлжээ.

Харуул хамгаалалтын ажилтан зөвхөн аргагүй хамгаалалтын хүрээнд галт зэвсэг хэрэглэх эрхийг хуулиар олгосон ба тэгэхдээ аргагүй хамгаалалтын тохиолдлыг хуулийн 19 дүгээр зүйлд тодорхой зааж хязгаарласан байгаа. Тухайлбал “Хамгаалж байгаа эд хөрөнгө, объект болон өөрт нь шууд заналхийлж зэвсэг хэрэглэн, эсхүл бүлэглэн халдсан” тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно гэжээ. Харуул хамгаалалтын алба хаагч галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх зааврыг Улсын Ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталдаг. Хамгаалах тусгай хэрэгсэл, албаны нохой хэрэглэж болохыг хуульд заасан ба нохойг ашиглах журмын талаар хуульд ямар нэг заалт байхгүй, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журам ч байхгүй. Практик дээр нохойг харуул манааны үүрэг гүйцэтгэхэд туслалцуулахаар ашиглаж байгаа ба тусгайлсан дүрэм, журам төдийлэн үгүйлэгдэхгүй байна.

Монгол улсад ажиллаж байгаа хамгаалалтын компаниудын өнөөгийн байдал

Монгол улсын Засгийн газраас улсын онц чухал объектын жагсаалтыг баталдаг ба тэр жагсаалтад орсон объектуудыг цагдаа, дотоодын цэрэг хамгаалдаг байв. Харин 2013 онд дотоодын цэргийг татан буулгаж цагдаад аюулгүй байдлын алба байгуулсантай холбогдуулан дотоодын цэргийн хамгаалалтад байсан объектууд цагдаагийн хамгаалалтад шилжсэн.

Одоогийн байдлаар цагдаагийн төсөвт болон гэрээт хамгаалалтад Монгол улсын Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын төв байр, Гоц халдварт өвчинтэй тэмцэх үндэсний төвийн лаборатори, Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн дарь, дэлбэрэх бодисын үйлдвэр, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан хотын төвлөрсөн усан хангамжийн сан, өргөх байгууламж, Улаанбаатарын 3, 4 дүгээр цахилгаан станц, Монгол банк зэрэг байгууллага байна. Мөн Монгол Улсад суугаа гадаадын элчин сайдын яам, төлөөлөгчийн газрыг шаардлагатай гэж үзвэл цагдаагийн алба хаагчийн хүчээр хамгаалахыг зөвшөөрчээ.

Манай улсад гэрээт харуул хамгаалалтын 300 гаруй компани байгаа бөгөөд тэдгээрт улирлын байдлаас хамааран 3800-4500 хүн ажиллаж байна. Эдгээр компаниудыг дөрвөн хэсэгт хуваан үзэж болох юм.

1. Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхтэй гэрээ байгуулж дохиоллын болон биечилсэн хамгаалалт хийдэг бие даасан хуулийн этгээдүүд.
2. Томоохон холдинг, групп, компанийн хамгаалалтын алба. Тэд гэрээт харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд болж улсын бүртгэлд бүртгүүлсэн, харин өмнөхөөс ялгаатай нь зөвхөн өөрийн түшиглэсэн холдинг, групп, компанийхаа харуул хамгаалалтыг эрхэлдэг.
3. Улсын бүртгэлд компани гэж бүртгүүлэн гэрчилгээ авсан, харин ажиллагсад нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бараг эсвэл огт хамрагдаагүй, ихэнх нь улсын бүртгэлд бүртгүүлсэн хаягтаа тогтмол байршдаггүй, гэхдээ цөөн тооны объект харж хамгаалдаг.
4. Улсын бүртгэлд бүртгүүлж аж ахуйн нэгжийн буюу хуулийн этгээдийн гэрчилгээ авсан боловч үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй, эсхүл үйл ажиллагаа явуулахаа болиод нэг жилээс илүү хугацаа өнгөрсөн 30 орчим компани байна.

Гэрээт харуул хамгаалалтын хувийн компаниудын цөөн тооны хэд нь гадаадын хөрөнгө оруулалтын оролцоотойгоор анх байгуулагдсан боловч өнөөдрийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай компани байхгүй байна. Харин цөөн тооны хэдэн компанийн хувьцааны 25-аас бага хувийг гадаад улсын иргэн эзэмшдэг ажээ.

2000 онд гэрээт харуул хамгаалалтын хууль батлагдахад анхны зөвшөөрлийг Нийслэлийн цагдаагийн газраас авсан “Бамбай” (Security service) хязгаарлагдмал хариуцлагатай компанийг жишээ болгоё. Энэ компани дээр дурдснаар 1999 онд “Цагаан бар” компаниас салж байгуулагдсанаас хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа, манай улсын гэрээт харуул хамгаалалтын байгууллагууд дотроос одоогоор хамгийн өргөн үйл ажиллагаа явуулдаг компани юм. Энэ компани 17 жилийн хугацаанд 96.152 хэрэг, зөрчил илрүүлэн шийдвэрлүүлсний дотор хулгайн гэмт хэрэг 4055, гал түймэр гарах, ус алдах тохиолдол 372, бусад нь үйлчлүүлэгч байгууллагын дотоод журмыг зөрчсөн, архидан согтуурахтай холбоотой зэрэг зөрчил байна. Хулгайн гэмт хэргийн 12.5 хувь нь гадны халдлага, 87.5 хувь нь үйлчлүүлэгч байгууллагын дотроос эд зүйл авч гарах оролдлого байв. 2016 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 314 ажлын байранд 405 ажилчинтай, Улаанбаатар хот, 11 аймагт 901 объект хамгаалж байна. 17 жилийн хугацаанд долоон нэрийн татварт 5,9 тэрбум, тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, торгууль, үйлчлүүлэгчийн хохирол барагдуулахад 139,3 сая, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хураамжид ажил олгогчоос 1,3 тэрбум, ажилчдаас 1,1 тэрбум төгрөг төлсөн байна. Монгол улсын Засгийн газар, Худалдаа аж үйлдвэрийн үндэсний танхимаас хамтран жил бүр шалгаруулдаг Монгол Улсын Топ-150 аж ахуйн нэгжийн тоонд 2009-2011 онуудад гурван жил дараалан багтсан болно. Тус компани гурван жил тусгайлсан төлөвлөгөөтэй ажиллаж, олон улсын чанарын ISO-9001, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг ISO-14001, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн OHSAS-18001 стандартын болзол ханган батламж авчээ.

Гэрээт харуул хамгаалалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь

Засгийн газрын тогтоолоор нэр заасан онц чухал объектуудаас бусад (цэрэг, цагдаагийн бус) бүх объектуудыг хувийн компаниуд хамгаалж байна. Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болсон уул уурхайн бүх объект, арилжааны бүх банк, тэдгээрийн салбарууд, шатах, тослох материалын агуулах, түгээх станцууд, худалдаа, үйлчилгээний бүх объект хувийн хэвшлийн хамгаалалтад байна. Үүнээс гадна жижиг

ТҮЦ, ломбард, айл өрхүүдийн нэлээд нь хувийн компанийн хамгаалалтад байна. Үүнээс үзвэл дотоодын аюулгүй байдлыг хангахад хувийн хэвшил их үүрэг гүйцэтгэж байна.

Дотоодын аюулгүй байдлыг хангахад хувийн хэвшлийн оролцоог өргөтгөх шаардлагатай гэж үзнэ. Үүний тулд дор дурдсан зүйлийг анхаарах хэрэгтэй юм. Үүнд :

1.Хувийн хамгаалалтын тухай хуулийг боловсронгуй болгож сайжруулах. Жишээлбэл, хуулийн этгээд эрхэлж болох харуул хамгаалалтын төрлийг хуульд тусгаж өгөх шаардлага байна. Засгийн газрын тогтоол болон хуульд цэрэг, цагдаа зэрэг төрийн тусгай албад хамгаалахаар зааснаас бусад бүх объектыг хамгаалж болно гэж бид үзэж байна. Өнөөдрийн байдлаар Оюу толгой уурхайн “Хан Бумбат” онгоцны буудал, уурхайн тэсрэх бодисын агуулахыг хамгаалах эрхгүй гэсэн ойлголт төрийн зарим байгууллага, албан тушаалтанд байгаа.

2.“Харуул хамгаалалтын ажилтан” гэсэн мэргэжлийг улсын бүртгэлд оруулж, тодорхойлолтыг батлах шаардлага байна. Ямар ч бэлтгэлгүй хүнийг хамгаалагчаар ажиллуулах явдал түгээмэл байгаа нь муу үр дагавартай. Хамгаалалтын хувийн хэвшлийн ажилтнуудыг бэлтгэх дамжааны сургалтын хөтөлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсролын сайдын 2001.4.12-ны өдрийн 107,118 тоот дугаар тушаалаар баталсан. Энэ хөтөлбөр шаардлага хангахгүй байна. Тусгай хэрэгсэл хэрэглэх, автомашины маркийг ялган таних, ээлж хүлээлцэх, хамгаалалтын бичиг баримт хөтлөх, үйлчлүүлэгчидтэй харилцах онцлог зэрэг өдөр тутмын ажилд шаардлагатай зүйлүүдийг заадаггүй. Хуулиудын тухай мэдлэгийг ч оновчтой биш өгч байгаа.

3.1993 оноос хойших туршлагаас үзвэл төрийн байгууллагууд, түүний дотор цагдаагийн байгууллага, хамгаалалтын хувийн хэвшлийн байгууллагын хооронд ямар нэг зөрчил, ажил үүргийн давхардал ажиглагдахгүй байна. Сүүлийн жилүүдэд нийслэлийн цагдаагийн байгууллагаас санаачлан хамгаалалтын компаниудтай хамтарч уулзалт, сургалт зохион байгуулах нь нэмэгдсэн, улмаар хамтын ажиллагаа дээшилж байгаа. Гэвч олон нийтийн хэв журам сахиулах үүрэг бүхий төрийн байгууллагуудаас, тухайлбал цагдаагийн байгууллагаас хамгаалалтын хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах явдлыг сайжруулах шаардлага байна. Хамгаалалтын ажилтан хамгаалж байгаа объектод хамаарахгүй гэмт хэрэг, зөрчлийн шинж бүхий үйлдэлтэй ялангуяа шөнийн цагт тааралдах нь цөөн биш. Энэ үед хэрхэн ажиллах сургалт дутагдалтай байна. Ер нь хувийн хамгаалалтын хүчийг олон

нийтийн хэв журам сахиулах, иргэдийн амгалан тайван байдлыг хангахад хэрхэн ашиглаж болох арга замыг эрж хайвал багагүй тустай байж болох юм. Жишээлбэл, хувийн хамгаалалтын ажилтнуудаас шилж сонгон цагдаагийн туслах ажилтнаар ажиллуулж болох мэт.

4. Хувийн хэвшлийн байгууллагын хамгаалагч галт зэвсэг хэрэглэсэн тохиолдол одоогоор бүртгэгдээгүй байна. Мөн тусгай хэрэгсэл буруу хэрэглэсэн гомдол бүртгэгдээгүй байна. Харин өр хураах нэрээр бусдын эд хөрөнгөнд халдах, газрын маргаанаас үүдэлтэйгээр хашаа буулгах, гудамж замын хөдөлгөөн хаах хууль бус үйлдэл цөөн боловч гарсаар байна. “Хамгаалалтын” нэртэй автомашин олширч, зарим нь хууль бус ан агнахад оролцож, шалгагдсан тохиолдол гарсан. Энэ бүхнийг төрийн байгууллагын зүгээс анхаарч, цэгцлэх нь дутагдалтай байна. Хамгаалалтын зарим компани үүрэг гүйцэтгэх чадваргүй байгааг төрийн зүгээс хянаж шалгах шаардлагатай.

П. Цэцгээ

МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН ШҮҮХИЙН ХӨГЖИЛ ШИНЭЧЛЭЛ

Түүхэн товчоон

Монгол Улсад цэргийн шүүн таслах ажиллагаа эрхлэх тусгай шүүх үүсэн байгуулагдсан түүх өөрийн онцлогтой. 1921-1993 он хүртэл Цэргийн шүүхийг Монгол улсын шүүхийн системд “Тусгай шүүх” хэмээн нэрлэж, бүхий л үйл ажиллагааг нь тухайн цаг үеийн нөхцөл байдалд тохируулан шинээр байгуулах, татан буулгах асуудлыг тусгайлсан хууль тогтоомж гаргаж шийдвэрлэж байжээ.

Судлаачдын тэмдэглэснээр 1921 оны 3 дугаар сарын 24-ны өдөр хуралдсан Ардын Түр Засгийн газрын II хурлаар түр Засгийн бүтцийг батлахдаа Дотоод яамны бүтцэд шүүн таслах хэлтсийг байгуулж, цэргийн шүүн таслах газар байгуулахыг Цэргийн яаманд даалгасан нь шүүн таслах байгууллагын талаар авч явуулсан анхны арга хэмжээ...⁹²-ний нэг гэж үздэг.

Уг арга хэмжээний хүрээнд 1921 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн Ардын Засгийн газрын шийдвэрээр Цэргийн яамны дэргэд улс төрийн хэрэг болон зэвсэгт хүчний доторх хэргийг таслан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Цэргийн тусгай шүүх “Комендатын хороо”⁹³-г байгуулсан нь тус улсад анх удаа дагнасан шүүхийн суурь тавигдсан хэрэг юм.

Цэргийн яам нь шүүхийн дээд байгууллага байж, түүний үйл ажиллагааг удирдан улс орон даяар шүүх, шүүн таслах үүргийг гүйцэтгэж байсан бөгөөд улс орны хэмжээнд бүх төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэх шүүн таслах ажиллагааг төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын түшмэдүүд эрхлэн хэрэгжүүлж байсан зурвас үеийн онцлог нь шүүхийн тогтолцоо бүрдээгүй, бэлтгэгдсэн боловсон хүчингүй зэрэг нөхцөл байдалтай холбоотой.

1924 оны БНМАУ-ын анхны Үндсэн хуулиар улсын шүүн таслах газруудын ба хэргийг явуулах дүрэм хэм хэмжээ, иргэний ба эрүүгийн хуулийг тогтоох эрхийг Улсын дээд эрхийг барих газарт олгосны дагуу 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Бага хурлын тэргүүлэгчдээс батласан “БНМАУ-ын аливаа шүүн таслах газруудыг байгуулах тухайн

⁹² Ж.Болдбаатар, Д.Лундээнжанцан “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” . 2 дахь хэвлэл. УБ 2011. 257 тал.

⁹³ БНМАУ-ын хууль, түүнд холбогдох зарим актын эмхтгэл. /1921-1940/ 1 дэвтэр. УБ. 1972 он. 193 тал.

дүрэм"-ийг баталж гаргасан бөгөөд шүүхийн анхны тогтолцооны бүрэлдэхүүнд Тусгай шүүн таслах газар буюу цэргийн шүүх байхаар тогтоосон байна.

Уг шүүн таслах газрын онцлог нь:

- Улаан цэргийн үндэсний байдал ба хүчинд хорлолтой цэргийн хүмүүсийн үйлдсэн эрүүгийн хэргийг харьяалан таслан шийдвэрлэх
- Цэргийн шүүн таслах газруудын гишүүдийг бүх цэргийн зөвлөлөөс томилж, Улсын Бага Хурлаар баталж байхаар заасан.

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1928 оны 54 дүгээр тогтоолоор батласан “Монгол Улсын Улаан цэргийн шүүн таслах газрын дүрэм”-д Бүх цэргийн зөвлөлийн тогтоолоор цэргийн тогтмол (байнгын) шүүн таслах газар болон түр шүүн таслах газрыг байгуулж болох ба цэргийн шүүн таслах газрын албан хаагчдыг цэргийн албан хаагчид тооцох, цэргийн албан хаагчдын тухай гаргасан хууль дүрмийг дагаж мөрдөж байхаар зохицуулсан.

- Цэргийн хороо, ангиас гадна болон энгийн хүмүүстэй хамтран үйлдсэн хэргийг ардын шүүн таслах газар шилжүүлж шийтгүүлэх ингэхдээ цэргийн төлөөлөгч суулцуулах, цэргийн албан хаагчид холбоотой аливаа иргэний хэргийг цэргийн шүүн таслах газар хэлэлцдэггүй байжээ
- Цэргийн шүүн таслах газар болон 1931 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Дотоод явдлын яамны дэргэд шинээр байгуулагдсан “Хил хязгаарыг батлан хамгаалах газрын цэргийн шүүх”-үүд нь дарга, 2 гишүүнээс бүрдэж, жич 1 нарийн бичгийн даргатай байх, энэ нь өөрийн үндсэн үүргээс гадна орлогч гишүүний эрх хэмжээтэй, хэрэг шийдвэрлэхэд зөвлөх эрхтэй сууж байсан байна.

Мөн 1930 онд “БНМАУ -ын аливаа шүүх таслах газруудыг байгуулах тухайн дүрэм”-д “Монгол Улсын Цэргийн шүүн таслах газрууд ба цэргийн прокурор нарын дүрэм” гэсэн 5 дугаар бүлгийг шинээр нэмж таслан шийдвэрлэх хэргүүдийн харьяаллыг өргөтгөснөөс гадна цэргийн шүүн таслах газрын дарга, нарийн бичгийн даргыг жинхэнэ цэргийн алба хаагчид хамааруулсан шинэлэг зохицуулалтыг бий болгосон.

1940 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд “тусгай шүүн таслах газрын дарга, гишүүдийг Улсын Бага хурлаас 4 жилийн хугацаатайгаар сонгоно” гэж тусгай шүүхийн шүүх бүрэлдэхүүнийг

томилох асуудлыг Үндсэн хуулийн төвшинд тусгайлан хуульчилсан. 1949 онд батлагдсан анхны БНМАУ-ын Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт тусгай шүүхүүдийг цэргийн ангиуд ба цэрэгжүүлсэн албан газруудын дэргэд байгуулах, цэргийн шүүхүүдийн дарга, гишүүд, ардын төлөөлөгчдийг хууль тогтоох дээд байгууллага БНМАУ-ын Ардын Их Хурлаас 4 жилийн хугацаагаар сонгох, цэргийн гэмт хэргийг цэргийн шүүхийн дарга буюу гишүүдийн нэгээр даргалуулж, ардын 2 төлөөлөгчийг /таслах эрхтэйгээр/ оролцуулан шийдвэрлэх зэрэг асуудлыг хуулийн хүрээнд шинээр зохицуулж хуульчилсан байна.

1921-1940 он хүртэлх хугацаанд Цэргийн тусгай шүүхийн бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагааг зохицуулсан онцлог зохицуулалт бүхий эрх зүйн актуудын давхардсан шинжтэй заалтууд нэлээд байгаа нь холбогдох заалтыг өөрчилсөнтэй холбогдуулж өмнөх заалтуудыг хүчингүй болгож байгаагүйгээс хамааралтай байж болохоор байна.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1951 оны 77-р зарлигаар Чойбалсан хот, Өндөрхаан хот дахь цэргийн шүүхүүдийг татан буулгаж, БХЯ-ны дэргэд Ардын армийн цэргийн шүүхийг байгуулсан, 1965 онд тус шүүхийг “Ардын армийн тусгай шүүх” болгосон, 1972 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 92 дугаар зарлигаар “Хязгаарын ба Дотоодын цэргийн тусгай шүүх”-ийг, 1972 оны 279-р зарлигаар ардын армийн Зүүнбаян дахь нэгтгэлийн шүүхийг шинээр байгуулсан, 1978 онд АИХТ-ийн 44-р зарлигаар “Барилгын цэргийн тусгай шүүх”-ийг, 1980 онд АИХТ-ийн 5-р зарлигаар Эрдэнэт, Зүүнбаян, Улиастайд гарнизоны шүүхийг, 1985 онд АИХТ-ийн 224-р зарлигаар Хилийн цэргийн тусгай шүүхийг бүтэц зохион байгуулалт болон нэршлийн хувьд тус тус өөрчилсөн байна.

1988 онд “Цэргийн хуулийн байгууллагын зохион байгуулалтыг өөрчлөх тухай” МАХН-ын Төв хорооны Улс төрийн Товчооны 5 дугаар тогтоол, БНМАУ-ын АИХТ-ийн 6 дугаар зарлигаар Хязгаарын ба дотоодын цэргийн тусгай шүүх, Ардын армийн тусгай шүүх, Барилгын цэргийн тусгай шүүхийг нэгтгэн “Бүх Цэргийн Тусгай Шүүх”-ийг давж заалдах болон хяналтын шатны шүүхийн эрхтэйгээр байгуулж, Улаанбаатар, Зүүнбаян, Эрдэнэт гарнизон болон Ховд, Даланзадгад, Баруун-Урт, Арвайхээр хот дахь цэргийн ангийг түшиглэн, анхан шатны шүүхийн эрхтэй цэргийн тусгай шүүхүүдийг зохион байгуулан ажиллуулжээ.

Дээрх тусгай шүүхүүдийн бүхий л үйл ажиллагааг зохицуулсан хууль зүйн гол эх сурвалжийн нэг нь 1978 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 302 дугаар зарлигаар батлагдсан “БНМАУ-ын Цэргийн шүүхийн дүрэм” юм. Энэхүү дүрмэнд цэргийн тусгай шүүхүүдийн

зорилгыг “социалист шүүн таслах эрхийг хэрэгжүүлж, БНМАУ-ын аюулгүй байдал, зэвсэгт хүчний байлдааны чадвар, цэргийн сахилга, цэргийн алба хаах талаар тогтоосон журмын эсрэг халдсан аливаа үйлдэлтэй тэмцэх” гэж тодорхойлсон байна. Мөн цэргийн коллеги, цэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэх хэргийн харьяаллыг тогтоосон ба цэргийн анхан шатны шүүхийн ажиллах нөхцөлийг БНМАУ-ын Батлан хамгаалах яам болон БНМАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам хариуцах, шаардлагатай гэж үзвэл БНМАУ-ын Зэвсэгт хүчний гарнизон, Цэргийн анги, нэгтгэлд цэргийн шүүх шинээр байгуулж болохоор заажээ. Дээрх тусгай шүүхүүдийн бүхий л үйл ажиллагааг тухайн үед үйлчилж байсан БНМАУ-ын Үндсэн хууль болон Шүүхийн байгууламжийн тухай хуулиуд, БНМАУ-ын Цэргийн шүүхийн дүрмээр зохицуулж байсан ба Үндсэн хуульд зааснаар цэргийн шүүх (Тусгай шүүх) нь шүүхийн нэгдсэн системд багтаж, түүний шүүн таслах үйл ажиллагаа нь Дээд шүүхийн хяналтад байсан хэдий ч хэргийг шүүн таслахдаа хэний ч нөлөөнд үл автах гагцхүү хуульд захирагдах зарчим бодитойгоор хэрэгжих боломж хангалтгүй байсан нь доорх нөхцөл байдалтай холбоотой гэж үздэг.

- Дээд шүүхийн цэргийн коллеги, цэргийн шүүхийн бүрэлдэхүүн нь зэвсэгт хүчний орон тооны бүрэлдэхүүнд багтаж, батлан хамгаалах яамны байгууллага, цэргийн ангийн цэргийн албан хаагчын нэгэн адил цол, хангамж эдэлдэг, цэргийн шүүхийн генерал, офицер, улирагчид нь цэргийн албан хаагчдын дагаж мөрдөх дүрэм, заавар болон БХЯ, НАХЯ-ны сайдын цэргийн алба хаах журмыг тогтоосон тушаалыг дагаж мөрдөж байхаар тогтоосон
- Цэргийн шүүхийн материал техникийн хангамж, орон байр, уналгаар хангах, санхүүжүүлэх зэргийг БХЯ, НАХЯ хариуцаж байсан
- Цэргийн шүүхийн албан байр болон цэргийн шүүхээр шүүгдэж байгаа хүмүүсийг хамгаалах үүрэг цэргийн шүүхийн түшиглэн ажиллаж байгаа гарнизон, цэргийн анги, нэгтгэлүүд хамгаалах үүрэгтэй
- Дээд шүүхийн цэргийн коллегийн дарга нь цэргийн шүүхийн ажиллагаатай холбоотой асуудлаар дээрх яамдууд болон Ардын армийн улс төрийн газрын даргад мэдээлэл хийдэг байсан зэрэг нь уг шүүхийг хараат бусаар ажиллахад ямар нэгэн хэмжээгээр нөлөөлж байсан гэж үзэх үндэслэлтэй юм.

Мөн Цэргийн шүүн таслах ажиллагаанд хамтын зарчмыг баримтлахаар заасны дагуу анхан шатны шүүх бүрэлдэхүүнд шүүгчийн адил эрх эдлэх 2 ардын төлөөлөгчийг оролцуулж байсан ба цэргийн шүүхийн дарга, орлогч дарга, гишүүд, ардын төлөөлөгчид нь БНМАУ-ын харьяат, сонгуулийн эрхтэй, ял шийтгэлгүй, 23 насанд хүрсэн цэргийн албан хаагч байх ижил шаардлага тавигдаж байсан, шүүхийн дарга, орлогч, гишүүд (шүүгчид)-ийг БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс 4 жилийн хугацаагаар, ардын төлөөлөгчийг цэргийн анги, нэгтгэлийн нийт албан хаагчдын хурлаас ил санал хураах журмаар 2 жилийн хугацаагаар (хожим 2 жил хагасын хугацаагаар) сонгодог байснаас үзэхэд мэргэжлийн шүүх бүрэлдэхүүн цэргийн шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж байгаагүй байна.

Тухайн үеийн цэргийн шүүхээр хэлэлцэж байсан хэрэг, шийтгүүлсэн хүмүүсийн тоо их байсан нь цэргийн албан хаагчдын үйлдсэн эрүүгийн бүх хэрэг, цэргийн алба хаах үүрэгтэй хүмүүсээс сургуулийн цугларалт хийж байх үедээ үйлдсэн эрүүгийн хэрэг, бүлэглэсэн хэрэгт цэргийн албан хаагч оролцсон болон аюулаас хамгаалах, цагдаа, засан хүмүүжүүлэх байгууллагын офицер, ахлагч, түрүүч, байлдагч, сэргийлэгч, хянагч, гал сөнөөгч зэрэг хүмүүсийн үйлдсэн эрүүгийн хэргүүдийг хамааруулж таслан шийдвэрлэж байсантай холбоотой юм. Нөгөө талаар цэргийн гэмт хэргийн субъектыг өргөн хүрээтэй авч үзэж, тэдний үйлдсэн хэргийг цэргийн тусгай шүүхээр таслан шийдвэрлэж байсан нь хүний үндсэн эрх, эрх чөлөөнд халдаж, эрх зүйн байдлыг дордуулсан нөхцөл байдалд хүргэж байжээ гэж үзэхээр байна.

”Улсад учруулсан цэргийн албан хаагчдын материалын хариуцлагын дүрэм”-д зааснаар цэргийн албан хаагч албан үүргээ биелүүлэх үедээ байгууллагадаа материалын хохирол учруулсан тохиолдолд, БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1984 оны 48 дугаар тогтоол (Иргэний хуулийн 320 дугаар зүйлийг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай)-д зааснаар “орчин тойрондоо аюул учруулж болох зүйлээс “учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг зөвхөн цэргийн шүүхүүд шийдвэрлэж байжээ.

Монгол Улсын цэргийн байгууллагын орон тоо, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулж, 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Шүүх байгуулах тухай хууль, 1993 оны Монгол Улсын Их Хурлын 1993 оны 60 дугаар тогтоолоор Бүх Цэргийн Тусгай Шүүх, анхан шатны тусгай шүүхийг татан буулгаснаар Цэргийн шүүхийн гүйцэтгэж байсан шүүн таслах үйл ажиллагааг ардын шүүхүүд цэргийн албан хаагчдын оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу хэрэгжүүлэхээр болсон байна.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулиар шүүхийн тогтолцоог төрийн эрх мэдэл хуваарилах зарчимд нийцүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах шударга шүүхийн тогтолцоог бий болгох, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг төр хангах, шүүн таслах ажиллагааг мэргэшсэн шүүх бүрэлдэхүүн хэрэгжүүлэх, аливаа этгээд шүүхэд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглосон зэрэг асуудлыг үндсэн хуулийн төвшинд шинээр хуульчилсан тул тусгай шүүхүүдийг татан буулгасан байна.

Цэргийн гэмт хэрэг гэж юу вэ? Түүнийг хэрхэн тодорхойлох вэ?

Монгол Улсын 2008 оны 2 дугаар сарын 1-нийг хүртэл Эрүүгийн хуульд “Цэргийн гэмт хэрэг” гэж томъёологдсон бүлэг хуульчлагдсан байсныг “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” болгон өөрчлөн нэрлэжээ. “Цэргийн” гэгдэх гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн “гэмт хэрэг” гэсэн ойлголтод бүрэн хамрагдсан, нийгэмд аюултай, хуульд харш, гэм буруутай үйлдэл (эс үйлдэл) юм.

1963 оноосхойш цогц байдлаар батлагдан үйлчилсэн Эрүүгийн гурван хуульд цэргийн гэмт хэрэг гэсэн ойлголтыг тухайлан тодорхойлоогүй атлаа бусад гэмт хэргүүдээс ялгагдах түүний онцлогуудыг зааж өгсөн байна.

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10 дугаар хэсэг 29 дүгээр бүлгийн 274 - 296 дугаар зүйлд “Монгол Улсын хууль тогтоомж болон цэргийн дүрэмд тогтоосон цэргийн алба хаах журмыг зөрчиж, нийгэмд аюултай хор уршиг учруулсан, эсхүл учирч болох нөхцөл байдлыг бий болгосон үйлдэл, эс үйлдэхүйг цэргийн албаны гэмт хэрэгт тооцоно” гэж хуульчлан тогтоожээ.

Эрүүгийн хуулийн 274 дүгээр зүйлийн 274.1-д Монгол Улсын иргэн зэвсэгт хүчин, бусад цэрэгт, цэргийн үүрэгтэн дайчилгаа, сургууль, цугларалтын үед цэргийн алба хаах талаар хуулиар тогтоосон журмыг зөрчиж энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдсэн бол цэргийн албаны гэмт хэрэг гэж тодорхойлсон байна.

Цэргийн албан хаагч гэдэгт “Зэвсэгт хүчин, бусад цэргийн бүрэлдэхүүнд цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэн” хамаарах учиртай.

2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн Эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр “цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гал түймэртэй тэмцэх байгууллагын офицер, ахлагч, гал, сөнөөгч, хорих байгууллагын албан хаагчдыг Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт заасан

цэргийн гэмт хэргийн субъект биш гэж үзэж 274 дүгээр зүйлийн 274.3 гэсэн заалтыг хүчингүй болгожээ.

Гэтэл 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах, үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг” шинээр “цэргийн алба” хэмээн томъёолсон байна. Эндээс үзэхэд цэргийн албаны эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг өргөтгөсөн утгаар ойлгох, улмаар Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсэхэд шаардлага тулгарахаар байна.

Цэргийн албаны гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь Монгол Улсын хууль тогтоомжид заан тодорхойлсон цэргийн алба хаах журам, түүнийг зохицуулж буй хэм хэмжээ нийлбэр цогц юм.

Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн объектив талын шинж нь цэргийн алба хаах талаар тогтоосон журмыг зөрчсөн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй юм.

Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн субъект нь өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулиар зэвсэгт хүчинд цэргийн алба хааж байгаа цэргийн албан хаагч, түүнчлэн түр сургууль хийж байгаа цэргийн алба хаах хүмүүс байна. Цэргийн албан хаагч гэмт хэрэг үйлдэх үедээ цэргийн албанаас өөр үүрэг гүйцэтгэж байсан, эсхүл түр хугацаагаар чөлөөтэй байсан ч Эрүүгийн хуулийн 274- 296 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн бол цэргийн албаны эсрэг хэргийн субъект болно.

Түүнчлэн цэргийн албанд 18 нас хүрээгүй байхдаа татагдаж ирсэн, гэмт хэрэг үйлдэх үедээ биеийн эрүүл мэндээр цэргийн албанд тэнцэхгүй болсон хүмүүс цэргийн албан хаагчдын нэгэн адил цэргийн алба хаах тухай хуульчлагдсан дэг журмыг чанд сахих үүрэгтэйн хувьд цэргийн албаны эсрэг гэмт хэргийн субъект болох үндэслэлтэй.

Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн субъектив тал нь санаатай ба болгоомжгүйн аль ч хэлбэрээр илэрч болно. Жишээ нь: Захирагчийн тушаалыг эсэргүүцэх, заналхийлэх, хүч хэрэглэх, цэргийн албанаас оргон зайлах зэрэг цэргийн гэмт хэргүүд нь зөвхөн шууд санаатайгаар өдүүлэгдэж байхад, захирагчийн тушаалыг биеүүлэхгүй байх, байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих гэмт хэргүүд нь ихэвчлэн болгоомжгүй хэлбэртэй байдаг. Харин харуулын, хилийн албаны журам зөрчих гэмт хэргүүд нь

санаатай буюу болгоомжгүйн аль ч хэлбэртэй байна.

Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн субъектив талын шинжийг тодорхойлоход уг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зорилго, сэдэлтийг тогтоох нь чухал тул санаатайгаар гэмт хэрэг өдүүлсэн этгээдийн хувьд энэхүү шаардлага заавал байх шинж болно.

Эндээс, цэргийн албаны гэмт хэргийг зөвхөн Монгол Улсын иргэн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд цэргийн алба хааж байгаа үед болон цэргийн үүрэгтэн, дайчилгаа, сургууль, цугларалтын үед цэргийн алба хаах талаар тогтоосон журмыг зөрчсөн гэмт үйлдэл (эс үйлдэл) хэмээн тодорхойлж болно. Энэхүү хэргийг Эрүүгийн хуулийн бусад бүлэгт заасан гэмт үйлдлүүдээс ялгах гол шинж нь тусгай объект, тусгай субъекттэй байдагт оршино.

Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг нь материаллаг болон хэлбэрийн бүрэлдэхүүний аль алиныг агуулж болно. Өөрөөр хэлбэл гэмт үйлдлийн ихэнх үр дүн нь хохирол, хор уршгаар, зарим тохиолдолд зөвхөн үйлдэл хийгдсэнээр төгссөнд тооцогдоно. Жишээ нь: Цэргийн албанаас оргон зайлах, захирагчийн тушаалыг биелүүлэхгүй байх, заналхийлэх зэрэг нь заавал хор хохирол учирсан байхыг шаардахгүй. Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн үйлдэгдсэн цаг үеийн нөхцөл байдлыг шууд хүндрүүлэх үндэслэл болгон авч үзсэн байдаг. Тухайлбал, дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий нөхцөлтэй үед уг гэмт хэргийг өдүүлбэл хүндрүүлэх, онц хүндрүүлэн үзэх бүрэлдэхүүнтэй хэмээн үздэг.

Цэргийн анги, байгууллагын тухай ойлголт, газар зүйн шалгуур

Цэргийн анги, байгууллагын тухай ойлголт

Юуны урьд өнөө үйлчилж буй Эрүүгийн хуулийн цэргийн албаны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт ганцаараа хамаарч буй объектыг тодорхойлох шаардлагатай, тэр нь Монгол Улсын зэвсэгт хүчин юм.

Монгол улсын зэвсэгт хүчин нь улс орныг цэргийн хүчээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллагуудын тогтолцоо мөн. Зэвсэгт хүчин нь тайван цагт ерөнхий зориулалтын, хилийн ба дотоодын цэрэг, мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулна. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нь цэргийн албан хаагч болон цэргийн анги байгууллагад гэрээгээр ажиллагсдаас бүрдэнэ.

Цэргийн анги байгууллага гэж цэргийн бүх шатны удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, цэргийн сургууль болон батлан хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг бусад хуулийн этгээдийг хэлнэ.

“Цэргийн албаны үүрэг гүйцэтгэж байгаа үе” гэдэгт цэргийн албан хаагчийн ангидаа байх, ажилдаа ирэх, харих, ангийн байрлалын гадна үүргээ биелүүлэхийг цэргийн албаны үүргээ гүйцэтгэж байгаа үеийг тооцно .

“Гэрээт цэргийн албан хаагч” гэдэгт Монгол Улсын Засгийн Газраас тогтоосон журмын дагуу цэргийн албанд сайн дурын үндсэн дээр гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэн байна.

Энгийн болон цэргийн алба хаах үүрэг бүхий хүмүүс, бэлтгэлд байгаа иргэд цэргийн албаны эсрэг гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон байж болно. Эдгээр хүмүүс зөвхөн цэргийн албаны эсрэг гэмт хэрэгт (зохион байгуулагч, хамжигч, хатгагчийн) үүрэг гүйцэтгэснээр эрүүгийн хариуцлага хүлээнэ. Харин гүйцэтгэгч байж болохгүй. Ийм тохиолдолд Эрүүгийн хуулийн 274 дүгээр зүйлийн 274.4-т зааснаар Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийг журамлан зохих зүйл, хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

“Захирагч” (дарга) гэдэг нь цэргийн дүрэм ёсоор цэргийн бусад албан хаагчдад тушаал өгч гүйцэтгэлийг хангуулах эрх, үүрэг бүхий цэргийн албан хаагч болно.

“Захирагдагч” гэж тасаг, салаа, анги, нэгтгэлийн бүрэлдэхүүн цэргийн алба хааж, удирдлагынхаа тушаалыг биелүүлэх, түүнчлэн цэргийн албан тушаалыг биелүүлэх үүрэг бүхий цэргийн албан хаагчийг ойлгоно.

“Тушаал” гэдэг нь албан хаагч албан үүрэг, цолны эрэмбээр захирагдах нэг буюу хэсэг хүмүүст шууд хандаж өгөгддөг тодорхой шаардлага агуулсан заавал биелүүлэх үүрэг. Тушаал нь аман болон бичгийн аль ч хэлбэртэй байхаас гадна утас, цахилгаан, радио станц, холбоо харилцааны бусад албан ёсны хэрэгслээр дамжуулан өгөгдөнө. Тушаалыг зөвхөн цэргийн албаны ашиг сонирхлын үүднээс өгнө. Үүнээс бусад хууль бус тушаалыг захирагдагч биелүүлээгүй тохиолдолд түүнд хариуцлага хүлээлгэхгүй. Даргын өгсөн тушаалыг захирагдагч нь ямар ч хариу тайлбаргүй биелүүлдэг зарчим бол цэргийн тодорхой анги, салбар, нэгжийн өмнө өгөгдсөн эх орны даалгавар. Энэ нь Монгол Улсын цэргийн албаны төдийгүй дэлхий нийтээр тогтоосон цэргийн албаны нийтлэг зарчим юм.

“Цэргийн алба хааж эхэлсэн хугацаа” гэж хугацаат цэргийн албаны байлдагч, түрүүчийг цэрэг татлагын байрнаас анги, байгууллагад хуваарилагдсан тэр өдрийг хэлдэг.

“Цэргийн алба хааж дууссан хугацаа” гэж тухайн этгээдийг бэлтгэлээс халах тухай ангийн захирагчийн тушаал гарсан үеэс, харин офицер ахлагчийн хувьд тэднийг тус тусын бүрэлдэхүүнд багтаасан тушаал гарснаар дууссан хэмээн тооцно.

Эрүүгийн хуульд заасан цэргийн албаны эсрэг гэмт хэргийг халдсан объект, бүрэлдэхүүний онцлог шинжээр нь дараах зүйлд ангилжээ.

- Захирагчийн тушаал биелүүлээгүй байх (275 дугаар зүйл)
- Захирагчийг заналхийлэх, эсэргүүцэх, хүч хэрэглэх (276 дугаар зүйл)
- Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх (277 дугаар зүйл)
- Бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих (278 дугаар зүйл)
- Цэргийн албанаас оргон зайлах (279 дүгээр зүйл)
- Биедээ гэмтэл учруулах буюу өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх (280 дугаар зүйл)
- Цэргийн эд хөрөнгийг болон байлдааны галт хэрэгслийг зарах, үрэгдүүлэх, завших (281 дүгээр зүйл)
- Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (282 дугаар зүйл)
- Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих (283 дугаар зүйл)
- Байлдааны машин жолоодох болон ашиглалтын журам зөрчих (284 дүгээр зүйл)
- Байлдааны болон сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх журам зөрчих (285 дугаар зүйл)
- Байлдааны жижүүр хийх журам зөрчих (286 дугаар зүйл)
- Дотоод албаны журам зөрчих (287 дугаар зүйл)
- Харуулын албаны журам зөрчих (288 дугаар зүйл)
- Хилийн алба хаах журам зөрчих (289 дүгээр зүйл)
- Цэргийн анги, нэгтгэлийг дайсанд буулгаж өгөх, орхих (290 дугаар зүйл)

- Байлдааны талбарыг дур мэдэн орхих, дайсантай (291 дүгээр зүйл)
- Сайн дураараа дайсанд бууж өгч олзлогдох (292 дугаар зүйл)
- Байлдааны талбарт тонуул хийх(293 дугаар зүйл)
- Эрх мэдлээ урвуулан ашиглах, хэтрүүлэх, хэрэгжүүлэхгүй байх (294 дүгээр зүйл)
- Албандаа хайнга хандах (295 дугаар зүйл)
- Байлдааны талбарт Улаан загалмайн тэмдгийг хууль бусаар зүүх, урвуулан ашиглах (296 дугаар зүйл)

Газар зүйн шалгуур

Цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, цэргийн сургууль болон батлан хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллага хаана байрлаж байгаагаас хамаарч гэмт хэрэг гарсан үед нутаг дэвсгэрийн харьяаллын зарчмыг удирдлага болгон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явагдана.

Одоо үйлчилж байгаа 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 болон 27 дугаар зүйлийн 27.4-т заасны дагуу нутаг дэвсгэрийн зарчмыг урьтал болгон өдүүлэгдэн гарсан гэмт хэргийн хүнд, хөнгөнөөс хамаарч цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид цэргийн албаны гэмт хэрэг өдүүлсэн этгээдэд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулна. Дашрамд дурдахад цэргийн шүүх, цэргийн прокурорын байгууллага дэргэдээ мөрдөн байцаагч бүхий тусгай алба үйл ажиллагаа явуулдаг байсан үед цэргийн гэмт хэрэг (тэр үеийн нэр томъёогоор нэрлэв) нь нутаг дэвсгэрийн харьяаллаар бус зөвхөн хэргийн харьяаллын зарчмыг удирдлага болгон шийдвэрлэгддэг байсан байна.⁹⁴

Цэргийн албан хаагчид бие биенийхээ эсрэг үйлдсэн гэмт хэрэг гэсэн ойлголтын шалгуур үзүүлэлт

Цэргийн албан хаагчдын “бие биендээ гэмтэл учруулах” гэмт хэргийг тусгайлан авч үзэхдээ Эрүүгийн хуулийн 6 дугаар хэсэг дэх “Хүний эрх , эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг”, юуны түрүүн мөн хэсгийн 15 дугаар бүлэгт байгаа “хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ийн зүйл, заалт, бүрэлдэхүүн, хүндрүүлэх, хөнгөрүүлэх үндэслэлүүд болон холбогдох хууль тогтоомжийг анхаарч үзэх нь чухал байна.

⁹⁴ Цэргийн гэмт хэрэг, Б.Бат-ерөөлт, Б.Нямдорж, УБ. 2007 он

Цэргийн албан хаагч бие биендээ, эсхүл энгийн хүнд гэмтэл учруулсан аль ч тохиолдолд гэмтлийн зэрэг тогтоох шүүх эмнэлэгийн магадлан шинжилгээний зааврыг үндэслэн тогтоосон шинжээчийн дүгнэлт заавал шаардагдана.

Цэргийн албан хаагчид бие биедээ гэмтэл учруулах тохиолдол, захирагч захирагдагч хүч хэрэглэсэн (ЭХ-ийн 277 дугаар зүйл), бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчсөн (ЭХ-ийн 278 дугаар зүйл), Биедээ гэмтэл учруулах буюу өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх (ЭХ-ийн 280 дугаар зүйл), байлдааны зэвсэг хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих (ЭХ-ийн 283 дугаар зүйл), байлдааны машин жолоодох болон ашиглалтын журам зөрчих (ЭХ-ийн 284 дүгээр зүйл), байлдааны болон сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх журам зөрчих (ЭХ-ийн 285 дугаар зүйлийн 285.2) гэмт хэргүүд өдүүлэгдсэн үед гарч болно. Түүнчлэн “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” бүлэгт багтан орсон зарим хэргүүдэд хүний биед янз бүрийн гэмтэл учруулах, амь насыг бүрэлгэх тухай шууд бус хэлбэрээр тусгасан байдаг. Тэгэхдээ амь нас бүрэлгэх нь болгоомжгүй хэлбэрээр (ЭХ-ийн 283 дугаар зүйлийн 283.3, 284 дүгээр зүйлийн 284.2, 284.3), бусдын биед янз бүрийн гэмтэл учруулах нь санаатай, болгоомжгүй аль ч байдлаар өдүүлэгдэхээр хуульчилжээ.

Ер нь гэмт хэргийн хор уршиг нь гэмт халдлагын улмаас нийгэм, төр, байгууллага, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг сонирхолд учирсан гэм хор бөгөөд гэмт хэргийн онцгой үр дагавар юм. Тухайлбал, хүний амь хохирсон, гэмтэл учирсан, эд хөрөнгө устсан, гэмтсэн гэх мэт.

Харин хохирол нь:

- А) Эдийн (мөнгөөр хэмжигдэх);
- В) Эдийн бус (мөнгөөр хэмжигдэхгүй) гэсэн хоёр төрөлтэй байна.

Эдийн бус хохирол нь:

- А) Нөхөн төлөгдөх
- Б) Нөхөн төлөгдөхгүй гэсэн хоёр хэлбэр агуулна.

“Нөхөн төлөгдөх эрүүл мэндийн хохирол” гэдэгт гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан гэмтэл нь бүрэн эдгэрч, хохирогч этгээд хэвийн амьдрах боломжтой болохыг, “нөхөн сэргээгдэх боломжгүй эрүүл мэндийн хохирол” гэдэгт гэмтсэн эрхтэн нь эдгэрэх боломжгүй, бүр мөсөн

байхгүй болсон, засрашгүй сорви, мөр үлдээсэн зэргийг хамааруулан ойлгоно.

Цэргийн албан хаагчид бие биенээ хайрлан хамгаалах, өөр хоорондоо хүндэтгэлтэй хандах, дүрмийн шаардлагыг мөрдөн биелүүлэх, хамт олон ч нөхөрсөг, шударга байхыг ямагт чухалчилж байх нь цэргийн албаны гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нөлөөтэй юм.

Улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэргийн дотор цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 2013 онд 0,084, 2014 онд 0,094, 2015 онд 0,088 хувийг эзэлж байна.

Цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, цэргийн сургууль болон батлан хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагын байрлаж байгаа нутаг дэвсгэрт оршин байрлах сум, сум дундын болон дүүргийн анхан шатны эрүүгийн хэргийн шүүхүүд цэргийн албаны гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэдэг.

Сүүлийн 3 жилийн хугацаанд нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу анхан шатны эрүүгийн хэргийн шүүхүүдээс шийдвэрлэсэн цэргийн албаны эсрэг гэмт хэргийг тухайн шүүхийн шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэрэгт харьцуулан үзэв.

Онууд	Тухайн анхан шатны эрүүгийн хэргийн шүүхээс нутаг дэвсгэрийн харьяаллаар шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлт (аймгууд)		Эзлэх хувь
	Шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэргийн тоо	Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн тоо	
2013 он	352	3	0,85 хувь
2014 он	473	6	1,26 хувь
2015 он	711	6	0,84 хувь
нийт	1536	15	0,97 хувь

Дээрх тоон үзүүлэлт нь шүүхийн статистик мэдээнд үндэслэсэн ба цэргийн албаны эсрэг гэмт хэрэг улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн дотор маш бага хувийг эзэлжээ.

Мөн цэргийн албаны эсрэг гэмт хэргийг Эрүүгийн хуулийн зүйл заалтаар нь судлахад захирагдагчдаа хүч хэрэглэсэн, бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчсөн, цэргийн албанаас оргон зайлсан, цэргийн албанаас зайлсхийсэн, цэргийн эд хөрөнгийг болон байлдааны галт хэрэгслийг зарах, үрэгдүүлсэн, байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчсөн хэргүүд байна.

Дүгнэлт

Хэдийгээр цэргийн албаны эсрэг гэмт хэрэг тооны хувьд цөөхөн ч цэргийн албан хаагчдын шийтгэгдсэн цэргийн албаны эсрэг гэмт хэргийн зүйлчлэлээс үзэхэд цэргийн албан хаагчдын ёс зүйн асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.

2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах, үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг” шинээр “цэргийн алба” хэмээн томъёолсон нь үр дагаврын хувьд асуудал үүсгэж байна. Эндээс үзэхэд цэргийн албаны эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг өргөтгөсөн утгаар ойлгоход хүргэх нөхцөл байдалд хүргэж болохоор байгаа тул хуулийн энэ заалт болон Эрүүгийн хуулийн холбогдох заалт хоорондох хийдэлийг цэгцлэх, зөвхөн нийгмийн хамгаалал, халамжийн хүрээнд хэрэглэх гэж явцуу утгаар ойлгох нь зүйтэй.

Цэргийн албаны гэмт хэргийг энгийн шүүх шийдвэрлэж байгаа нь аливаа томоохон зөрчил, хүндрэл үүсгэж байгаа онцгой нөхцөл байдал харагдахгүй байна гэж үзэж байна.

П. Оюунчимэг

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАР ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Аюулгүй байдлын салбар дахь хүний эрхийн асуудал

Монгол улсын 1992 оны шинэ Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлыг онцгойлон авч үзэж баталгаажуулснаараа түүхэн томоохон өөрчлөлтийг авч ирсэн бөгөөд энэ ч үүднээс “Ардчилсан Үндсэн хууль” хэмээн нэрлэгддэг. Үндсэн хууль батлагдсанаас хойш 8 жилийн дараа буюу 2000 онд Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий үндэсний байгууллага байгуулах хуулийг батлан гаргаснаар Хүний Эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй.

Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хууль 6 бүлэг, 26 зүйлтэй бөгөөд Комисс, түүний гишүүний бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, хүний эрх, эрх чөлөөг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Комисст гомдол гаргах, шийдвэрлэх журмыг зохицуулдаг. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3.1-д «Комисс нь Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн» гэж заасан.

Хүний эрхийн комиссын тухай хуулийн 3,3-д зааснаар “Комисс нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хараат бус байх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шударга, ил тод байх зарчмыг баримтална...3.4 дэх хэсэгт зааснаар “...аливаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн Комисс, түүний гишүүний үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно гэж заасан байдаг. Өнөөдрийн байдлаар комисс нь хараат бусаар бие даан үйл ажиллагаагаа явуулах Парисын зарчмын дагуу ажиллаж байгаа бөгөөд үүнд улс төрийн болон бусад байдлаар хэн нэгэн албан тушаалтан, хувь хүн нөлөөлөх боломжгүй .

Хуульд зааснаар Комиссын гишүүнд нэр дэвшигчийн нэрийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга Улсын Их

Хуралд өргөн мэдүүлдэг. Комиссын даргыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Комиссын гишүүдээс Улсын Их Хурал гурван жилийн хугацаагаар томилно. Комиссын гишүүний нэгэн бүрэн эрхийн хугацаа зургаан жил байна.

Хүний эрхийн үндэсний комисс нь хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдагтай холбоотойгоор хэн нэгэн албан тушаалтанд ажлаа тайлагнадаггүй зөвхөн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэдэг. Илтгэлийг Хууль Зүйн байнгын Хороо хуралдаанаар хэлэлцээд тогтоол гаргах бөгөөд шаардлагатай гэж үзвэл хүний эрхийн тухайн жилийн илтгэлийн сэдвээс хамааран Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлдэг

2010 онд НҮБ-ын Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээр Монгол улсын хүний эрхийн илтгэлийг авч хэлэлцээд өгсөн зөвлөмжиндөө Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагаа явуулахад нь хүрэлцэхүйц, хангалттай төсөв хөрөнгөтэй байх талаар Монгол Улсын Засгийн газарт удаа дараа зөвлөсөн байдаг. Монгол улсын нутаг дэвсгэрт бүхэлд нь үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагын хувьд сүүлийн 3 жилийн төсвийг 2014 онд 830,3 сая, 2015 онд 831,5 сая, 2016 онд 731,6 сая төгрөгөөр төсөвлөсөн нь үйл ажиллагаа явуулахад туйлын хангалтгүй бөгөөд сүүлийн жилүүдэд хүний эрхийн тусгайлсан эрхийн хүрээнд олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн болно.

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс нь үйл ажиллагаа явуулж буй 15 жилийн хугацаанд 3 удаа Хүний Эрхийн Үндэсний Байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хороонд «А» статусаар магадлан итгэмжлэгдсэн, Ази Номхон Далайн Бүс Нутгийн Хүний Эрхийн Үндэсний Байгууллагын Чуулганы бүрэн эрхт гишүүн юм.

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулиараа хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий үндэсний байгууллага болохын хувьд аюулгүй байдлын салбарт ажиллах үүрэг хүлээсэн төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах, шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах, сургалтуудыг зохион байгуулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг таслан зогсоох зорилгоор тусгай удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, иргэдийн гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагааг явуулдаг.

Эдгээрийг дэлгэрүүлж үзвэл:

Хүний эрх, эрх чөлөөг бататган хамгаалсан олон улсын гэрээ, конвенцид нэгдэж орохын зэрэгцээ өөрийн иргэдийн ашиг сонирхлыг хамгаалсан хоёр талын гэрээ, хэлэлцээр байгуулах асуудлыг дэмжих үйл ажиллагаа

Аюулгүй байдлын салбарт хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа нь Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 13.2.6-д заасан зохицуулалтын дагуу хэрэгждэг. Үүнд олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх; олон улсын хүний эрхийн гэрээг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохыг дэмжих үйл ажиллагаа багтаж байна.

НҮБ-д болон гэрээний хороодод Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн газраас явуулж буй илтгэлүүдэд хөндлөнгийн санал өгөх болон Комисс хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллага болохын хувьд сүүдэр илтгэлийг явуулдаг. Комисс байгуулагдсан цагаасаа хойш 5 удаагийн сүүдэр илтгэлийг Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд 2016 оны 7 дугаар сарын 13-ны өдөр, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хороонд 2006 он болон 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр, НҮБ-д Монгол Улсын Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг 2010 болон 2014 оны 9 дүгээр сарын 14-ны өдөр Хүний Эрхийн Үндэсний Комиссын сүүдэр илтгэлийг бичиж хүргүүлсэн байна.

Тухайлбал, 2008- 2015 онуудад Комисс хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд 100 орчим саналыг боловсруулж хүргүүлснээс гадна Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3-р нэмэлт протокол, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт протокол болох Палермогийн протокол зэрэг олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орох асуудлаар нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулсан.

Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах дараагийн арга зам болох гадаадад зорчиж, ажиллаж амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд тэдний эрх, үүргийн талаар эрхээ мэдэж хамгаалах талаар мэдээлэл өгдөг механизм буй болгохын дээр гадаадад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар иргэдийнхээ эрхийг хамгаалах үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа

Эл хүрээнд Комисс өөрийн санаачилгаар иргэдийнхээ эрхийг хамгаалах үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2-т олон улсын, бүсийн, хүний эрхийн бусад үндэсний байгууллагатай хамтран ажиллахаар заасан болно.

Комисс Ази Номхон Далайн бүсийн Хүний Эрхийн Чуулганы гишүүн орны хувьд бусад улсуудын хүний эрхийн байгууллагуудтай хамтран гадаадад оршин сууж байгаа Монгол иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаагийн нэгжишээ нь БНСУ, Мьянмар, Филиппин, Австрали улсын Хүний эрхийн үндэсний байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж байна.

Гадаад улсад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдийн олон улсын гэрээнд заасан түгээмэл эрхүүд нь зөрчигдсөн, гадаад улсад ял эдэлж байгаа иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр тухайн улс оронд ажиллаж байгаа хүний эрхийн үндэсний байгууллагууд, бүс нутгийн байгууллагуудтай хамтран нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, харилцан ойлголцох, эх оронд нь эргүүлэн авчрах үйл ажиллагааг хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд болон бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж ирсэн байна.

БНСУ-д гэмт хэрэгт холбогдсон болон ял шийтгэл эдэлж байгаа иргэдийн эрхийг хамгаалах, шүүх хуралдаанд ажиглагч оруулахаар Солонгосын Хүний эрхийн комисст хандаж 5 иргэний эрхийг хамгаалуулах ажлыг зохион байгуулсан байна. Монгол Улсаас гадаад орнуудад жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх холбооны БНСУ дахь суурин төлөөлөгчийн газар, Монголын амьдрал ХХК-ийн санхүүжилтээр “БНСУ-д ажиллаж буй Монгол иргэдийн зарим эрхийн хэрэгжилт” сэдэвт тусгай судалгааны ажлыг зохион байгуулсан. Мөн Малайзад амь насаа алдсан иргэн Ш.Алтантуяагийн асуудлаар Малайзын хүний эрхийн байгууллага болон бүсийн байгууллагуудтай хамтран ажиллаж олон улсын хүний эрхийн байгууллагуудын анхаарлыг хандуулсан.

Улсын Их Хурал 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалыг батлан гаргасан бөгөөд уг үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлыг хангах гол чиглэл, арга замыг тодорхойлсон төрийн бодлогын чухал баримт бичиг бөгөөд үүнээс үүдэлтэй аюулгүй байдлын салбар, эрх зүйн орчны өргөн хүрээтэй шинэтгэлийг эхлүүлсэн байна.

Монгол улсын дотоод аюулгүй байдлын үндэс нь хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах явдал юм.

Орчин цагт Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчинд шинэ, олон талт эрсдэл үүсэн бий болсоор байна. Улс, үндэстнүүдийн харилцаа, харилцан хамаарал нэмэгдэж, эдийн засаг, нийгмийн нэгдмэл орчин бий болж, мэдээлэл харилцаа, холбоо хүчтэй хөгжиж, хил хязгааргүй гэхээр шинэ орчин буй болж, хүмүүсийн оюун санаа, амьдралын хэвшилд өөрчлөлт орж байна. Энэ шинэ орчин нь хөгжил, дэвшлийн шинэ боломж нээхээс гадна шинэ аюул, занал, эрсдлийг бий болгож байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Мэдээллийн хэрэгсэл ашиглан хувь хүний нууц, ухамсар, оюун санаанд нөлөөлөх эрсдэл нэмэгдэж байна. Мэдээлэл өөрөө үндэсний нөөц баялаг, улс орны хөгжил, дэвшилд нөлөөлөх чухал хүч болсон тул мэдээллийн орчинд өрсөлдөөн хурцдаж, сөргөлдөөний хэлбэрт шилжиж байна. Мэдээллийн аюулгүй байдал алдагдсан тохиолдолд энэ нь улс орны аюулгүй байдалд нөлөөлөхөөс гадна иргэдийн эрх, эрх чөлөөнд бодит эрсдлийг бий болгоно.

Ийм учраас үндэсний аюулгүй байдлын бүтцэд иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг багтаах нь зайлшгүй асуудал юм.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, хүний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, хууль сахиулах болон төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд хүлээдэг. Гэсэн ч өнөөдөр иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлын тухай ойлголт, цар хүрээ, хангах арга замыг өргөтгөж цогц хэлбэрээр хандах, зөвхөн төрийн байгууллагуудын үүрэг төдийгээр хязгаарлах бус нийгэм, хувь хүний хамтын хүчээр хангах зарчим дээр тулгуурласан шинэ хандлага үгүйлэгдэж байна.

Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал гэж хувь хүн өөрийн хийгээд эх орон, ард түмнийхээ ашиг сонирхлын төлөө биеийн болон оюуны хүч чадавхаа зориулж, түүнийхээ үр шимийг хүртэх тэгш боломж хангагдсан байх, олон улсын гэрээний дагуу хүний эрхийн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүрэг хэрэгжих нөхцөл бүрдсэн байдлыг хэлдэг.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсий Комисс хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад, дотоод хүчин зүйлүүдийг багасгах, тэдгээрээс сэргийлэх чиглэлээр байгуулагдсан цагаасаа хойш ажилладаг.

Тухайлбал, улс орны дотоодод Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон буюу байгуулсан олон улсын гэрээ, конвенцид заагдсан хүний эрх ноцтойгоор зөрчигдөх, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор олгогдсон Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөөг хангахуйц улс төр, эдийн засаг, нийгмийн болон бусад бодит баталгаа алдагдах нөхцөлд Комисс хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аюулгүй байдлын салбар ба хүний эрхийн хамгаалал Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3 дахь хэсэгт "Дотоод аюулгүй байдал"-ыг тодорхойлохдоо хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн" гэж заажээ.

Хүний эрхийг хамгаалах чиг үүрэгтэй төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэнтэй хамтарч иргэдийн хүний эрхийн боловсрол, хүний эрхийн талаарх мэдлэг мэдээллийг түгээх ажлыг чанарын шинэ төвшинд гаргах, хүний эрхийн аливаа зөрчил гажуудалтай тууштай тэмцэх, хүн бүр өөрийнхөө хууль ёсны эрхийн төлөө идэвхтэй тэмцэгч байж чадах нөхцөлийг бүрдүүлэх, хүний эрхийн асуудлаар олон улсын, бүс нутгийн хүрээнд үр өгөөжтэй харилцаа холбоо, итгэлцлийг хөгжүүлэх нь Хүний эрхийн комиссын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл байсаар ирсэн.

Комисс жилд хоёр удаа иргэний нийгмийн байгууллагуудад өөрийн явуулж буй үйл ажиллагааг танилцуулж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр Комиссын явуулсан үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлэлт өгөх боломжийг олгон ажиллаж байна. Түүнчлэн Комиссын дэргэд Монгол Улсад тодорхой эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагуудын 19 төлөөллөөс бүрдсэн комиссын үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл төвлөрөн үйл ажиллагаа явуулж байна.

Иргэдийн эрх, эрх чөлөөний талаарх төрийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг бэхжүүлэх, тэдгээрийг чадавхижуулах үйл ажиллагаа.

- Олон нийтэд чиглэсэн хүний эрхийн тухай мэдээлэл, сурталчилгааг тогтмол явуулж, иргэдийн энэ талаарх мэдлэг, ойлголтын төвшинг дээшлүүлэх
- Төрийн албан хаагч, иргэдэд чиглэсэн бүх төрлийн хүний эрхийн сургалтыг зохион байгуулах
- Хүний эрхийн тулгамдсан асуудлаар олон нийтэд зориулсан лекц тогтмол зохион байгуулах
- Олон нийтийн анхаарлыг татаж буй тодорхой сэдвээр хүний эрхийн ном товхимол, сурталчилгааны хуудас боловсруулж, түгээх
- Олон улсын хүний эрхийн өдрийг жил тутам тэмдэглэх
- Хүний эрхийн асуудлаар улирал тутам радио буюу телевизээр нэг буюу түүнээс дээш удаа нэвтрүүлэг бэлтгэж, цацах
- Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай Комиссын илтгэлийн талаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг явуулах
- Комиссын вэб хуудсын агуулга, мэдээллийн чанарыг сайжруулж, тогтмол шинэчлэн ажиллуулах
- Хүний эрхийн цахим сургалтын кампусыг ажиллуулах
- Орон нутагт “Хүний эрхийн нээлттэй өдөр” цогц арга хэмжээг тогтмол зохион байгуулах
- Хүний эрхийн цахим номын санг ажиллуулах зэрэг болно.

Комиссоос тогтмол зохион байгуулдаг “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээ бол Комиссын гишүүн хуулиар олгогдсон бүрэн эрхээ цогц байдлаар хэрэгжүүлж буй онцлог арга хэмжээ юм.


Уг арга хэмжээний үеэр аймгуудын Цагдаагийн газрын Баривчлах түр саатуулах байр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны Цагдан хорих байрны орчин нөхцөлтэй танилцдаг. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын алба, Засаг даргын тамгын газар, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тахарын алба зэрэг байгууллагын ажилтан, албан хаагчид болон иргэний нийгэм, иргэд, олон нийтийн төлөөлөлтэй уулзалт, ярилцлага тогтмол хийж хэвшсэн.

Хүний эрхийн нээлттэй өдрийг жил бүр тогтсон хугацаанд зохион байгуулдаг уу? Хорих байрны нөхцөлтэй танилцах ажлыг гэнэтийн байдлаар зохион байгуулж байна уу.

Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдөр буюу Хүний эрхийг хамгаалах олон улсын өдрийг жил бүр уламжлал болгон тусгай хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулж хэвшсэн. Энэ өдрөөр улсын хэмжээнд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, олон нийтийн мэдлэг, хандлагыг өөрчлөх тусгай сэдэвт телевизийн нэвтрүүлэг, сонингийн нийтлэл, ярилцлагууд, хүний эрхийн боловсролыг нийтэд түгээх зорилгоор сургалтууд олноор зохион байгуулдаг.

Төвлөрсөн хорих ангиудын шалгалтуудыг улсын хэмжээнд зохион байгуулахдаа төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр зохион байгуулдаг. Төлөвлөгөөт шалгалтыг прокурорын газар эсвэл ШШГЕГ-тай хамтран нэгдсэн удирдамжийн дагуу улсын хэмжээнд тусгай төлөвлөгөөтэйгөөр шалгадаг бол төлөвлөгөөт бус шалгалтыг ХЭҮК-ийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу гомдлын мөрөөр эсвэл гэнэтийн байдлаар удирдамжтайгаар зохион байгуулдаг.


Мөн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж зэрэг эрх зүйн акт хүний эрхийн үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, хууль зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Хууль, хяналтын байгууллагын ажилтнууд болон төрийн захиргааны албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулдаг. “Нээлттэй өдөр” арга хэмжээг өнгөрсөн хугацаанд зохион байгуулсан тоо хэмжээг дараах хүснэгтээс харна уу.



Хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, түүнээс сэргийлэх чиглэлээр гомдол шийдвэрлэх үйл ажиллагаа

Хэрэв аливаа хувь хүний эрхийг зөрчигдөхөөс идэвхитэй хамгаалах үйл ажиллагаа явуулахгүй бол хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хүлээн зөвшөөрөх нь ач холбогдолтой биш. Эрх мэдлийг хэрэгжүүлж буй бүлэг нь хүний эрхийг зөрчсөнөөр удирдлагадаа байгаа хүмүүсийг хараат болгодог бөгөөд томоохон зорилгодоо хүрэх арга замыг нь богиносгодог. Ингэснээр иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал алдагддаг гэж үздэг. Иймд хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлыг үр нөлөөтэй шалгах, шийдвэрлэх замаар хүний эрхийн зөрчлийг арилгах нь иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах гол хэрэгсэл болдог.

Өнгөрсөн хугацаанд хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, түүнээс сэргийлэх чиглэлээр гомдол шийдвэрлэх ажиллагааг Комиссын гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлсээр ирсэн. Комисст хандаж гомдол гаргаж буй иргэдийн тоо жилээс жилд нэмэгдсээр ирсэн бөгөөд иргэдийн хүний эрх, эрх чөлөөний талаарх мэдлэг ойлголт нэмэгдсэн, орон нутагт Комисс ахлах мэргэжилтнээ томилон ажиллуулж байгаа, цахим сайтаар дамжуулан иргэдийн гомдлыг хүлээж авах боломжтой болсон зэргээс шалтгаалж, тоо нь нэмэгдэж байна. Комисс нь 2008-2016 оны эхний 10 сарын байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 3738 гомдол хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд өмнөх жилүүдэд дунджаар 200 орчим гомдол хүлээн авч, шалгаж шийдвэрлэж байсан бол сүүлийн гурван жилд хүлээн авч шийдвэрлэсэн гомдлын тоо 645-710 болж хоёр дахин өссөн үзүүлэлттэй байна.



ХЭҮК-оос аюулгүй байдлын салбарт тавих хяналт (зэвсэгт хүчин, цагдаа, тагнуул, хил хамгаалах алба): экспост, эксантэ болон тогтмол хяналтын чиг үүргүүд, хянан шалгах ажиллагаа, холбогдох мэдээлэлтэй танилцах, өргөдөл гомдол хянан шийдвэрлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих г.м эрх

2008-2015 онуудын голлох үйл явдал

Аюулгүй байдал, хууль сахиулах салбарт хүний эрхийг хангах, ХЭҮК-ын үйл ажиллагаа, чиг үүрэг эрх мэдэлтэй холбоотой зохицуулалт хууль эрх зүйн хүрээнд болон бодит байдал дээр хэрхэн баталгаажсан, үүнийг бодит жишээ, тоо баримтад тулгуурлан олон улсын хэм хэмжээтэй харьцуулж үнэлэх, цаашид анхаарах асуудлуудыг тодорхойлох.

ХЭҮК-ын хуульд аюулгүй байдлын салбарт гүйцэтгэх чиг үүргийн талаар тусгайлсан заалт байхгүй бөгөөд комисс энэ чиг үүргээ Монгол Улсын олон улсын гэрээ болон комиссын хуулийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бүх байгууллагад тэгш оролцооны үндсэн дээр хэрэгжүүлдэг.

Комисс хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явуулдаг бөгөөд төлөвлөгөөт бус хяналт шалгалт нь иргэд болон албан тушаалтан бүлэг хүмүүсээс комисст хандаж гаргасан гомдол болон мэдээллийн үндсэн дээр зохион байгуулагддаг. Хяналт шалгалт явуулахдаа Монгол Улсын олон улсын хууль болон дотоодын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгохоос гадна НҮБ болон түүний харьяа байгууллагуудаас батлан гаргасан ерөнхий зөвлөмж, зарчим, дүрэм, журмуудын заалтыг удирдлага болгодог.

Хүний эрхийн Комиссын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1,4-т зааснаар "...шаардлагатай нотлох баримт, албан бичиг, мэдээллийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах, газар дээр нь танилцах..." гэж заасны дагуу цэргийн болон хуулийн байгууллагуудын улсын нууцтай холбоотой, нууцын жагсаалтад орсон баримт бичгүүдээс бусад баримт бичигтэй шалгалтын явцад танилцах бүрэн эрхтэй байдаг. Гэхдээ шалгалтын явцад бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзсэн тохиолдолд холбогдох хуульд заасан журмын дагуу төрийн байгууллага, хувь хүний нууцтай танилцаж болох хуулийн зохицуулалт нь ХЭҮК-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8-д зааснаар хийгддэг.

Мөн тус хуулийн 17 дугаар зүйлд Комиссын гишүүний гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой бүрэн эрхийг хуульчилж өгсөн байдаг.

2005 оноос эхлэн цэргийн байгууллага болох Зэвсэгт Хүчний Жанжин Штабын харьяа цэргийн анги нэгтгэлүүд, Хил Хамгаалах Ерөнхий Газрын харьяа хилийн цэргийн отрядуудын үйл ажиллагаанд хүний эрхийн байгууллагын шалгалтуудыг анх удаа зохион байгуулсан. Энэ шалгалтын үр дүнд тэнд алба хааж буй хугацаат цэргийн алба хаагч болон цэргийн ангиудын алба хаагч нарын харилцаан дахь хүний эрхийн зөрчлүүдийг анх удаа илрүүлэн гаргасан нь тухайн үед цэргийн байгууллагуудын хувьд хөндлөнгийн хяналт шалгалтыг хийсэн анхны тохиолдол байсан. Мөн тэнд ажиллаж буй офицер, ахлагч нарын хөдөлмөрлөх эрх, тэдний үр хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг шалгаж тодорхой саналуудыг холбогдох байгууллагууд руу тавьж шийдвэрлүүлсэн байна.

Тус шалгалтын хүрээнд цэргийн албан хаагчдын хуульд заасан эрхийн хэрэгжилт, цэргийн байгууллага дахь хүний эрхийн зөрчлүүд, тэр дундаа дүрмийн бус харьцаанаас үүдэн гарч буй үр дагварууд, цэргийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажиллагсдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт, цэргийн албан хаагчдын амьдрах орчин, ахуй нөхцөл, хоол хүнс, хувцасны хангалт, хөдөлмөр хамгааллын байдалд үнэлэлт дүгнэлт өгөв.

Тухайн үед хийсэн шалгалтаар олон тооны зөрчил дутагдал илэрсэн бөгөөд ахлагч, дунд шатны офицерүүдээс хугацаат цэргийн алба хаагч нарт хэрэглэдэг дарамт, шахалт, эрүү шүүлтийн шинж чанартай албадлагын арга хэмжээнүүдийн хэлбэрийг ил болгон гарган тавьж байлаа. Шалгалтад Хил Хамгаалах Ерөнхий Газрын харьяа 5 анги, застав, Зэвсэгт Хүчний Жанжин Штабын харьяа 6 анги нэгтгэлүүд хамрагдаж цэргийн албанд хэрэглэгддэг дэг, эрүү шүүлтийн шинж чанартай олон үйлдлүүдийг илрүүлэн гаргаж таслан зогсоох чиглэлээр ангийн удирдлагуудын цугларалтад танилцуулж, авах арга хэмжээний төслийг удирдах байгууллагууд дээр батлан хэрэгжүүлснээс гадна Хүний Эрхийн Комиссоос УИХ-д өргөн барьдаг “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2007 оны илтгэлийн 1 дүгээр бүлэгт “Цэргийн алба хаагчдын эрхийн хэрэгжилт” гэсэн гарчигтайгаар тусгайлан оруулж УИХ-ын Хууль Зүйн Байнгын хороогоор хэлэлцүүлсэн байна. Мөн тухайн үед эдгээр байгууллагуудад хэрэглэгддэг Монгол Улсын хууль болон түүнийг дагаж гарсан бусад дүрэм журамд дүн шинжилгээ хийж илтгэлд тусгасан байна.

Жишээ нь, шалгалтанд хамрагдсан зэвсэгт хүчний ангиудад алба хааж буй 829 хугацаат цэргийн албан хаагчдаас авсан санал асуулгаар 79.4 хувь нь түрүүч нар, 55.9 хувь нь офицерууд, 53.6 хувь нь ахлагч нар, 38.7 хувь нь байлдагч нар дүрмийн бусаар харьцдаг гэж хариулсан байна. Хилийн цэргийн ангиудын 522 хугацаат цэргийн албан хаагчид санал асуулгад хамрагдсанаас 44.8 хувь нь ахлагч нар, 23.0 хувь нь офицерууд, 10.2 хувь нь түрүүч нар, 22.0 хувь нь байлдагч нар дүрмийн бус харьцдаг гэжээ. Зэвсэгт хүчний цэргийн ангиудын санал асуулгад хамрагдагсдын 32.3 хувь нь зодож, хүч хэрэглэдэг, 33.5 хувь нь айлган сүрдүүлж дарамталдаг, 36.6 хувь нь мөнгө, эд зүйл шаарддаг, Хилийн цэргийн ангиудад 17.6 хувь нь зодож хүч хэрэглэдэг, 17.6 хувь нь айлган сүрдүүлж дарамталдаг, 6.3 хувь нь мөнгө, эд зүйл шаарддаг гэж тус тус хариулсан байна. Зэвсэгт Хүчний Клиникийн Төв Эмнэлэгт 2006 оны эхний 10 сард хэвтэж эмчлүүлсэн хугацаат цэргийн албан хаагчдаас дээд албан тушаалтандаа зодуулж, эмнэлэгт хэвтсэн 12 байлдагч байсан байна. Эдгээр тоо баримтаас харахад цэргийн албан хаагчдыг зодох, дарамтлах, айлган сүрдүүлэх зэргээр хууль, дүрмийн бус хүрээнд харьцах зөрчил багагүй байна гэж үзэх үндэстэй байна² гэж илтгэлд дурдагдсан байна.

Үүнээс хойш тухайн байгууллагуудтай хамтран тодорхой чиглэлийн хүрээнд хүний эрхийг хангах, хамгаалах, хүний эрхийн боловсролыг олгох, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох хяналт шалгалтыг хамтран зохион байгуулах “Санамж бичиг”-ийг тодорхой хугацаанд, тодруулбал 3-5 жилийн хугацаатай байгуулан жил бүр тухайн байгууллагуудтай санамж бичгийн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах жилийн тусгай төлөвлөгөө гарган ажилласан нь цаашид эдгээр байгууллагад иргэний байгууллагууд тэр дундаа хүний эрхийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахад чухал алхам болсон гэж үздэг. Үүний тод жишээ нь, 2011-2015 онуудад Хил Хамгаалах Ерөнхий Газрын харьяа хилийн 7 анги, түүний застав, харуулууд дээр хийсэн шалгалт, 2011-2015 онуудад Зэвсэгт Хүчний Жанжин штабын харьяа 12 цэргийн анги нэгтгэлүүд дээр хийсэн шалгалтууд тэдгээрийн үр дүнг илтгэнэ. Эдгээр анги нэгтгэлүүд дээр хийсэн шалгалтыг 2005 онд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлүүдийн ихэнх хэсэг нь буюу 80 орчим хувь нь арилсан байх бөгөөд тухайн байгууллагуудын удирдлага, албан тушаалтнууд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсооход үйл ажиллагааныхаа болон төсвийнхөө тодорхой хэсгийг чиглүүлж ажиллаж байгаа нь харагдаж байна гэж хүний эрхийн байгууллагын зүгээс үзсэн болно.

Гэсэн хэдий ч цэргийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт, зан харьцаа, ажиллах орчин нөхцөл, сахилгын байрны нөхцөл нь хүний эрхийн зөрчлийг дагуулсаар байна. Сахилга хариуцлага алдсан, ажилтнуудынхаа хөдөлмөрлөх эрхийг зөрчсөн зөрчлүүдэд тухайн тодорхой албан тушаалтанд тооцох хариуцлагын механизм сул, хариуцлага тооцохоосоо илүү дэвшүүлэн ажиллуулдаг гаж тогтолцоо байгааг үгүйсгэхгүй.

Хүний эрхийн комиссоос дээрхи байгууллагуудын үйл ажиллагаанд гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, таслан зогсоох комиссын гишүүний 10 шаардлага, 4 зөвлөмжийг ЗХЖШ-ын харьяа анги, нэгтгэлүүдэд, 5 шаардлага, 5 зөвлөмжийг ХХЕГ-ын удирдлагуудад тус тус хүргүүлсэн. Үүний үр дүнд шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг удирдлагуудын хэмжээнд анхаарч хамтын ажиллагааны тусгай төлөвлөгөө гарган ажиллаж байна. Шаардлага зөвлөмж хүлээн авсан байгууллага шаардлагын хариуг комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т зааснаар 7 хоногийн дотор, зөвлөмжийн хариуг 30 хоногийн дотор авсан арга хэмжээнийхээ талаар бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй байдаг. Хуулийн дагуу ХЭҮК, Комиссын гишүүний шаардлага зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авахаас татгалзсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны талаар хуульд заасан журмын дагуу шүүхэд хандах эрх байдаг.

Хууль сахиулах салбарт явуулсан хүний эрхийн боловсрол, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа (2008-2015)


Нөлөөлөл, сурталчилгааны үйл ажиллагаа

- Хүний эрхийг хамгаалах нөлөөллийн үйл ажиллагааны гол чиглэл нь Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцийг шүүх хуулийн практикт хэрэглэж хэвших, төрийн байгууллагын аль ч салбарт хүний эрхийн мэдрэмжтэй дотоод дүрэм журам баталж хэрэгжүүлэх чиглэлд нөлөөллийн үйл ажиллагаагаа явуулж байна. Хууль хяналтын байгууллагуудад мөрдөж буй дүрэм журамд шалгалтын ажлыг зохион байгуулж хүний эрхийг хангаж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд ШШГЕГ болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй дотоод үйл ажиллагааг зохицуулсан бүх дүрэм журмын заалтыг хүний эрхийн үүднээс судалж УИХ-д комиссоос өргөн барьдаг “Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх удаагийн илтгэлд тусгай бүлэг болгон оруулсан байна.

- 2011 оноос эхлэн төвийн хэвлэл мэдээллийн өдөр тутмын 4 сонинд хүний эрхийн 7 хоног бүрийн сурталчилгааны буланг тогтмол ажиллуулж ирсэн бөгөөд 2016 оноос санхүүжилтгүйн улмаас түр хаагдсан.
- МҮОНТВ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгтэй хүний эрхийн чиглэлээр хамтран ажилладаг.
- 2002 оноос эхлэн хүний эрхийн чиглэлээр судалгааны болон эрдэм шинжилгээний ажлыг хийдэг олон улсын болон дотоодын багш, судлаач нарын хүний эрхийн чиглэлээр хийсэн судалгааны ажил болон бүтээлийг хэвлэн нийтэлдэг “Хүний эрх” сэтгүүлийг жилд 4 удаа тогтмол гаргаж олон нийтэд түгээх ажлыг хийж хэвшсэн боловч 2016 оноос эхлэн санхүүжилтгүйн улмаас энэ онд хоёр удаа хэвлэн түгээлээ.

Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа

- Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4-т зааснаар Комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах үйл ажиллагаа явуулна. Доорх хүснэгтээс өнгөрсөн хугацаанд зохион байгуулсан сургалтын тоон мэдээллийг харж болно.



- Хүний эрхийн боловсролыг бүх нийтэд түгээх үндсэн чиглэлийн хүрээнд хууль хяналтын байгууллагуудад зориулсан сургалтуудыг хуулийн бүх байгууллагуудад тогтмол явуулж хэвшсэн бөгөөд хүний эрхийн чиглэлээр 24 сургалтын гарын авлагыг боловсруулж үйл ажиллагаандаа хэрэглэж байна.
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар хуульч нарын кредит сургалтын багц цаг олгох хөтөлбөрт хүний эрхийн чиглэлээр заавал судлах хичээлийн жагсаалтад 8 сэдвийг оруулан батлуулж, сургалтыг зохион байгуулах ажлыг Хуульчдын Холбоотой хамтран хэрэгжүүлж байна.
- Мөн хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын хүний эрхийг хамгаалагч нар болон их дээд сургуулийн багш нар, эрдэмтэн судлаач нарыг оролцуулсан “Олон нийтийн лекц”-ийг 2012 оноос эхлэн өнөөдрийг хүртэл хүний эрхийн тодорхой сэдвийн хүрээнд жилд 6 удаа зохион байгуулдаг бөгөөд өнөөдрийн байдлаар 29 дэх лекцээ зохион байгуулаад байна.
- Аймаг орон нутгийн хуулийн байгууллагын ажилтнуудад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр сургалтыг бүтэн жилийн хугацаанд Швейцарийн хөгжлийн Агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан. Хуулийн байгууллагуудын өөрсдийн хүсэлтээр 2008-2015 оны хооронд нийт 100 гаруй сургалтыг комисс хийжээ. Каритас Чех олон улсын байгууллагатай хамтран төвлөрсөн 25 хорих ангид хүний эрхийн ойлголтын чиг хандлага, хүний эрхийн боловсролын талаар сургалтыг бүтэн жилийн хугацаанд 2012 онд зохион байгуулсан.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагч нарт болон Хууль сахиулах их сургуулийн сонсогч нарт жил бүрийн хүний эрхийн өдрөөр тусгайлсан хичээлийн хөтөлбөрөөр хүний эрхийн хичээлүүдийг орж хэвшсэн.
- 2005 оноос эхлэн ХСИС-д Хүний эрхийн төвийг ажиллуулж байна.
- Хуулийн бүх байгууллагуудад “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх” сэдвийн хүрээнд 2016 онд 25 сургагч багшийг бэлтгэн ажиллуулж байна.
- 2008-2016 онуудад нийт 468 удаагийн сургалтаар 26164 оролцогч нарыг сургалтад хамруулжээ.


Судалгаа, мониторинг

Хүний эрхийн анхаарал татсан сэдвүүдийн хүрээнд болон цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан комиссын бүрэн эрхийн хүрээнд бусад судалгааны байгууллагуудтай хамтран болон бие даан олон төрлийн судалгааны ажлуудыг хийх хүний нөөцийн болон үйл ажиллагааны чадавхитай болсон байна. Судалгааны хамтрах объектийн хүрээнд хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа болон төрийн, хувийн хэвшлийн аль ч байгууллагуудад тодорхой сэдвийн хүрээнд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэх бүрэн боломжтой. 2009-2015 оны хооронд зөвхөн хуулийн байгууллагын үйл ажиллагаа болон тэдгээртэй холбоотой 12 төрлийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2015 онд л гэхэд Засгийн газрын тогтоол болон хуулиудын шинэчилсэн найруулга нэмэлт өөрчлөлтүүдэд хүний эрхийн чиглэлээр судалгаа хийж нийт 25 удаагийн саналыг Засгийн газар болон холбогдох яамдуудад хүргүүлэн ажиллажээ.


Бодит эрхийн хамгаалал

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх хэсэгт “Комиссын гишүүн гомдлыг шийдвэрлэхдээ аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 2003-2016 онд иргэний зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, гэм хорын хохирлыг арилгуулахаар нийт 30 нэхэмжлэл шүүхэд гаргаж 412 сая 214 мянган төгрөгийн хохирол барагдуулсан бөгөөд 2011 оноос хойш нийт 274 сая 452 мянга 390 төгрөгийн хохирол барагдуулж шийдвэрлүүлсэн байна.




Хууль зүйн зөвөлгөө

Комисс нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хууль зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй үзүүлдэг бөгөөд хууль зүйн зөвлөлгөө авахаар хандсан иргэдийн тоо жилд дунджаар 200-400 орчим байсан бол сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч хууль зүйн зөвлөгөө авч буй иргэдийн тоо 1500 болж гурав дахин өссөн үзүүлэлттэй байна.



Хяналт, шалгалт

Комисс нь 2008-2016 оны эхний 10 сарын байдлаар нийт 452 удаагийн хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллага албан тушаалтанд шаардлага, зөвлөмж хүргүүлж, биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан байна.



Дүгнэлт

Дүгнэлт хэсэгт аюулгүй байдлын салбарын хууль тогтоомжид Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрхийг хангаж ажиллах аль хэр тусгагдсан талаар, ерөнхий нөхцөл байдал ямар байгаа талаар дурдах шаардлагатай.

1. Дотоодын хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх хүрээнд дагаж мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг олон улсын хуульд нийцүүлэн баталж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг.

2. Хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтын талаарх сургалтуудыг байгууллага бүр дээр тасралтгүй, байнгын давтамжтайгаар зохион байгуулах шаардлагатай. Учир нь хууль сахиулах байгууллагууд, цэргийн байгууллагуудын томилгоо ойр ойрхон хугацаанд хийгддэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдсан ажилтнууд өөр газар шилжин ажиллах нь олонтаа тохиолддог.

3. Хүний эрх, тэр дундаа цэргийн байгууллагуудад гарч буй хүний эрхийн зөрчил нь хууль хяналтын байгууллагуудад илэрч байгаа хүний эрхийн зөрчлөөс эрс ялгаатай байдаг тул түүнийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс санхүүгийн бүрэн чадавхитай байх хэрэгтэй. Монгол улс нутаг дэвсгэр томтой, аюулгүй байдлын чиг үүрэг бүхий байгууллагууд тарж байрласан байдагтай холбоотойгоор хүний эрхийн хяналт шалгалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулахад хүндрэлтэй байдаг байна.

4. Тусгай бодлого гарган хүний эрхийн сургагч багш нарыг олноор нь бэлтгэх, тэдэнд зориулан олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн талаарх шинэ мэдээ, мэдээллээр байнга хангаж байх шаардлага байсаар байна.

5. Тухайн байгууллагуудын алба хаагчид, ажилтнуудыг албан тушаал ахих, цол хэргэм нэмэгдэхэд тавигдах шалгуур үзүүлэлтийн нэгэнд хүний эрхийн зөрчил гаргаж байсан эсэх талаар асуулга заавал байх шаардлагатай.

6. Хүний эрхийн зөрчилгүй хамт олныг шалгаруулах, олон нийтэд мэдээллэх сурталчилгааны ажлыг Хүний эрхийн байгууллагуудтайгаа хамтран зохион байгуулж хэвших шаардлагатай байгааг хэлэх хэрэгтэй.

Б. Индра

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАР БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Сэтгүүлзүйн хөгжил Монголд

Хэвлэл мэдээллийн салбар Монголд

Монгол Улсад хэвлэл мэдээллийн салбар үүсч хөгжөөд 100 гаруй жил болж байгаа боловч хараат бус, чөлөөт хэвлэл бий болоод 20 гаруй жил л өнгөрч байна. Монголын анхны олон нийтийн хэвлэл 1913 онд “Шинэ толь” сонин бичиг нэртэй хэвлэгдэн гарч байв. ЗХУ-ын тусламжаар 1934 онд Монгол улс даяар радио өргөн нэвтрүүлгийг албан ёсоор нээсэн бол 1967 онд анхны зурагтын тогтмол нэвтрүүлгийг орон даяар цацаж, үндсэндээ Монголын олон нийтийн мэдээллийн хэрэгслийн систем бүрэлдэн хөгжжээ. Гэхдээ социалист дэглэмийн үед хэвлэл мэдээлэл 100 хувь төрийн мэдэлд байж, төрийн дуу хоолой болж байлаа.

1990 онд Монгол Улс ардчилсан дэглэмд шилжиж, 1990 оны дөрөвдүгээр сарын 8-нд “Ардчилал” сонины анхны дугаар хэвлэгдсэнээр, Монголд чөлөөт ардчилсан хэвлэл хөгжих үндэс суурь болжээ. Улмаар мэдээллийн эрх чөлөө бий болсныг 1992 оны Үндсэн хуулиар баталгаажуулав.⁹⁵

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүлээн зөвшөөрснөөр хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн тогтолцоо бий болж, чөлөөт хэвлэлийн нийгэмд гүйцэтгэх үүрэг шинэчлэгдсэн нь Монгол дахь ардчиллын томоохон ололт байв. (2015 оны байдлаар Монголд 101 сонин, 71 телевиз, 112 вэбсайт ажиллаж байгаа ба МҮОНРТ (телевиз ба радио), МОНЦАМЭ (мэдээллийн агентлаг) хоёр байгууллага төрөөс санхүүжиж бусад нь хувийн хэвшилд хамаарч байна).

Хэвлэл мэдээллийн хууль эрхзүйн орчин

Ардчилсан дэглэмд шилжсэнээс хойш хэвлэл мэдээллийн салбарт холбогдох гол хуулиудыг баталж, эрх зүйн орчин аажим шинэчлэгдэж буй нь одоо хэр үргэлжилсээр байна. “Глоб интернэйшнл” ТББ-ын хийсэн

⁹⁵ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д хүн бүр “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй” хэмээн хуульчлан тунхагласан байдаг. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан нь хүн бүр хууль ёсны дагуу дурын аргаар мэдээлэл хайх, хүлээн авах, дамжуулах, түгээх эрхтэй болжээ.

“Сэтгүүлч ба хууль”⁹⁶ судалгаагаар 230 гаруй хуулийг авч үзэхэд 91-д нь хэвлэл мэдээлэлтэй шууд холбоотой заалтууд байжээ.⁹⁷

Хэдий тийм ч хэвлэл мэдээлэл хөгжин, иргэний нийгэм, олон нийтийг мэдээллээр хангаж, төр, засгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ жинхэнэ ёсоор биелүүлэх гол нөхцөл болсон эрх зүйн механизм, эдийн засгийн орчин хангалттай бус хэвээр байгаа юм.⁹⁸ 1998 онд баталсан Хэвлэлийн эрх чөлөөний хуулиар цагдан хяналтыг (цензур) хориглож, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг төр өмчлөх эрхийг хязгаарласан нь чухал алхам болсон боловч энэ хуулийг төрийн байгууллага ёсчлон биелүүлэхгүй байгаагаас Монголын радио, телевиз урьдын адил Засгийн газраас шууд санхүүжин түүнд үйлчилсээр байна.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд олон нийтэд үйлчлэх статустайгаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэдэлд очсон гэх боловч хэрэг дээрээ төрийн удирдлага, хяналтыг эрхэлдэг засаг даргынхаа хараа хяналт дор ажилласан хуучин уламжлал өөрчлөгдөөгүй байна.

Эрэн сурвалжлах сэтгүүлзүй Монголд

Нийгмийн систем солигдох шилжилтийн үед 1990-ээд оны эхээр зохиолч, сэтгүүлч Ж.Барамсай хуулийн байгууллагын ажилд оршиж байсан ноцтой завхралыг илчилсэн «Шорон дотроос «өшөө авагчид» байдаг юм биш биз?», “Хуульчид өөрсдөө багаа хууллаа” хэмээх цуврал нийтлэл хэвлүүлсэн нь монголын сэтгүүл зүйн түүхэнд эрэн сурвалжлах аргаар бичигдсэн анхны бөгөөд дорвитой бүтээлд тооцогддог. Тэдгээр цуврал материал, ярилцлага олон түмний санаа бодолд хүчтэй нөлөөлж чадсанаар тухайн үед зохиомол хэрэгт холбогдсон олон арван хүнийг цагаатгаж, хуулийн байгууллагын албан тушаалтнууд зохих хариуцлага хүлээж, хууль зүйн салбарт оршиж буй дутагдал доголдлыг арилгах, үйл ажиллагааг нь сайжруулахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн ажээ.⁹⁹

⁹⁶ Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай холбоотой хуулийн заалтууд <http://www.mediacouncil.mn/content/10863.shtml>

⁹⁷ Гол хуулиуд: “Монгол Улсын Үндсэн хууль”, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай”, “Зохиогчийн эрхийн тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх чөлөөний тухай”, “Эрүүгийн хууль”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”, “Төрийн нууцын тухай хууль” гэх мэт.

⁹⁸ “СЭТГҮҮЛЧ БА ХУУЛЬ” ЦУВРАЛ № 03” ГЛОБ ИНТЕРНЕЙШНЛ” ТББ http://www.globeinter.org.mn/old/publications/pub_2_2_08_06.html

⁹⁹ С.Базар: “Эрэн сурвалжлах сэтгүүлзүйн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлүүд, даван туулах арга зам” <http://journalism-edu.mn/investigative/images/xupld/BazarSecond.pdf>

Үүнээс хойш 20 гаруй жил өнгөрсөн ч эрэн сурвалжлах сэтгүүл зүй хангалттай хөгжөөгүйгээр барахгүй, зарим талаар сэтгүүлзүйн либеральчлал гацсан байдалтай байна. Энэ нь дараах хоёр шалтгаантай.

Нэгд, мэдээлэл олж авах хууль эрхзүйн орчин хангалттай бус байгаагаас албан тушаалтан мэдээлэл өгөхөөс татгалздаг, төр засгийн мэдээллийн санд нэвтрэх боломжгүй гаж тогтолцоо үйлчилж байгаагаас эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих, эрэн сурвалжлага хийхэд ихээхэн бэрхшээлтэй байгаа. Ийм нөхцөлд сэтгүүлчид мэдээллийг зүй бусаар олж авч, улмаар шүүхийн өмнө буруудах тохиолдол бишгүй гардаг. Өөрөөр хэлбэл сэтгүүлчид баталгаатай мэдээлэл ба түүнийг олж авахад нотлох баримт бүрдүүлэх явдал бэрхшээлтэй гэсэн үг. Тандалт судалгаагаар “Та бүхэн яагаад эрэн сурвалжилсан томоохон бүтээл хийхгүй байна вэ? гэсэн асуултанд сэтгүүлчдийн 90.25 хувь амь насанд хохирол учирч болзошгүй, 78.90 хувь нь айдас болгоомжлолтой байна, 90.45 хувь нь редакцийн хамгаалалт баталгаагүй, 85.15 хувь нь сэтгүүлч бичлээ ч сөхөгдсөн асуудал цагдаа, хууль, шүүхийн өмнө очоод замхардаг, 85.0 хувь нь гадны болон эзний дарамт шахалт ирдэг хэмээн хариулжээ.¹⁰⁰

Хоёрт, ХМХ-ийн санхүүжилттэй холбоотой. ХМХ төрийн эзэмшилд байхаа больсон ч аль нэг улс төрч, бизнесмений эзэмшилд шилжсэнээр хэвлэл мэдээллийг либеральчлах үйл явц Монголд бараг зогсож гацаанд оржээ. Улс төр, санхүүгийн бүлэглэлүүд хэвлэл мэдээлэлд хүчтэй нөлөөлж, ил далд хөрөнгө оруулалт хийж байгаагийн уршгаар ХМХ эх сурвалжаас ихээхэн хамаарах болж, улмаар хэвлэлийн гол бүтээгдэхүүн болох мэдээ, мэдээлэл эзнээсээ хэтэрхий хамааралтай болж, редакцийн хараат байдал ноёрхож, олон түмэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа байх чадвар алдагдаж эхэлжээ.

Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрх, хязгаарлалтууд

Монгол Улсад иргэдийн мэдээлэл хайх, түгээх эрх Үндсэн хуулиар баталгаажсан ч түүнд нэвтрэн олж авах эрх өнөө хэр хязгаарлагдмал хэвээр байгаа талаар дээр цухас дурдлаа. Монголд сэтгүүлзүйн чиглэлээр “Глоб интернэшнл” ТББ шат дараалсан, дорвитой судалгаа явуулдаг бөгөөд үүний нэг нь 2006 онд хийсэн “Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө” хэмээх судалгаа билээ.

Ардчилсан нийгэмд мэдээллийг чөлөөтэй хүртэх, хязгаарлалтай хүртэх гэсэн ерөнхий хоёр зарчим байдаг. Монголд иргэдийн мэдээлэлтэй

¹⁰⁰ С.Базар: “Эрэн сурвалжлах сэтгүүлзүйн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлүүд, даван туулах арга зам” <http://journalism-edu.mn/investigative/images/xupld/BazarSecond.pdf>

байх эрх, мэдэх эрх төрийн нууц, байгууллагын нууц, хувь хүний нууцын тухай болон бусад олон хууль тогтоомжоор хязгаарлагддаг. Энд төрийн нууцтай холбоотой мэдээлэл авах хязгаарлагдмал байдлын өнөөгийн нөхцлийн талаарх судалгааны дүгнэлтийг танилцуулж байна.

Төрийн нууцын тухай

Монгол Улсад төрийн нууцыг Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалтын тухай хуулиар зохицуулдаг. 1995 онд баталсан Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлд «улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээ, баримт бичиг, бусад зүйлийн нууцалбал зохих хэсэг», «гадаад бодлого, байр суурьтай холбоотой түүнчлэн Монгол Улсаас гадаад орнуудтай байгуулсан нууцалбал зохих гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн төсөл»-ийг төрийн нууцад хамааруулахаар тодорхойлжээ. Түүний дотор батлан хамгаалах хүрээнд 9, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд 4, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд 5 зүйлийг төрийн нууцад хамааруулсан байна. Төрийн нууцын жагсаалтын тухай хуулиар 73 зүйлийг нууцлан хамгаалахаар баталжээ. Төрийн нууцыг хамгаалах тухай хуулийн 3-р бүлгийн 2-р зүйлийн 5-р хэсэгт “Төрийн нууцыг олж авах зорилгоор хайх, бусдад тараахыг хориглоно” гэсэн байна.

Төрийн нууцын жагсаалтыг гаргахдаа үзэл бодлын болон мэдээллийн эрх чөлөөний суурь ач холбогдлыг бататгаагүй бөгөөд нууцын зэрэглэлд хамрагдсан зүйлийн алинд нь ч олон нийтийн хууль ёсны ашиг сонирхлыг харгалзаагүй байна гэх үндэслэл байна. Жишээлбэл: Төрийн нууцын тухай хуулийн 5-р зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол улс болон гадаадын бусад орны хоорондох нууц гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн төслүүд” нууц байхаар заасан тул энэ нь “нууц” гэсэн тэмдэг тавьсан үеэс л нууцын зэрэглэлд хамрагдах бичиг баримт болно. Гэтэл Засгийн газар, гадаад орнуудтай ард олноос нууцлах ямар гэрээ, хэлэлцээр хийсэн болох нь хаана ч тодорхойгүй, зохисгүй билээ.¹⁰¹

“Албан үүргийн хувьд төрийн нууцыг мэдэх ёсгүй этгээд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн нууцыг олж авах зорилгоор хайсан, бусдад задруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлийн 2-т заасан нь хэвлэл мэдээллийнхэнд юуны өмнө хамаарна.

¹⁰¹ “СЭТГҮҮЛЧ БА ХУУЛЬ” ЦУВРАЛ № 03” ГЛОБ ИНТЕРНЕЙШНЛ” ТББ http://www.globeinter.org.mn/old/publications/pub_2_2_08_06.html

“Глоб Интернэшнл” ТББ-ын хийсэн эдгээр судалгаанд үндэслэн одоо үйлчилж, буй төрийн нууцтай холбоотой хуульд дараахь доголдол байна гэж хуульчид үзжээ.

- Төрийн нууцлалын хүрээ туйлын өргөн,
- Нууцын хугацаа хэтэрхий урт,
- Төрийн нууцын жагсаалтын тухай хууль төрийн нууцын хуулиас давсан,
- Төрийн нууцыг задруулсан хүнийг 8 жилээр хорихоор Эрүүгийн хуульд заасан нь “Үндэсний аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах тухай” Йоханнесбургийн зарчимтай харшилж,
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Гадаад Худалдааны арбитрын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль болон бусад олон хуульд янз бүрийн замаар төрийн нууцыг хамгаалах тухай зүйл заалт орсон нь төрийн нууцын тухай ерөнхий хуультай зөрчилдсөн байна.¹⁰²

Төрийн нууц - мэдээллийн хагас нээлттэй байдал - хүний эрх

“Төрийн нууцыг хамгаалах” гэж төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас төрийн нууцыг задруулахгүй байх зорилгоор өөрийн бүрэн эрхийн хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, арга хэрэгслийн цогцолборыг ойлгож байгаа. Төрийн нууцыг хариуцдаг, эсхүл төрийн нууцтай албан үүргийн дагуу танилцсан албан тушаалтан, иргэн төрийн нууцыг задруулах, хувийн зорилгоор ашиглах, төрийн нууцыг олж авах зорилгоор хайж олох, бусдад задруулахыг хориглон хуульчилсан нь нууцын хүрээг хэт өргөн хүрээнд томъёолсон энэ үед мэдээлэл хайсныхаа төлөө хариуцлага хүлээх үндэслэлийг бий болгохоор байгаа.¹⁰³

Үүнээс гадна төрийн нууцыг задруулсан талаарх хэргийг аль шат хүртэл нууц байлгах тухай хуулийн зохицуулалт огт алга. Төрийн нууцтай холбоотой мэдээ мэдээллийг эрэн сурвалжлах эрх хуулиар хязгаарлагдсан атлаа нууц задруулсан хэргийг эцэслэн тогтоогоогүй байхад энэ тухай хэвлэлээр цацах нь хэвлэл мэдээллийг хариуцлагүй харагдуулж байна.

¹⁰² Глоб интернэйшнл ТББ: “Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө”, Улаанбаатар хот, 2006 он, <http://www.globeinter.org.mn/images/upld/1189333442reportm-last.pdf>

¹⁰³ Мөн тэнд

Жишээлбэл, 2015 онд төрийн нууцыг хариуцдаггүй, нууц хадгалах үүрэг хүлээгээгүй төрийн албан хаагчийг төрийн нууц задруулсан хэргээр мөрдөн шалгаж, улмаар хэдэн сар хорьж байцаан, анхан шатны шүүхээр ялласны эцэст давж заалдах шатны шүүхээр хэргийг хэрэгсэхгүй болгожээ. Хэрэв нууцын зэрэглэлтэй материалтай харьцдаггүй албан хаагч мэдээллийг олж авч задруулсан гэж үзвэл тухайн нууцыг хариуцдаг албан тушаалтанд ч хариуцлага алдсан гэдгээр мөн адил холбогдох учиртай. Гэтэл нууцыг хариуцдаг албан тушаалтныг олж тогтоолгүйгээр, нууц мэдээллийг олж авсан гэх албан хаагчид шууд ял төлөвлөж хорьсон нь хүний эрхийг зөрчсөн явдал болно. Мөн нууцын хүрээг хэт өргөн томъёолсноос үүдэн жирийн албан хаагч хохирсон нэг тохиолдол болно.

Шүүхээр эцэслэн шийдвэрлээгүй уг хэргийн талаар 2015 оны 8 дугаар сард “Өнөөдөр” сонины “Шүүхийн танхимаас” буланд нийтэлж, олон нийтэд зарласан. Төрийн нууцтай холбоотой тул тус хэргийн нарийн үйл явцыг хэвлэл мэдээлэл цааш нь эрэн сурвалжилж тодруулах боломжгүй. Үндэсний аюулгүй байдалд бодитой хохирол учруулсан нь үнэн бол давж заалдах шатны шүүхээр эцсийн шийд гартал уг хэргийн талаарх мэдээлэл хаалттай байвал зохино. Гэтэл хэвлэл мэдээлэлд энэ бүх явц хагас нээлттэй буюу анхан шатны шүүхийн шийдвэрийг шууд хэвлэлд цацсан нь хүний эрхийг ноцтой зөрчсөн явдал болов.

Шүүхийн байгууллага аюулгүй байдалтай холбоотой хэргийн талаар хэвлэлд хагас нээлттэй байснаараа хэвлэл мэдээллээр хүний эрхийг зөрчүүлж, хариуцлагагүй үйлдэл хийхэд хүргэсэн. Энэ хэрэгт шүүх байгуулагад хариуцлага тооцох бүтэц механизм алга байна. Магадгүй хэвлэл мэдээлэл өөрсдөө хүний эрхийг зөрчсөн гэдгээ ухамсарлаж, залруулан мэдээллэнэ хэмээн сэтгүүлзүйн ёс зүйд найдах л үлдэж байна.

Дүгнэхэд, төрийн нууцтай холбоотой хэргийн мэдээлэл шүүхийн салбараар дамжин олон нийтэд хагас нээлттэй болж байгаа нь хэвлэл мэдээллийн салбарыг идэвхгүй дамжуулагч болгож байна. Аюулгүй байдлын салбарын мэдээлэл ил тод байхыг хуулиар хязгаарлагдсан энэ хаалттай байдал болон хэвлэл мэдээллийн идэвхгүй дамжуулагч үүрэг ролийн дунд иргэний эрх ашиг хохирч үлдэх ан цав гарчээ. Төрийн нууцтай холбоотой, эрэн сурвалжлах боломжгүй ийм салбарын мэдээлэл хагас нээлттэй байх нь бүрэн хаалттай байхаас ялгаагүй хор уршигтай байна.

Онц байдлын үеийн хэвлэл мэдээлэл ба цензур

Монгол Улсад улс төрийн үймээн самуунаас болж орон даяар онц байдал тогтоосон нэг тохиолдол бий. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр УИХ-ын сонгуулийн дүнг эсэргүүцсэн иргэд жагсаал цуглаан хийж, үймээн самуун дэгдээж, эцэст нь 5 хүний амь нас эрсэдсэн хэрэг гарсан нь ардчилсан тогтолцоог сонгосноос хойших монголын түүхэнд анх удаа олон нийтийг цочроосон, онцгой үйл явдал болж, нийгэмд зөрчилт нөхцөл байдал үүсгэсэн билээ. Энэ онцгой хэрэг явдлын үеэр хэвлэл мэдээллийн гүйцэтгэсэн үүрэг болон төрийн зүгээс тавьсан хяналтын талаар хэвлэлийн мониторинг хийсэн байдаг.¹⁰⁴

7 дугаар сарын 1-ний хэрэг явдлын дараа онц байдал тогтоох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар дөрөв хоногийн хугацаатай МҮОНТ-ээс бусад телевизийн үйл ажиллагааг зогсоон, олон нийтийн радио, телевизэд төрийн цензурыг сэргээн тогтоожээ. Ийнхүү иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллээр үнэн бодит, олон ургальч мэдээлэл хүлээн авах эрх, эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарласан нь Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөө туйлын эмзэг байгааг харуулсан юм.

МҮОНТ, 2008 оны 07 сарын 05 - ны 00:11 - 00:21 цаг, 618 секунд ... Онц байдал цуцлагдлаа. Өнгөрсөн хугацаанд МҮОНТ нь Онц байдлын тухай хуульд захирагдаж Үндэсний Аюулгүй байдлын Шуурхай штабын шууд удирдлаган дор тус штабын мэдээлэлд үндэслэн мэдээллээ дамжуулж байсан ...

7 дугаар сарын 1-ний үйл явдал, түүний дараа үүсч бий болсон зөрчилт нөхцөл байдалтай холбоотой мэдээлэлд телевизийн 11 суваг 709 цагийн эфирийнхээ 107 цаг буюу 15 хувийг зарцуулжээ. Өдөр тутмын сонинууд нийтлэлийн талбайнхаа 12.6 хувийг (118716 см²) 7 дугаар сарын 1-ний үйл явдалтай холбоотой мэдээлэлд зориулжээ. Төрийн хяналттай өдрүүдэд МҮОНТВ-ийн дэлгэцнээ гарсан мэдээллийн эх сурвалжийн 51.1 хувь нь албаны буюу Засгийн газрын төлөөлөл байв. Иргэд 4.1 хувь, төрийн бус байгууллагын төлөөлөл 3.2 хувийг эзэлсэн бол шинжээч, ажиглагч ердөө 0.1 хувьтай байлаа.

Үүссэн нөхцөл байдлын шалтгааны тухай МҮОНТВ-ийн 7 дугаар сарын 1-ний өдөр, онц байдлын үеэр, онц байдал цуцлагдсаны дараах дөрөв хоногийн мэдээлэлд цензур хэрхэн нөлөөлснийг харвал:

¹⁰⁴ "7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг" <http://www.journalism.mn/content/34829.shtml>

Онц байдлын хугацаанд өссөн гол үзүүлэлт: 7 дугаар сарын 1-ний өдөр тухайн нөхцөл байдалд сөрөг хүчин, тухайлбал иргэний эвсэл, БНН, түүний удирдагчид буруутай тухай мэдээлэл хамгийн ихдээ 5.5 хувь эзэлж байсан бол төрийн хяналт дор ажиллаж байсан онц байдлын үед үлэмж нэмэгдэн дээд тал нь 22.6 хувьд хүрсэн байна. Мөн Ийгл телевиз турхирч байгаа тухай мэдээлэл гарч, 6.3 хувийг эзэлжээ.

Онц байдлын хугацаанд буурсан гол үзүүлэлт: 7 дугаар сарын 1-ний өдөр үүссэн нөхцөл байдлын шалтгааныг МАХН сонгууль будлиантуулсан (25.3%)-ны үр дагавар, Ардчилсан намын дарга Ц.Элбэгдоржийн турхиралтаас (14.4%) болсон гэсэн тайлбар зонхилж байсан бол онц байдлын үеэр хэд дахин буурч, онц байдал цуцлагдсаны дараа МАХН-ыг буруутгасан мэдээлэл давамгайлж, дараа нь сонгуулийн үр дүн нийгмийн хүлээлттэй зөрчилдсөн тухай тайлбар 10.4 хувийг эзэлжээ.

Энэ хэрэг явдлаас үүдэн цагдаа гэмтэж бэртсэн тухай мэдээлэл 18.6 хувь эзэлжээ. Соёлын өв шатсан (14.5%), хүний амь эрсэдсэн (11.2%) тухай мэдээлэл орсон байна.

Үүнээс гадна Монголын ХМХ хүний эрхийг хамгаалах чиглэлээр дагаж мөрдөх соёл, журам дүрэмгүй учир 7 дугаар сарын 1-ний өдөр, түүний дараа хүний эрхийг зөрчих явдал гарчээ. Телевизүүд шууд сурвалжлага хийх, ярилцлага хийхдээ гэрч, хохирогсдын нүүрийг нууцлах, дуу хоолойг нь өөрчлөх зэрэг хувиргалтын арга ашигласангүй. Энэ нь ЦЕГ-ын албадлага, шаардлагаар телевизийн сувгуудаас авсан үйл явдлын бичлэгийг сэжигтэн, баривчлагсдын эсрэг ашиглах боломж олгосон байна. Телевизийн сэтгүүлчид цагдааг нотлох баримтаар хангах гэж бус олон нийтийг мэдээллээр хангах гэж үйл явдлыг сурвалжилдаг билээ.

Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу онц байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад МҮОНТВ-ээс бусад телевизийн үйл ажиллагааг зогсоож, МҮОНТВ-ийн мэдээллийн агуулгад цензур тогтоосон нь Олон нийтийн радио телевизийн тухай хуулийг зөрчиж, 1995 оны Онц байдлын тухай хуулийн хуучинсаг заалтыг хэтрүүлэн хэрэглэсэн гэж хэвлэлийн мониторингид үзжээ. Ингээд холбогдох зөвлөмжүүдийг гаргаж УИХ, ХМХ, сэтгүүлчдийн мэргэжлийн холбоодод өгсөн байна.¹⁰⁵

¹⁰⁵ “7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг” <http://www.journalism.mn/content/34829.shtml>

Зэвсэгт хүчин ба хэвлэл мэдээлэл

Монгол Улсад “Зэвсэгт хүчин иргэний хяналтад байх” талаар хуульчилж заасан. Зэвсэгт хүчний тухай Монгол Улсын хуулийн 11.2-т “Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь төрийн хууль тогтоомжийн биелэлт, Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн удирдлагын үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтыг нээлттэй, ил тод хянах үйл ажиллагаа мөн” гэж заажээ.

Зэвсэгт хүчний төсвийн санхүүжилтийг Сангийн яам хянаж, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороогоор хэлэлцэж УИХ-аар батлуулдаг нь зэвсэгт хүчинд тавьж буй иргэний хяналтын нэг хэлбэр болно. Зэвсэгт хүчний төсвийн зарцуулалтад тавих хяналт “Шилэн дансны тухай” хуулиар хэрэгждэг ба иргэд www.shilendans.gov.mn/org/5296 хаягаар орж төсвийн зарцуулалтыг хөтөлж буй эсэхийг хянах боломжтой.

Хэрэв батлан хамгаалах салбарын төсвийн зарцуулалтад асуудал үүссэн гэж үзвэл хэвлэл мэдээллийн зүгээс эрэн сурвалжлах замаар хяналт тавих эрх хязгаарлагдмал хүрээнд нээлттэй. Хязгаарлагдмал хүрээнд гэдэг нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн 3.2-т Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуулын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад энэ хууль үйлчлэхгүй гэсэн заалтаар мэдээлэл олж авах эрх хязгаарлагдаж буйг хэлж байна. Тэгэхээр хэвлэл мэдээллийн салбар хуулийн энэ хязгаарлалт болон ил тод байдал хоёрын дунд тэнцвэр барьж ажиллах шаардлагатай.

Магадгүй энэ тэнцвэрийг барих нь туйлын төвөгтэй учраас хэвлэл мэдээллийнхэн бодит байдал дээр гүнзгий сонирхдоггүй. Батлан хамгаалах салбарын төсвийн зарцуулалт будлиантаж, Авлигатай тэмцэх газраар шалгагдах үед л сая сонирхож мэдээллэдэг жишээ бий. Монголд эрэн сурвалжлах сэтгүүл зүй сайн хөгжөөгүй байгаатай холбоотойгоор энэ мэт асуудалд хэвлэл мэдээллийнхэн хяналт тавих үүргээ гүйцэтгэж чадахгүй, гагцхүү идэвхгүй дамжуулагч төдий үүрэгтэй байна.

Батлан хамгаалах яамны харьяанд “Дуулга” студи ажилладаг ба энэхүү өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үйл ажиллагаагаа сурталчилж байгаа нь тус салбарын дуу хоолой болохоос хяналт болж чадахгүй юм.

Дүгнэлт

Хууль эрхзүйн орчны нөлөө: Аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагууд мэргэжлийн шаардлагаар олон нийтэд бүрэн нээлттэй ил тод байх боломжгүй энэ байдлаа ашиглан хүний эрх, олон нийтийн эрх ашгийг хохироосон шийдвэрийг далдуур гаргах эрсдэлтэй учраас ХМХ-үүд үүнд хяналт тавих ёстой боловч Монголын өнөөгийн хууль эрхзүйн боловсронгуй бус орчинд энэ үүргээ хангалттай гүйцэтгэж чадахгүй байна.

Хууль эрхзүйн орчныг сайжруулах чиглэлээр Монголын ТББ-ууд дангаар болон олон улсын байгууллагуудтай хамтран судалгаа хийж, сургалт явуулж, холбогдох байгууллагуудад зөвлөмж өгдөг. Ерөнхийдөө хууль эрхзүйн шинэчлэлт аажим боловч тасралтгүй хийгдсээр байгаа, хууль эрхзүйн орчин бүрэлдэн боловсронгуй болох явц үргэлжилсээр буй.

ХМХ-ийн санхүүжилтийн нөлөө: Сэтгүүлзүйн либеральчлал, эрэн сурвалжлах сэтгүүлзүй Монголд сайн хөгжөөгүйгээс хагас хаалттай байдаг аюулгүй байдлын салбар дахь олон нийтийн “нүд чих” ажиллаж чадахгүй байна. ХМХ улс төр, бизнесийн бүлэглэлүүдээс санхүүгийн шууд хараат учраас эздийнхээ эрх ашгийг хамгаалахад голлон ажилладаг. Энэ дунд олон нийтийн эрх ашгийг хамгаалсан мэдээлэл сугарч хоцордог.

ISBN 99978-806-0-9



AURUC
PUBLISHING